

П.Одсүрэн, С.Амарсайхан, Ч.Жачин,
Т.Мөнхнаран, Г.Нандинбилиг, Д.Цогзолмаа

УРАН ЗОХИОЛ

VI

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
6 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын
Яамны зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

ННА 74,2
ДАА 373
А-618

Уран зохиол VI: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 6 дугаар ангийн сурах бичиг /Одсүрэн П., ба бусад; Ред С.Дулам, Тех. Ред Р.Нямцэрэн УБ. 2018, 96х

Азийн Хөгжлийн банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99978-61-93-1

ГАРЧИГ

Нэгдүгээр бүлэг.

МОНГОЛ ДОМОГ, ҮЛГЭР

МОНГОЛ ДОМОГ

Ертөнцийн үүслийн домог6

Дэлхий анх тогтсон нь

Амьтан ургамлын домог 9

Тэмээ үнсэнд хөрвөөх болсны учир

Соёлын үүслийн домог 12

Хуур хөгжим үүссэн нь

МОНГОЛ ҮЛГЭР

Амьтны үлгэр..... 15

Аргат улаан үнэг

Шидэт үлгэр 17

Хааны хүү Гомбо, харцын хүү Гонгор

Аж байдлын үлгэр 20

Арсландай мэргэн хаан

Хоёрдугаар бүлэг.

МОНГОЛ ЯРУУ НАЙРАГ

АМАН ЯРУУ НАЙРАГ

Зугаа үг, үгэн наадам 26

Хэл зүгшрүүлэх үг 26

Ес хэлэлцэх үг 27

Цэц булаалдах үг 28

Зүйр цэцэн үг 29

Онъсого 31

Дайралцах үг 34

ШҮЛЭГ

Данзанравжаа37

Гурван сүлжээ сургаал

Хуульч Сандаг38

Салхинд хийссэн хамхуулын хэлсэн үг

Дашдоржийн Нацагдорж39

Миний эжий

Пунцагийн Бадарч40

Есөн эрдэнийн орон

Жамбын Дашдондог43

Аранзал зээрд

Сэндэнжавын Дулам45

Нүүдлийн цай

Загдын Түмэнжаргал46

Монголын тал нутаг

Гуравдугаар бүлэг.

МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ

ӨГҮҮЛЛЭГ

Пүрэвийн Хорлоо 52

Алт, Мөнгө хоёр

Данигайн Давааням 55

Зүрх цагаан

Чадраабалын Лодойдамба 57

Шаргачин

Лувсангийн Одончимэд 64

Хүүхдийн бор

ТУУЖ

Лодонгийн Түдэв 72

Хорвоотой танилцсан түүх

Зурагтай танилцсан минь

Дөрөвдүгээр бүлэг.

ДЭЛХИЙН УРАН ЗОХИОЛ

ҮЛГЭР

Лакшмийн соёрхол 78

Шидэт бийр 81

Ас-Синдбад хааны үлгэр 84

ӨГҮҮЛЛЭГ

Лев Николаевич Толстой 85

Шударга шүүгч

Оскар Уайлд 88

Тосгоны овгор

Кейко Тани..... 90

Цаасан онгоцны үлгэр

Изобел Финн..... 94

Маш залхуу цох

ҮГИЙН ТАЙЛБАР 95

СУРАХ БИЧГИЙН АГУУЛГА

Ерөнхий чадвар	Суралцахуйн зорилт	Бүлэг							
		I		II		III		IV	
		Монгол домог, үлгэр		Монгол яруу найраг		Монголын уран зохиол		Дэлхийн уран зохиол	
	Монгол домог	Монгол үлгэр	Аман яруу найраг	Шүлэг	Өгүүллэг	Тууж	Үлгэр	Өгүүллэг	
Унших	Зохиолыг мэдэрч ойлгох	+	+	+	+	+	+	+	+
	Зохиолчийн үг сонголтын шалтгааныг тайлбарлах	+	+	+	+	+		+	+
	Өгүүлэгдэхүүнийг ялгах	+	+			+	+	+	+
	Сэдэв, гол санааг тайлбарлаж, үзэл бодлоо илэрхийлэх	+	+	+	+	+		+	+
	Дүрийн үг, үйлдлээс зорилгыг тодорхойлох	+	+			+	+	+	+
	Орон ба цагийн дүрслэлээр орчныг ялган таних	+	+			+			
	Уран дүрслэлийг тайлбарлах	+	+	+	+	+			
Сонсох-ярих	Зохиолын үйл явдлыг өөрийн үгээр ойлгомжтой ярих		+			+			
	Шүлэг зохиолоос сонгон цээжилж, дуу хоолойн өнгө, айзам, хэмнэлийг тохируулан уран унших				+				
	Зохиолын гол санааг алдагдуулахгүй үйл явдлыг товчилж бичих		+			+			
Бичих	Уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичих								+
	Шүлэглэсэн зохиолын хэлбэрийг дуурайн бичих				+				

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЭЗЭМШИХ ЧАДВАР:

УНШИХ ЧАДВАР

- Зохиолыг мэдэрч ойлгох, үг сонголтын шалтгааныг тайлбарлах
- Өгүүлэгдэхүүнийг ялган таних
- Сэдэв, гол санааг тайлбарлаж, үзэл бодлоо илэрхийлэх
- Дүрийн үг үйлдлээс зорилгыг тодорхойлох
- Орчны дүрслэлийг тайлбарлах
- Уран дүрслэлийг тайлбарлах

ЯРИХ-СОНСОХ ЧАДВАР

- Зохиолын үйл явдлыг өөрийн үгээр ойлгомжтой ярих

БИЧИХ ЧАДВАР

- Зохиолын гол санааг алдагдуулахгүйгээр үйл явдлыг товчилж бичих

МОНГОЛ ДОМОГ, ҮЛГЭР



МОНГОЛ ДОМОГ



Унших чадвараа хөгжүүлэе

ЕРТӨНЦИЙН ҮҮСЛИЙН ДОМОГ

Уншихын өмнө

- Үлгэр домгийг сонирхолтой, зугаатай болгодог гол зүйл бол уран сэтгэмж юм. Дэлхий ертөнцийн үүслийг тайлбарласан дараах эртний домгийг уншихдаа домгийг зугаатай сонирхолтой болгож байгаа уран сэтгэмжийн зүйлсийг ажиглаарай.
- Уншихын өмнө дараах домог зүйн дүрүүдтэй танилцана уу.

Дүрүүд	Тайлбар
Хурмаст тэнгэр	Бүх тэнгэр нарын ахлагч, Монгол домог зүйн дүр
Шагжамуни	Энэ галавын эзэн, Буддын домог зүйн дүр
Матар мэлхий	Өнгөрсөн галавын амьтан болох аварга яст мэлхий

1. Үгийн утгыг тайлбарлахдаа 27 дугаар хуудасны бүдүүвчийг хэрэглээрэй.

ДЭЛХИЙ АНХ ТОГТСОН НЬ

(Домог)

Эрт урьд цагт гэнэ. Шагжамуни анхны хүсэл сэтгэлчлэн бүтсэнд туйлын их баярлаж байжээ. Хурмаст тэнгэр: “Доод газар дээр юу болж байна?” гэж асуусанд “Эзэн минь, тэнд газар гэх юмгүй, уснаас өөр юу ч үгүй” гэжээ. “Тэгвэл чи дөрвөн далай хаана байгааг ялгаж мэдэх үү?” гэхэд “Мэднэ” гэжээ. “Мэдвэл энэ шар шороог аваад дөрвөн далайн хамгийн ахмад зүүн далайн тэг дунд нь шидчихээд, харж хүлээж бай. Тэгтэл аяндаа сүүнд өрөм тогтож байгаа юм шиг газар дэлхий биежээд ирнэ” гэж хэлээд, нэг түмэн зүйлийн эрдэнээс бүтсэн бөөрөнхий шар шороо өгч гэнэ.

Тэр шороог нь аваачаад, хэлсэн ёсоор нь дөрвөн далайн ахмад зүүн далайн тэг дунд нь шидчихээд, хэчнээн харсан боловч юу ч алга л байна гэнэ. Тэгсэн тэр нь илбийн нүдээр харагдахаас биш энгийн нүдэнд үл үзэгдэнэ гэнэ. Сайн ажаад үзвэл үнэхээр сүүнд өрөм тогтож байгаа юм шиг бүрэлдэж байжээ.

Гэтэл Матар мэлхий нөгөө шороог нь яг элгэндээ тэврээд салахгүй байна гэнэ... Тэгэхлээр нь Хөхдэй мэргэнд ирж хэлсэнд Хөхдэй мэргэн тэр мэлхийг харважээ. Яг хөндий цээж рүү нь онилж байгаад харватал тэр мэлхий айж цочихдоо, нэг эргээд толгой нь урагшаа хараад унаж гэнэ. Тэгсэн мэлхийн толгой нь урагшаа хандаж, амнаас нь гал гараад, араас нь шээс гараад үхэж гэнэ. Иймд баруун талаас харвасан сум мөн төмөр зэвээрээ баруун тийшээ хараад унасан тул баруун зүгийг цагаан төмөр зүг, модон иш нь зүүн тийшээ харсан тул зүүн зүгийг хөх модон зүг, хойд зүгийг хар усан зүг, урд зүгийг улаан гал зүг гэж нэрлэсэн учиртай юм гэнэ. Элгэндээ тэвэрч байсан шар шороо нь төв дунд мандсаны учир шар шороон зүг болжээ.

(Dulam S., Vacek J. A Mongolian mythological text. Prague: Charles University, 1983, 152 p. Шаракшинова Н.О. Мифы бурят. Иркутск, 1980, 167 с)

Дүрийн үг үйлдлээс зорилгыг тодорхойлох

1. Домогт ямар баатрууд гарч байна вэ? Хэн нь хэндээ тушааж, даалгаж байгааг ажиглан, дүрүүдийг эрх мэдлийн зэргээр жагсаана уу.

Хурмаст


2. Домгийн баатруудын хэлсэн үг, хийсэн үйлдлийг бүртгэн бичнэ үү.

Дүрүүд	Хэлсэн үг	Хийсэн үйлдэл	Зорилго нь юу байв?
Хурмаст			
Шагжамуни			
.....			

3. Домгийн гол баатар хэн бэ? Гол баатрыг ялган танихын тулд дараах асуултад хариулж бичээрэй.
- А. Дэлхийг бүтээх тухай анхны санаа, шийдвэрийг хэн гаргасан бэ?
 Б. Тэрхүү санааг нь хэн дэмжиж, үйл хэрэг болгосон бэ?
 В. Дэлхийг бүтээх үйл хэргийг бүтээхэд саад учруулах гэсэн ямар нэгэн баатрыг домогт үзүүлж байна уу?
4. Домгийн баатруудын зөрчилдөх шалтгаан нь юу вэ?
5. Эртний домогт гарч буй бурхдын дүрийг та нар хэрхэн төсөөлж байна вэ? Хурмаст тэнгэр ба Шагжамунийн талаарх төсөөллөө илэрхийлнэ үү. Тэдгээр дүрийн зорилго юу байна вэ?

Орчныг ялгах

1. Домгийн эхний цогцолборыг дахин уншина уу. Дэлхий ертөнц үүсэхээс өмнөх болон үүссэний дараах төлөв байдлыг хэрхэн үзүүлсэн байна вэ?
2. Эртний домгийн орон, цагийг та нар хэрхэн төсөөлж байна вэ? Домогт үзүүлсэн шиг газар шороо гэж үгүй, нэл их усан далай байсан бол амьдрал ямар байхыг та нар төсөөлж байна уу?
3. Домгоос зүг чиг, байрлал заасан үгсийг нөхөн тэмдэглээд, домгийн орныг зураглан үзүүлнэ үү. Ертөнцийн зүг чигийг өнгө, махбодоор хэрхэн нэрлэж буйг бүдүүвч зургаар үзүүлэн, гэрийнхэндээ тайлбарлаж өгөөрэй.



Өгүүлэгдэхүүнийг ялгах

1. “Дэлхий анх тогтсон нь” домогт энэ дэлхийг хэрхэн үүссэн гэж үзүүлсэн байна вэ? Домгийн хэрэг явдлын эхлэл, өрнөл, төгсгөл хэсгийг тодорхойлно уу. Үүний тулд дараах асуултад хариулж бичээрэй.
- А. Хэрэг явдал хэрхэн эхэлсэн бэ?
 Б. Тэрхүү үйл хэргийг бүтээх замд ямар саад бэрхшээл тулгарсан бэ?
 В. Тэд саад бэрхшээлийг хэрхэн даван туулсан бэ? Тэдэнд хэн тусалсан бэ?

Уран дүрслэлийг тайлбарлах

1. Домгийн бичвэрээс уран дүрслэлийн жишээг түүж бичээд, утгыг тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
сүүнд өрөм тогтож байгаа юм шиг...	
илбийн нүдээр...	

Зохиолын сэдэв, гол санааг тайлбарлах

1. Дэлхий анх үүссэн тухай домгийн уран сэтгэмжийг ярилцана уу. Домгийн уран сэтгэмж ёсоор дэлхийг хэн бүтээсэн байна вэ?
2. Энэхүү дэлхийг бурхад бүтээсэн хэмээн тайлбарлах эртний домгийн уран сэтгэмжийн цаана ямар санаа оршиж байна вэ? Тус домогт ямар зүй тогтлыг хэрхэн тайлбарлаж байна вэ?
3. Газар дэлхий хэрхэн бүрэлдэн тогтсон талаарх шинжлэх ухааны тайлбарыг судалж, домгийн уран сэтгэмжтэй харьцуулан хэлэлцэнэ үү.

Домгийн мэдлэгээ ашиглан, шагайгаар “Алаг мэлхий” өрж наадаарай.



Тайлбар. *Ертөнцийн үүслийн тухай домгийн яст мэлхийн дүр нь Монголчуудын хувьд дэлхий ертөнцийн загвар, урт нас, бат бэхийн бэлгэдэл болжээ.*

Яст мэлхийн дүр монгол ёс заншилд уламжлан ирсний нэгэн жишээ бол цагаан сарын битүүний үдэш хотлоороо нааддаг “Алаг мэлхий” шагайн наадам билээ.

1-р шат. Алаг мэлхий өрөх

- гурван **хар** шагайгаар **хойд** зүг буюу алаг мэлхийн шээсээр **усыг**,
- дөрвөн **улаан** шагайгаар **өмнө** зүг харсан мэлхийн хэл буюу амьсгалаар **галыг**,
- таван **хөх** юм уу ногоон шагайгаар **зүүн** гар талаас нь цухуйж буй сумны гичрээр **модыг**,
- тав тав, зургаа зургаан шар шагайгаар **шороо, уул, огторгуй, салхи** дөрвийг,
- хоёр **цагаан** шагайгаар **баруун** гар талаас нь цухуйж байгаа сумны **төмөр** зэвийг тус тус орлуулан дүрсэлж өрнө. Энэ мэтчилэн 128 шагайны 92-оор яст мэлхийн толгой, хүзүү, нуруу, шилбэ, сарвуу, нүд, чих, бөөр, зүрх, давсаг, хамар, хошууг дүрсэлнэ.

2-р шат. Дөрвөн бэрх орхиж наадах

- хоёр нүх буувал модыг буюу шороо, уул хоёрын нэгийг,
- зургаан нүх буувал салхи, огторгуй хоёрын нэгийг,
- гурван нүх буувал усыг,
- дөрвөн нүх буувал мэлхийн хэл (амьсгал)-ийг авна.

Дараагийн орхилтоороо мэлхийн бие эрхтнээс авч наадна. Тухайлбал

- нэг нүх буувал зүрх, давсгийн нэгийг,
- хоёр нүх буувал нүд, чих, бөөр, хамар, хошуу, хүзүүний үсний аль нэгийг,
- гурван нүх буувал толгойг,
- дөрвөн нүх буувал 4 шилбэний аль нэгийг,
- таван нүх буувал сарвууны аль нэгийг,
- зургаан нүх буувал зургаан нурууны аль нэг буюу хүзүүний зургаан шагайг тус тус авна.

АМЬТАН, УРГАМЛЫН ДОМОГ

Уншихын өмнө

- Хүүхдүүд ээ! Дараах зурагт юуг дүрслэн үзүүлсэн байна вэ? Орчны зураглалд байгалийн ямар дүрийг тодотгож, ямар өнгө зохистой үзүүлсэн байна вэ?
- “Эрдэнийн зүйлээр бөөлжөөд байдаг эрүү цагаан хулгана нэгэн жил ээ” гэж эхлээд арван хоёр жилийн амьтдыг тус бүрд нь магтан дуулдаг магтаалыг санаж байна уу? Цээжилснээ хэлээрэй.



П.Батжав. Тэмээ.
Арьсан урлал

ТЭМЭЭ ҮНСЭНД ХӨРВӨӨХ БОЛСНЫ УЧИР

(Домог)

Урьд цагт монгол литийн арван хоёр жилд адгуусан амьтдын нэр өгч байхдаа Бурхан арван нэгэн амьтны нэрсийг шулуухан тохоогоод, “Арван хоёр жилийн хамгийн эхний жилд ямар амьтны нэр өгөх вэ?” гэтэл тэмээ хулгана хоёр нэрээ оруулж, арван хоёр жилд багтахаар булаалджээ. Бурхан аль алиныг гомдоохгүйн тулд “Өөрсдөө шийд” гэж айлджээ.

Тэр хоёр маргааш өглөөний мандах нарны туяаг хэн түрүүлж үзсэн нь арван хоёр жилийн түрүүчид тохоогдохоор болж, мэлзээ тогтоосон ажээ. Тэмээ нар гарах дорно зүг харж, нар гарахыг хүлээж зогсов. Хулгана тэмээний бөхөн дээр гарч, баруун зүг харан, цаг ямагт уулын оройг ширтэж байв. Тэгж байтал нар гарах цаг болж, ургах нарны анхны туяа баруун уулын оройд туссанд хулгана нарны гэрлийг түрүүлж хараад, “Нар гарлаа” гэж хашхирчээ. Тэмээ мэлзээгээ алдсандаа уурлан, хулганыг дэвсэж алах гэж ухасхийтэл хулгана овоолоостой үнсэн доогуур гүйн орж, амь хоргодож гэнэ. Тэр цагаас хойш тэмээ үнс асгасан газар харагдах бүрд өнөөх өстөн дайсан хулганыг бяц дарах санаатай үнсийг дэвсэлж, хөрвөөдөг болсон гэнэ.

Ингээд хулгана арван хоёр жилд багтаж, тэмээ хасагдах болсон гэнэ. Тэмээ арван хоёр жилд багтаагүй боловч арван хоёр жилд багтсан бүх амьтны шинжийг цөмийг биедээ агуулсан байдаг гэнэ. Уг шинж нь:


Хулгана чихтэй
Үхэр гэдэстэй
Бар тавагтай
Туулай хамартай
Луу биетэй
Могой нүдтэй
Морин дэлтэй
Хонин ноостой
Бичин бөхтэй
Тахиа өрөвлөгтэй
Нохой гуятай
Гахай сүүлтэй гэнэ.

(Монгол ардын үлгэр. УБ., 1982, 35 дугаар тал)

Сэдэв, гол санааг тайлбарлах

1. Мандах нарны туяаг уралдаж харсан нэгний арван хоёр жилд орох энэ мэлзээ нь та нарын бодлоор хэр шударга арга байсан бэ? Таны бодлоор тэмээ хулганатай мэлзээ тогтоохдоо юуг дутуу бодсон бэ?
2. Домгийн арван хоёр жилийг ертөнцийн үүслийн домгоос танин мэдсэн таван махбодоор үржүүлбэл ямар тоо гарах вэ?
12 x 5 =?


Дорно дахины ард түмэн жарны тоололтой. Жарны тоолол ёсоор монголчууд цагаан сарын баяр буюу жилийн эхний өдрийг тэмдэглэж, өвөө эмээ, аав ээж, ахан дүүстэйгээ золгон баярладаг уламжлалтай. Загвар үзүүлэнг харьцуулан ажиглаж, жарны тооллын зүй тогтлыг тодруулна уу.



3. Хойт хар усан зүгт арван хоёр жилийн ямар амьтан байрлаж байна вэ? Тойргийг монгол гэрийн орон зай гэж төсөөлөөд, хойт зүгээс эхлэн, нар зөв тойруулан арван хоёр жилийн амьтад гэрийн аль зүгт байрлаж байгааг нэрлэнэ үү.
4. Энэхүү домгоор дамжуулж өвөг дээдэс маань хойч үедээ юуг мэдүүлэхийг зорьсон гэж бодож байна вэ? Домгийн гол санааг эргэцүүлэн хэлэлцэнэ үү.

Өгүүлэгдэхүүнийг ялгах

1. “Тэмээ үнсэнд хөрвөөх болсны учир” домгийн хэрэг явдлын эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялгана уу. Ялгахдаа:



2. Домгийн хэрэг явдал хэрхэн эхэлсэн бэ? Хэрэг явдлын шалтгаан болсон гол зөрчлийг тодорхойлно уу.

Үзэл бодлоо илэрхийлэх


1. Хэрвээ та нар тэмээний оронд байсан бол мэлзээ тогтоохдоо чухам юуг нарийвчлан тохиролцох байсан бэ?
2. Хулганад ялагдсан тэмээний домгоос та нар юуг тусган авч байна вэ?
3. Хулгана тэмээний бөхөн дээр баруун зүг харж байхдаа юу бодсон бол? Харин тэмээ дорно зүг харж байхдаа юу бодсон бол? Алиных нь бодол зөв байсан бэ?

Дүрийн үг, үйлдлээс зорилгыг тодорхойлох

1. Сонгон ажиллана уу.

Дүрийн зан төрхийг тодорхойлох Хосоороо ажиллах дасгал	Дүрийн зорилгыг тодорхойлох Багаараа ажиллах дасгал
Сонгосон дүр	Сонгосон дүр
Дүрийн дотоод бодол, хэлсэн үг нь юу байв?	Дүрийн зорилго
Дүрийн хийсэн үйлдэл нь юу байв?	Зорилгодоо хэрхэн хүрэв?
Дүрийн бодол, хэлсэн үг, хийсэн үйлдлээс зан төрхийг тодорхойлоорой.	Зорилгодоо хүрэх арга нь зөв байсан эсэхийг дүгнээрэй.

2. Сорилт мэлзээний өмнө тулгарсан тэмээ хулгана хоёрын адил болон ялгаатай талыг тодруулна уу. Тэд ямар шинжээрээ хэрхэн эсрэгцэж байна вэ?



3. Тэмээ хулганад мэлзээгээ алдсанаар домогт үзүүлсэн нь тэмээний ямар шинжийг тодруулж үзүүлэх зорилготой вэ? Хулгана тэмээ хоёрын гаргаж буй зан чанарыг харьцуулна уу. Тэмээнд ямар зан чанар дутсанаас арван хоёр жилд багтаагүй вэ?

Дүрүүд	Илрүүлж буй зан чанар	Дутагдаж буй зан чанар
Тэмээ		
Хулгана		

4. Энэ домогт Бурханы дүр ямар үүрэгтэй гарч байна вэ? Түүний шийдвэрийг шүүн хэлэлцэнэ үү.

Орон цагийн дүрслэлээр орчныг ялгах

1. Мандах нарыг түрүүлж харах мэлзээ болж буй орон болон цагийн талаар та нар хэрхэн төсөөлж байна вэ?
2. Домгийн цагийн утгатай үгсийг тайлбарлана уу.

	Эшлэл	Тайлбар
Цаг	Урьд цагт	
	Дорно зүг	

Уран дүрслэлийг тайлбарлах

1. Тэмээнд арван хоёр жилийн амьтны ямар ямар шинжүүд байдаг гэж домогт нэрлэсэн бэ? Эдгээр нь гадаад шинжийг тоочиж байна уу, дотоод шинжийг илэрхийлж байна уу?
2. Юуг ямар шинжээр адилтгасныг тайлбарлана уу.

Эшлэл	Тайлбар
Таваг	
Дэл	
Өрөвлөг	

СОЁЛЫН ҮҮСЛИЙН ДОМОГ

Уншихын өмнө

- Хүүхдүүд ээ! Хүн төрөлхтний соёлын нэгэн чухал хэсэг нь хөгжим юм. Үндэстэн бүр өөрийн аж амьдралын ая хэмнэлийг илэрхийлэх олон янзын хөгжмийн зэмсгийг бүтээж иржээ. Та нарын бодлоор хөгжим анх хэрхэн үүссэн бол? Төсөөлөн бодно уу.
- Жигүүрт мориныхоо үхэлд гашуудан морин хуурыг бүтээсэн Хөхөө Намжилын тухай домгийг та нар санаж байна уу? Хуур хөгжим хэрхэн үүссэн тухай өгүүлсэн өөр нэгэн уран сэтгэмжээр баялаг домгийг уншицгаая.
- Эртний монголчуудын уран сэтгэмжээрээ ургуулан зохиосон домгийг уншихын өмнө дараах үг хэллэгтэй танилцана уу.

Үг хэллэг	Тайлбар
Икэл	Ойрад монголчууд морин хуурыг икэл гэдэг.
Товшуур	Тууль хайлахад хэрэглэдэг нэгэн зүйл хөгжмийн зэмсэг
Маар	Хуурын чавхдасыг өргөж буй жижиг хөндлөн мод
Тууль	Баатарлаг хэрэг явдлыг аялгуулан өгүүлдэг аман яруу найргийн нэгэн зүйл

ХУУР ХӨГЖИМ ҮҮССЭН НЬ

(Домог)

Хувилбар 1

Бурхан багш ээжийгээ алдаад уй гашуу болж суухдаа гуньж гутсан сэтгэлээ сэргээх нэг юм гаргах сан гэж бодоод хуур гэдэг юмыг хийх болжээ. Тэгсэн тэр нь ер олигтой юм болж өгсөнгүй, аргаа бараад нэг зурхайчид очиж учир явдлаа хэлсэнд:

- Аа, чи мод дөрвөлжлөөд, могойн арьсаар гадарлаад, морины сүүлээр хялгаслаад, махир модоор онь хийвэл хуур гэдэг юм болно доо гэж хэлжээ.

Хэлсэн ёсоор нь мод дөрвөлжлөөд, могойн арьсаар гадарлаад, морины сүүлээр хялгаслаад, махир модоор онь хийгээд дуу гаргах гэсэн чинь хяхарч чахраад л санаанд нь хүрсэнгүй. Тэгэхлээр нь нөгөө зурхайчдаа эргэж очоод:

- Хуур хийсэн чинь эвтэй, аятай дуу гарахгүй юм. Яах вэ? гэсэнд:

- Ээжийг чинь авснаараа үүнийг чөтгөр хэлж өгөх биз гэж хэлжээ.

Чөтгөрт очоод:

- Ээжийгээ алдаад гуньж гутаж суухдаа сэтгэлээ сэргээх гэж хуур гэдэг юм хийсэн чинь хяхарч чахраад байх юм. Яавал сайхан дуутай болгох вэ? гэсэнд Чөтгөр:

Шар хээрийн хялгас л дутаа биз

Шар харгайн давирхай л дутаа биз гэж хэлжээ.

Тэр ёсоор хуурынхаа хялгасанд модны давирхай түрхсэнд үнэхээр сайхан дуу гарч энэ цагаас хойш хуур гэдэг хөгжим гарсан гэнэ.

(Д.Цэрэнсодном, Монгол ардын домог үлгэр, УБ., 1989, 167 дугаар тал)

Иклийг ч гэсэн, товшуурыг ч гэсэн Шуламс эхэлж хийсэн байгаа юм. Иклийг хийчхээд, харгайн давирхай түрхээд дуугаргасанд энэ хуур их чанга дуутай, чахтнаад, үг хэл огт орж ирэхгүй байжээ. Тэгээд Шуламс Бурханаас очиж асуусан гэнэ. Шуламс:

- Би нэг хуур хийлээ. Хийсэн хуур маань их дуутай болчихлоо. Дуу нь хэтэрхий, үг хэл муутай. Үүний дууг яавал багасгах арга байх вэ? гэж асуудаг юм байж. Тэгэхэд Бурхан багш хэлсэн байгаа юм.
- Аа, чи давирхай их түрхсэн байна л даа, бохь бага түрхсэн байх, ингээд дуу нь ихдэж байгаа юм гэсэнд “Давирхай их түрхчихвэл хэлгүй их дуутай болдог юм байна” гэж мэдээд, давирхайг хусаж арилгаад, бохийг түрхсэн байгаа юм. Тэгээд тэр хуур цэвэр дуутай, хэллэг сайтай болжээ. Гэхдээ энэ хуурыг Бурхан өөрийн нэрээр хүнд бэлэглэн өгчээ.

Тэгэхээр нь товшуур гэдэг хөгжмийг Шуламс хийжээ. Товшуурыг хийгээд цохихлоор царгиад бас л хэл ам орохгүй байсанд “Энэ яавал хэл орох вэ? гэж бодоод Шуламс Бурханаас очиж асуужээ. Шуламс:

- Би товшуур гэдэг хөгжим хийлээ. Миний товшуур хөгжим дуу ихтэй гэж бас бэрх боллоо. Жаахан дуу багатай болгох арга байна уу? гэсэнд Бурхан:
- Аа, чи одоо маараа их өндөр хийсэн байна. Маараа намсга гэж хэлжээ. Шуламс буцаж ирээд маараа намсгаж тавьсан, тэгээд товшуур бий болсон. Бурхан багш товшуур гэдэг хөгжмийг Шуламс хийсэн учраас тэр Шуламсын үйлсийг тасалж, дайг нь дарж явах учиртай гээд тууль хэмээх зүйлийг хайлдаг энэ заншилд нь заншуулж гаргасан гэнэ.



(С. Дулам, Монгол домог зүйн дүр, УБ., 2009, 275 дугаар тал)

Зохиолын үг сонголтын шалтгааныг тайлбарлах

1. Домогт мэдэхгүй ямар үг хэллэг байна вэ? Дараах үгсийн утгыг хам сэдвээс тодруулаад толь бичгийн тайлбартай харьцуулаарай.

Танил бус үг	Толь бичгийн тайлбар	Хам сэдвийн утга	Ямар утгыг тодруулах гэж энэ үгийг хэрэглэсэн бол?
харгай			
бохь			
давирхай			
Мэдэхгүй үгээ тэмдэглэнэ үү.			

Өгүүлэгдэхүүнийг ялгах

1. Хуур хөгжим үүссэн тухай домгийн хоёр хувилбарын эхлэл, өрнөл, төгсгөл хэсгийг тус тус тодорхойлно уу. Үүний тулд дараах асуултад хариулж бичээрэй.
 - А. Хуурыг бүтээх санаа ба шийдвэрийг хэн гаргасан бэ?
 - Б. Тэр санаагаа хэрэгжүүлэх замд ямар саад бэрхшээл тулгарсан бэ?
 - В. Саад бэрхшээлийг хэрхэн даван туулсан бэ? Тэдэнд хэн, юу тусалсан бэ?

.....

.....

.....

Дүрийн зорилго, зан төрхийг тодорхойлох

1. Домгийн хоёр хувилбарт ямар ямар дүрүүд гарч байна вэ?
2. Бурхан багш юуны учир хуур хийхээр болов? Эхний өгүүлбэрийг уншаад, Бурхан багшийн тухай юу бодов?
3. Хуураа хийхийн тулд ямар зорилго тавив? Түүний зорилгыг хэр зөв гэж бодож байна вэ?
4. Зорилгодоо хүрэхийн тулд юу бодов? Юу хийв? Тэр шантарсан уу?
5. Бурхан багш болон чөтгөрийн гадаад төрхийг төсөөлөн яриарай. Чөтгөр
“Шар хээрийн хялгас л дутаа биз
Шар харгайн давирхай л дутаа биз” гэж хэлэхдээ ямар төрх байдалтай байсан бол?

Домгийн сэдэв, гол санааг тайлбарлах

1. Хуур хөгжим үүссэн тухай дээрх домогт, хуурын үүслийг Бурхан багшийн эхээ алдсантай холбон тайлбарласан эртний домгийн уран сэтгэмжийн цаана ямар санаа оршиж байна вэ? Үүгээрээ аялгуу хөгжмийн үүргийг хэрхэн төсөөлж байна вэ?
2. Энэ домог нь хуур хөгжмийг хийх аргын талаар бидэнд юуг таниулж байна вэ?
3. “Хуур хөгжим хийсэн соёлын тухай сэдэвтэй домог юм” гэсэнтэй санал нийлж байна уу? Яагаад?



Өөрийгөө хөгжүүлэх

Даалгаврыг сонгон гүйцэтгэнэ үү.

- A. Монголчууд баяр ёслол, найр хуримыг морин хуурын аялгуугаар эхлүүлдгийн утга учир болон хуур хөгжмийн соёлыг өвөө эмээгээсээ, цахим сүлжээнээс сурвалжлан судална уу. Морин хуур хөгжмийн зэмсгээр тоглож сураарай.
- B. Усны урсгал, салхины исгэрэлт, ойн шуугиан, шувуудын жиргээ, морин төвөргөөн гээд бидний хүрээлэн буй орчинд хөгжим эгшиглэсээр байдаг. Орчин тойрноосоо хэмнэл аялгууг сонсож мэдрэхийг хичээнэ үү.
- B. Үнэндээ та нар ч хөгжим бүтээж чадна. Оролдоод үзээрэй. Янз бүрийн хэлбэр хэмжээтэй мод, чулуу, төмөр, шаазан, хялгас, утас зэргийг ашиглан ямар хөгжим бүтээж болохыг туршаарай.




НОМ УНШЛАГАД УРИХУЙ

Хүүхдүүд ээ! Судлаач Д.Цэрэнсодномын эмхэтгэн хэвлүүлсэн “Монгол ардын домог үлгэр” (1989) номоос “Эрхий мэргэн” домгийг уншаад, нөхдөдөө ярьж өгөөрэй.

МОНГОЛ ҮЛГЭР АМЬТНЫ ҮЛГЭР

Уншихын өмнө

- Үлгэрийн нэрийг уншаад, ямар үйл явдал өрнөхийг таамаглаарай.
- Үнэг, чоно болон бусад амьтдын тухай өөр ямар үлгэрийг та нар мэдэх вэ? Дараах номын чимэг зургийг хараад, бага ангидаа уншсан үлгэрүүдээ сэргээн ярилцана уу.



АРГАТ УЛААН ҮНЭГ (Үлгэр)

Эрт урьд цагт нэг хоосон ядуу хүү оготно, зурманд урхи, тор зүүж, түүгээрээ амьдардаг байжээ. Тэгээд нэг өдөр оготно, зурам агнаж яваад түр амран сууж байтал гэнэт нэг улаан үнэг хар гүйхээрээ давхиж ирээд, тэр хүүгийн хормой доогуур шурган орж:

- За, намайг хөөж яваа олон морьтой хүн хүрч ирээд, “Үнэг хаачив?” гэж асуувал “Аль хэдийн тэр хамар дээгүүр даваад явчихсан” гэж хэлээрэй гээд хүүгийн хормой доогуур улам нуугдан оров гэнэ.

Гэтэл түүнийг хөөсөн бололтой буу, саадаг агссан олон морьтон хойноос нь давхин ирж, нөгөө хүүгээс:

- Нэг том улаан үнэг хаачив, түүнийг харав уу гэж асуухад нь хүү үнэгний хэлсэн ёсоор:

- Нэг үнэг аль хэдийн тэр хамар дээгүүр даваад явчихсан. Одоохон явбал гүйцнэ гэхэд тэр улсууд мориныхоо амыг ч татаж завдалгүй, тэр чигээрээ үнэгний хойноос давхин явцгаав гэнэ.

Нөгөө хүүг босоод явахад үнэг ийнхүү хэлж гэнэ.

- За, та миний амийг аргагүй аварлаа. Харин ачийг тань заавал хариулах болно. Гэхдээ таны аж амьдрал хэр зэрэг билээ? гэж асуухад нь өнөөх хүү:

- Би оготно, зурамхан урхи тороор барьж, амь зуудаг хүн гэж үнэн байдлаа хэлж гэнэ. Үнэг,

- Одоо үед оготно зурам ч юу базаах вэ дээ. Харин чонын арьс л их үнэтэй шүү дээ. Иймд чоно алж, арьсыг нь цай тамхи, янз бүрийн юмнаас худалдах уу гэхэд хүү:

- Тэр ямар зүг байх вэ? Харин миний муу урхинд орж, надад алагдах тийм чоно хаанаас байх вэ дээ гэж хэлэхэд нь:

- Та наад бүсэндээ байгаа хонхыг миний хүзүүнд зүүж өгнө үү гэж гуйхад нь хүү бүсэндээ байсан хонхыг тэр үнэгний хүзүүнд зүүж өгчээ.

Үнэг тэр өдрөө цаашаа давхиад янз бүрийн араатан амьтдын дэргэдүүр явж байтал чоно тааралдаад:

- Үнэг, чи энэ хөөрхөн юм хаанаас олоод зүүчхээ вэ? Наадах чинь яадаг юм бэ? гэж асуухад нь үнэг:

- Энэ юмыг олоход тийм төвөгтэй биш. Энэ булгийн мөсөн дээр өдөр шөнө хоёр оцойгоод суухаар нэг өвгөн хүрч ирээд, хүзүүнд зүүгээд өгдөг юм гэжээ.

- Намайг оцойгоод суувал зүүж өгөх болов уу? гэж асуухад нь:

- Надад өгсөн юм. Танд өгөлгүй яах вэ гэж үнэг хэлжээ.

Чоно хүзүүндээ хонх олж зүүхээр:

- Тэр булаг чинь чухам хаана байдаг юм бэ? гэж лавлан асууж үлджээ.

Үнэг ийнхүү чононд хэлснийхээ дараа хүүд хүрч ирээд:

- За хө, маргааш өглөө энэ булгийн мөсөн дээр нэг чоно бөгсөөрөө наалдчихсан байх вий. Түүнийг цохиж алаад, арьсыг нь авч, цай, тамхи, идэж уух юмнаас өгөөрэй гэж хэлээд явжээ.

Хүү маргааш өглөө нь “Юу магад вэ?” гэж бодоод, булгийн наахна мод бариад очтол, нээрэн булгийн мөсөн дээр нэг чоно оцойгоод сууж байхыг хараад, түргэн түргэн алхалсаар очиход нь тэр чоно “Миний хүзүүнд хонх зүүж өгөх хүн ирж яваа юм болов уу” гэж санаснаа цааш зугтаах гээд ухасхийтэл бөгс нь мөсөнд наалдчихсан байжээ. Тэгэхийн хооронд хүү түүнийг цохиж алаад, арьсыг нь худалдаж, цай, идэж уух юмнаас өгч гэнэ...

(Монгол ардын үлгэр, Эмхэтгэсэн Д.Цэрэнсодном, УБ., 1982, 59-60 дугаар тал)

Өгүүлэгдэхүүнийг ялгах

1. “Аргат улаан үнэг” үлгэрийн үйл явдлын эхлэл, гол, төгсгөл хэсгийг тодорхойлно уу. Зохиолын зөрчлийг тодорхойлно уу. Үүний тулд дараах асуултад хариулж бичээрэй.
 - А. Үнэгний хийж байгаа үйлийг эсэргүүцсэн юм уу, эсвэл саад учруулсан ямар нэгэн баатрыг үлгэрт үзүүлж байна уу?
 - Б. Үнэг болон түүнийг авлах гэсэн морьтнуудын хооронд, эсвэл чоно үнэг хоёрын хооронд ямар зөрчил байна вэ? Эндээс үндэслээд үлгэрийн зөрчлийг тодорхойлоорой.

Дүрийн үг, үйлдлээс зорилгыг тодорхойлох

1. Үнэгний хэлсэн үгийг дахин уншаад, зан чанарыг хэлэлцээрэй.
2. Үнэг чоно хоёрын дүрийг харьцуулж, адил ба ялгаатай талыг тодруулаарай.
3. Үнэг ямар зан төрхтэй учраас чоно үнэгний заль мэхэнд автахад хүрэв? Чонын хэлсэн үг, хийсэн үйлдлээс үндэслэн чонон зорилгыг тодруулаарай.

Орон цагийн дүрслэлээр орчныг ялгах

1. Үлгэрийн үйл явдал өрнөж буй газар орон, цагийг тодруулах ямар нэгэн мэдээлэл үлгэрт байна уу?
2. Үнэг юуг тооцож, чоныг мөсөн дээр аваачсан бэ? Мөсөн дээр үйл явдлыг өрнүүлснээрээ үнэгний ямар зан чанарыг тодруулж байна вэ?

Үзэл бодлоо илэрхийлэх

1. Хэрвээ та нар чонон оронд байсан бол яах байсан бэ?
2. Үлгэрт үнэгний заль мэхийг зөвтгөж байна уу? Аль эсвэл?
3. Хормой доогуураа улам нуугдаж байгаа үнэгийг хараад хүү юу бодсон бол?

ШИДЭТ ҮЛГЭР

Уншихдаа

- Хүүхдүүд ээ! Та нар дараах үлгэрийг уншихдаа ямар ямар шидэт зүйлс гарч буйг анхааран уншаарай.
- Үлгэрийн үйл явдлыг утгат хэсгүүдэд хувааж, хэсэг тус бүрт гарчиг өгнө үү.

(Н.Содном, Номын чимэг зураг, 1990 он)



ХААНЫ ХҮҮ ГОМБО, ХАРЦЫН ХҮҮ ГОНГОР

(Үлгэр)

Эрт урьд цагт нэг хааны хүү, харцын хүү хоёр их дотно үерхэж байжээ. Хааны хүүг Гомбо гэдэг, харцын хүүг Гонгор гэдэг байжээ. Харцын хүү Гонгор эцэг эхээсээ өнчин хоцорчээ.

Тэгээд нэг өдөр Гомбодоо хэлсэн нь:

-За найз минь, одоо надад санаж сарвайх эцэг эх үгүй, гон бие гозон толгой боллоо. Харь газар явж, юм үзэж, эрдэм ном суръя гэжээ. Гэтэл хааны хүү Гомбо:

-Зовбол хамт зовно биз, жаргавал хамт жаргана биз. Ямар боловч би чамтай хамт явна гээд хоёулаа хамт явж гэнэ.

Олон хоног явж ядраад, нэгэн модны сүүдэрт хэвтээд, хоёул унтжээ. Хааны хүү есөн хэл мэддэг эрдэм сурсан байжээ. Гомбо түрүүлж сэрээд байтал баруун талаас нэг хэрээ, зүүн талаас нэг хэрээ нисэж ирээд, тэр хоёрын сүүдэрт нь унтаж байсан модон дээр сууж гэнэ. Тэгээд үзэж дуулснаа нэгэндээ хэлж, “Энэ зүүнтээ долоон чөтгөр эрдэнийн таяг булаалдаад хэн нь ч авч чадахгүй байна. Түүнийг яаж авах вэ?” гэлцжээ.

Энэ үгийг сонссон Гомбо, Гонгорыгоо дагуулан тэр зүг явжээ. Замд нэг ханын модны хугархай тааралдахад түүнийг авч, цааш явсаар эрдэнийн таяг булаалдан байсан долоон чөтгөр дээр очжээ. Гомбо тэднээс:

- Та нар ямар юмаа ингэж булаалдаа вэ? гэж асуухад чөтгөрүүд:

- Бид эрдэнийн таяг олоод түүнийгээ булаалдаад хэн нь ч авч чадахгүй байна гэжээ. Ингэж булаалдаад байвал та нарын хэн нь ч авч чадахгүй. Та нар уралдаад ирцгээ. Хэн түрүүлсэнд чинь тэр таягийг чинь өгье! гэж хааны хүү хэлжээ. Чөтгөрүүд зөвшөөрч, уралдаж ирэхэд нь түрүүлсэн чөтгөрт нөгөө ханын модоо бариулчхаад яваад өгчээ.

Хоёр хүү буцаж ирээд модныхоо дор унтаад, өглөө сэрсэн чинь том сайхан гэр дүүрэн эд баялаг, гадаа нь таван хошуу мал багширч байжээ. Энэ бол эрдэнийн таягны ид шид байжээ.

Мөн нэгэн өдөр нөгөө хоёр хэрээ баруун зүүн талаас нисэж ирээд, модон дээр суужээ. Тэгээд “Нөгөө долоон чөтгөр чинь өнөөдөр эрдэнийн шаахай булаалдаад байна” гэж нэгэндээ хэлжээ. Энэ үгийг сонссон Гомбо, Гонгорыгоо дагуулан тэр зүг явжээ. Замдаа нэг айлын нутаг дээр байсан гутлын зулгийг аваад, цааш явсаар долоон чөтгөр дээр очжээ. За та нар чинь юу гэгчийг булаалдаад байгаа юм бэ? гэж асуувал:

- Бид эрдэнийн шаахай олоод түүнийгээ булаалдаад хэн нь ч авч чадахгүй байна гэжээ.

- Тэгвэл та нар уралдаад ир. Түрүүлж ирсэн нь шаахайгаа ав гэхэд долоон чөтгөр зөвшөөрч уралдахаар явжээ. Түрүүлж ирсэн чөтгөрт гутлынхаа зулгийг атгуулчхаад яваад өгчээ.

Хэд хоногийн дараа нөгөө хоёр хэрээ мөн л баруун ба зүүнээс ирээд “Нөгөө долоон чөтгөр чинь өнөөдөр далдын хар малгай булаалдаад хэн нь ч авах аргаа олохгүй байна” гэжээ. Үүнийг дуулсан Гомбо, Гонгорыгоо дагуулан тэр зүг явжээ. Замд нь нэг муу тоорцог хэвтсэнийг аваад явжээ. Цааш яваад долоон чөтгөр дээр очиход нээрээ нэг малгай булаалдаж байжээ. За та нар бас юугаа булаалдаа вэ? гэж асуувал:

- Бид далдын хар малгай гэдгийг булаалдаад хэн нь ч авч чадахгүй байна гэжээ.

- Та нар яваад уралдаад ир. Түрүүлсэнд чинь өгье гэхэд долоон чөтгөр зөвшөөрч уралдахаар явжээ. Түрүүлж ирсэн чөтгөрийн толгой дээр тоорцгоо тавьчхаад, өөрсдөө малгайг нь өмсөөд зугтаачхаж гэнэ ээ. Гэртээ ирээд Гомбо Гонгортоо:

- За хоёул маргааш гурван эрдэнээ аваад явна. Одоо энд суухгүй. Явж газар үзье гэжээ.

Ингээд маргааш нь хоёр хүү аян замд гарч явжээ. Хэдэн өдөр яваад нэг айлын бараа харагдаж гэнэ. Айлын гадаа өдий төдий морь мал багширч, ямар нэгэн найр наадам хийж байжээ. Хааны хүү Гомбо хэлсэн нь:

- За Гонгор минь хоёулаа энэ айлд очъё. Тэгэхдээ чи ил очоорой. Би далдын хар малгайгаа өмсөөд далд очно. Би үргэлж чиний хажууд байна. Чи миний юу хэлснийг хийгээрэй гэжээ.

Ингээд хоёулаа ил, далд байдлаар очжээ. Тэр айлд олон хүн цугларч, ихээхэн найр наадам хийгээд тарж байх атал эмгэн өвгөн хоёр уйлж суужээ. Хүмүүс цөм тараад явж гэнэ. Эмгэн өвгөн хоёр уйлаад хоцорчээ. Тэгэхэд Гонгор тэр хоёроос:

- Хүмүүс цөм баяр баясгалантай найр наадам хийж байхад та хоёр юунд ингэж уйтгарлан уйлж байгаа юм бэ? гэж асуухад тэр хоёр хэлсэн нь:

- Манай энд долоон настай хүүг хаан ширээнд суулгадаг. Хаан ширээнд суусан хүүхэд нь гурав хоногоос хэтрэлгүй үхдэг юм. Маргааш ганц хүүг минь тэр хаан ширээнд суулгахаар сая найр наадам хийгээд тарж байна. Тэгээд л бид хоёр ганц хүүгээсээ салах болсондоо уйлж байгаа юм гэжээ. Тэгэхэд нь Гонгор тэдний хүүгийн оронд хаан ширээнд суухыг гуйсаар зөвшөөрүүлжээ.

Хааны ордонд очвол хааны хатан гэж нэг сайхан хүүхэн байж гэнэ. Ордныхон түүнийг Цэвцэл хатан гэлцэнэ. Шөнө орой болж унтах болсон чинь Цэвцэл хатан эргэл мөргөл хийнэ гээд гарч гэнэ. Хааны хүү Гомбо:

- Эндэхийн хаан үхээд байдгийн учир энэ Цэвцэл хатанд байх шиг байна. Тэгэхээр энэ хатан юу хийдгийг нүд салгахгүй дагаж мэдье гэж Гонгортоо хэлээд, хатны хойноос гарчээ. Хатан үнсэн дээр очиж нэг хөрвөөгөөд, урт улаан үнэг болж, зүүн хойшоо давхижээ. Хааны хүү Гомбо ч эрдэнийн шаахайгаа өмсөөд хойноос нь дагаж гэнэ ээ...

Үлгэрийн үргэлжлэлийг дараах номоос уншаарай.

Хэсэглэн аваа

(Монгол ардын үлгэр. Эмхэтгэсэн Д.Цэрэнсодном, УБ., 1982, 129 дүгээр тал)

Өгүүлэгдэхүүнийг ялгах

1. Эхлэл хэсэгт бичсэн дүрүүдийг бусдад танилцуулж яриарай.
2. Үлгэрийн гол хэсэгт хааны хүү Гомбо, харцын хүү Гонгор хоёрт ямар үйл явдал тохиолдсон бэ? Тэдэнд сурсан эрдэм нь тус болсон уу? Тэд хоорондоо эвтэй байна уу?
3. Тус үлгэр хэрхэн өрнөж дуусах бол? Таамаглан ярилцсаны дараа “Монгол ардын үлгэр” номоос гүйцээн уншаарай.
4. Та нар зохиолч байсан бол яаж төгсгөх байсан бэ?

Дүрийн зорилгыг тодорхойлох

1. Үлгэрт гарч буй дүрүүд бүгд зорилготой байна уу?
2. Гомбо юуны учир юм үзэж, ном суръя гэсэн бэ? Түүний зорилгыг та нар юу гэж бодож байна? Энэ хоёр дүртэй хамт байсан бол чи ямар шийдвэр гаргах байсан бэ?
3. Унших явцдаа хэнийг дэмжиж байв? Яагаад?
4. Чөтгөрүүд шидэт зүйлсийг эхэлж гартаа оруулсан ч эзэмшиж чадаагүйн учир юу вэ? Энэ долоон чөтгөрт ямар чанар дутагдаж байсан бэ? Харин Гомбо Гонгор хоёрт амжилтад хүргэх ямар сайн чанарууд байсан бэ?

Эхийн агуулгыг ярилцаж, сэдэв, гол санааг тайлбарлах

1. Үлгэрт гарч буй шидэт зүйлс нь хүн төрөлхтний ямар хүслэнг илэрхийлж буйг өөрийнхөөрөө тайлбарлана уу.
2. Шидэт зүйлсийг эхэлж гартаа оруулсан ч эзэмшиж чадаагүй чөтгөрүүдийн тухай энэхүү үлгэрийн өгүүлэмжийн цаана ямар утга санаа оршиж байна вэ?

Үзэл бодлоо илэрхийлэх

1. Хааны хүү Гомбо, харцын хүү Гонгор хоёрын нөхөрлөлийн түүхээс та нар юунд суралцсан бэ?
2. Та нарын бие дааж уншсан үлгэрүүдэд өөр ямар шидэт зүйлс гардаг вэ?

Үлгэрийн онцлогийн тухай ярилцъя.

1. Тус үлгэрт ямар ямар шидэт зүйлс гарч байна вэ? Үүнээс үндэслэн шидэт үлгэрийн онцлогийг тодорхойлно уу.

	Эшлэл	Тайлбар
Шидэт зүйлс	Эрдэнийн таяг	
	
	
Шидэт хувилал	Хатан үнсэн дээр очиж нэг хөрвөөгөөд, урт улаан үнэг болж, зүүн хойшоо давхижээ	
	

2. Шидэт үлгэрийн уран сэтгэмжийг өнөөгийн шинжлэх ухаан техникийн ололттой харьцуулна уу. Үлгэрийн уран сэтгэмжээр үзүүлсэн хүн төрөлхтний хүсэл мөрөөдлийн илэрхийллээс өнөөгийн амьдралд биелсэн ямар зүйлс байна вэ? Дэвтэртээ жагсаан бичээд хэлэлцээрэй.

Хүний хүслэнгийн илэрхийлэл	Үлгэрийн уран сэтгэмж	Биелэл
Нисэх хүслэн	Нисдэг бор морь	Нисэх онгоц
...		

Шидэт үлгэр. Сайн сайхан үнэн шударгын төлөө тэмцэгч хувилгаан чадалт хүн ба хүн бус төрөлтөн, тэнгэрийн ид шидэт үйл, ер бишийн явдлын тухай их төлөв үргэлжилсэн үгээр хүүрнэн өгүүлэх уран сэтгэмж голлосон үлгэрийг шидэт үлгэр гэнэ. Шидэт үлгэрийн тэмцэл бол жирийн учир зүйн дотор ойлгогдох энгийн тэмцэл биш, ер бусын нууц далдын хүчний тэмцэл байдаг.


АЖ БАЙДЛЫН ҮЛГЭР

Уншихын өмнө

“Алтай Хангайн ар орой дээр нэг уулзъя
Ардаг хүрэн морины ар зоон дээр нэг уулзъя
Арсландай мэргэн хааны ар мөрөн дээр нэг уулзъя” гэсэн үгийн учрыг тайлахын тулд үлгэрийг уншаарай.

АРСЛАНДАЙ МЭРГЭН ХААН

(Үлгэр)



(Зураач Ч.Бямбасүрэн,
Р.Бат-Өлзий, 2018)

Эрт урьд цагт Арсландай мэргэн хаан гэж байжээ. Араараа дүүрэн ай түмэн арван живаа адуутай, өврөөрөө дүүрэн үй түмэн хорин живаа хонгор алаг адуутай юм гэнэ. Арынхаа хонхрыг дүүргэж үзээд, дүүрч байвал бүрэн гэж, дүүрэхгүй бол дутуу гэж мэддэг юм гэнэ.

Гэтэл нэг өдөр адуу нь хонхор дүүрэхгүй байв гэнэ. Манай адуу яагаад цөөрөөд байна гээд Арсландай мэргэн хаан явж байтал гурван чоно гараад давхиж гэнэ.

Тэр гурван чонын нэг нь Мэргэн саарал, нөгөө нь Бөөн саарал, гурав дахь нь Хурдан саарал нэртэй байжээ. Арсландай мэргэн хаан:

- Аа, эд нар л идэж хороож байгаа юм байна. Маргааш буга гүйцдэг буурал халиунаараа хөөгөөд ална гэж хэлж явж гэнэ. Мэргэн саарал үүнийг мэдээд нөгөө хоёртоо хэлж гэнэ.

- Буга гүйцдэг буурал халиунаараа хөөгөөд алчихна гэж байна. Буурал халиун гэдэг хөгшин гүүний унага тул гурвуулаа газрын өөд зугтаж байгаад гэнэт уруугаа зугтаавал гүйцэхгүй гэхэд бусад нь зөвшөөрчээ. Маргааш нь Арсландай мэргэн хаан буга гүйцдэг буурал халиунаараа хөөхөд нь эхлээд газрын өөд зугтааж байснаа гэнэт уруугаа зугтаасан тул гүйцсэнгүй гэнэ.

Орой буцахдаа Арсландай мэргэн хаан хэлжээ.

- Та нар ийм айхавтар бол халиу гүйцдэг халтар халзнаараа хөөгөөд алчихна даа гэжээ. Мэргэн саарал үүнийг бас мэдээд нөгөө хоёртоо хэлж гэнэ.

- Халиу гүйцдэг халтар халзнаараа гүйцнэ гэнэ. Халтар халзан нь залуу гүүний унага тул газрын уруу зугтаж байгаад гэнэт өөдөө зугтаавал гүйцэхгүй гэхэд мөн нөгөө хоёр зөвшөөрчээ. Маргааш нь Арсландай мэргэн хаан халиу гүйцдэг халтар халзнаараа хөөж гарчээ. Гурван чоно газрын уруу зугтаж байгаад гэнэт өөдөө зугтаагаад бас гүйцсэнгүй гэнэ. Тэгэхээр нь Арсландай мэргэн хаан хэлжээ.

- Та нарыг ардаг хүрэн мориороо хөөгөөд алчихна даа, маргааш гэжээ. Арсландай мэргэн хааны ардаг хүрэн гэж нэг айхавтар эрдэмтэй морь бий юм байжээ. Мэргэн саарал үүнийг бас мэдээд нөгөө хоёртоо хэлжээ,

- Ардаг хүрнээрээ хөөгөөд алчихна гэж байна. Арсландай мэргэн хааны ардаг хүрэн гэдэг бол таван жил сувайрсан залуу гүүнээс гарсан хулангийн унага юм. Жигүүртэн шувууг ч урдаа оруулдаггүй морь доо. Одоо бид аргагүй болов оо. Энэ шөнө л түүнийг идэх арга хийе гэв.

Гурвуулаа ирээд адуунд нь гүйжээ. Шөнө дундаас хойш нэг алгын чинээ адасга шиг туранхай хүрэн морь тааралджээ. Мэргэн саарал чоно хэлжээ,

- Үүнийг л идье! Гурвуул зулгааж идвэл бидний хэрэг бүтнэ гэжээ. Бөөн саарал, Хурдан саарал хоёр нь хэлжээ,

- Өдий олныг харж байж адасга шиг туранхай энэ муу морийг идвэл арай азанд муу болох байх гээд өнөө хоёр үсэрч очоод, нэг тарган гүү унагаад авчээ. Цадталаа идэж гэнэ.

Мэргэн саарал чоно нь Бөөн саарал, Хурдан саарал хоёртоо хэлжээ.

- Би үүнээс чинь идэхгүй. Та хоёр цадаж ханаад одоо хол яв аа! Бид гурвын уулзах хэмжээ

Алтай Хангайн ар орой дээр нэг уулзъя

Ардаг хүрэн морины ар зоон дээр нэг уулзъя

Арсландай мэргэн хааны ар мөрөн дээр нэг уулзъя гэжээ. Тэгээд давхиад явчихжээ.

Өглөө нар гарснаас хойш Арсландай мэргэн хаан ардаг хүрэн морио барьж унаад өнөө гурван чонын хойноос хөөжээ. Гурвууланг нь цохиж алаад, Алтай хангайн ар орой дээр авчирч өвчжээ. Арьсыг нь аваад ардаг хүрэн мориныхоо ар зоон дээр тавьж ганзагалаад гэртээ иржээ. Арсландай мэргэн хаан арьсыг нь элдээд хүрэм хийж өмссөн тул гурван чоно Арсландай мэргэн хааны ар далан дээр бас нэг уулзсан нь тэр гэнэ.

(Монгол ардын үлгэр, Эмхэтгэсэн Д.Цэрэнсодном, УБ., 1982, 182 дугаар тал)

Эхийн агуулгыг ойлгосноо ярилцаж, сэдэв, гол санааг тайлбарлах

Сонгон ажиллана уу.

1. Тус үлгэрт мэргэн ухааны тухай өгүүлжээ гэж дүгнэвэл санал нийлэх үү? Үгүй бол яагаад? Мэргэн саарлын үгээс Арсландай мэргэн хааны хурдан хүлэг бүрийн онцлогийг тайлбарлах замаар мал ахуйн уламжлалт мэдлэгийг тодруулна уу.

Эшлэл	Аж төрөхийн мэргэн ухаан
Буга гүйцдэг буурал халиун гэдэг хөгшин гүүний унага тул гурвуулаа газрын өөд зугтаж байгаад гэнэт уруугаа зугтаавал гүйцэхгүй	
.....	
.....	

2. Энэхүү аж байдлын мэргэн ухааныг дамжуулах үлгэрийн уран сэтгэмжийн цаана ямар утга санаа оршиж байна вэ? Тус үлгэрийн эхэнд, гол хэсэгт, төгсгөлд хэн нь хэнийгээ ялж байна вэ?
3. Үлгэрт яагаад Арсландай мэргэн хааны гурван удаагийн тэмцлийг үзүүлээд, гурав дахь удаадаа төгс дийлж буйгаар үзүүлсэн бэ? Багаараа ярилцаад, санаа дэвшүүлээрэй.

Бусадтай ярилцаж, үзэл бодлоо илэрхийлэх

1. Аль хэсэг сонирхлыг чинь татсан бэ?
2. Энэ үлгэрээс чи үнэ цэнтэй ямар мэргэн ухаанаас суралцсан бэ? Нэг өгүүлбэрээр тодорхойлон бичээрэй.
3. Ардын морь шинжих ёс уламжлалын талаар судалж, үлгэрийн мэдлэгтэйгээ харьцуулан хэлэлцэнэ үү.

Өгүүлэгдэхүүнийг ялгах

1. Үлгэрийн үйл явдлын эхлэл, гол, төгсгөл хэсгийг тодорхойлно уу. Үүний тулд дараах асуултад хариулж бичээрэй.
 - А. Чоныг авлах тухай шийдвэрийг хэн гаргасан бэ?
 - Б. Тэрхүү үйл хэргийг бүтээх замд ямар саад бэрхшээл тулгарсан бэ?
 - В. Тэр саад бэрхшээлийг даван туулахад Арсландай мэргэн хаанд хэн, юу тус болсон бэ?
2. Зохиолын зөрчлийг тодорхойлно уу. Үүний тулд дараах асуултад хариулж бичээрэй.
 - А. Арсландай мэргэн хаан адуун сүргээ өсгөхөд хэн, юу саад болсон бэ? Үүнээс үндэслээд үлгэрийн зөрчлийг тодорхойлоорой.
 - Б. Гурван чоно хоорондоо зөрчилдсөн үү? Хэрвээ хүн байна гэж бодвол ямар зан чанартай болоод зөрчилдсөн бэ?

Дүрийн үг, үйлдлээс зорилгыг тодорхойлох

1. Арсландай мэргэн хааны зорилго юу байна вэ? Арсландай мэргэн хааны дүр нь “Аргат улаан үнэг” үлгэрийн хүүгийн дүр хоёрын шийдвэр гаргах чадварыг харьцуулан бодоорой.
2. Гурван саарлын зорилгыг хэлсэн үг, хийсэн үйлдлээс нь тодорхойлоорой.
3. Гурван сааралд чухам ямар чанар дутсанаас алдаа гаргасан гэж та нар бодож байна вэ?

Орчны дүрслэлийг ялгах

1. Үлгэрээс газар усны нэр болон орны утгатай үгсийг түүж тэмдэглээд, үлгэрийн үйл явдал өрнөж буй орны талаар таамаглана уу. Зургаар илэрхийлж болно.
2. Үлгэрт ерөнхий эрт цагаас гадна цаг улирлын байдлыг тодруулсан үгс байна уу? Дахин уншина уу.

Уран дүрслэлийг тайлбарлах

1. Үлгэрт буй оноосон нэрсийг түүж бичээд ажиглана уу. Ямар нэгэн онцлог санааг илэрхийлж байна уу?
2. Мэргэн саарал чоно өөрсдийн үхлийг мэдэрч хэлсэн гурван үгийн тайлбарыг үлгэрээс авч бичнэ үү.

Эшлэл	Тайлбар
Алтай Хангайн ар орой дээр нэг уулзъя	
Ардаг хүрэн морины ар зоон дээр нэг уулзъя	
Арсландай мэргэн хааны ар мөрөн дээр нэг уулзъя	



Сонсох, ярих чадвараа хөгжүүлэе

Зохиолын үйл явдлыг өөрийн үгээр ойлгомжтой ярих

Алхам 1

- Уншсан үлгэр, домгоосоо аль нэгийг сонгоорой.
- Үлгэрт олон удаа давтагдаж байгаа ямар үг, хэллэг, эсвэл ямар уран дүрслэл байна вэ? Тэдгээрийг бүртгээрэй.
- Ярихын тулд уншсан зохиолынхоо үйл явдлыг дарааллуулан тоочин тэмдэглээрэй. Зураглан илэрхийлж болно.

Алхам 2

- Бүртгэн бичсэн үг хэллэг, уран дүрслэлээ цээжлэн тогтоогоорой.
- Үйл явдлыг ярихдаа тэгээд, иймийн тулд, мөн гэх мэт холбоос үг хэрэглэн яриарай.
- 68 дугаар хуудсан дахь ярих, сонсох чадвараа үнэлэх шалгуурыг хэрэглээрэй.




Бичих чадвараа хөгжүүлэе

Уншсан зохиолын гол санааг алдагдуулахгүйгээр үйл явдлыг товчилж бичих

Зохиолын үйл явдлыг товчилж бичихдээ	<ol style="list-style-type: none"> 1. Товчилж бичих үлгэр, домгоо сонгоё. 2. Үйл явдлыг хүүрнэж ярьсны дараа товчилж бичих үйлээ эхэлье. 3. Гол гол үйл явдлыг багтааж товчлохоо төлөвлөө. 4. Товчилсон хэсэгт гол санаа илрэхүйц байгаа эсэхийг шалгая. 5. Товчилсон бичлэгээ багийн гишүүд болон ширээний найздаа уншуулж, ойлгомжтой болсон эсэхийг асууж хэлэлцье. Ноороглоё. 6. Зөв бичгийн дүрмийн болон найруулгын алдаа гаргасан эсэхийг нягталъя. 7. Дахин сайжруулан хичээнгүй бичье.
Бүтцээ гаргахдаа	Үйл явдлыг дараах бүтцээр бичиж болно. Эхлээд ... Үүний дараагаар... Тэгээд дараа нь ... Эцэст нь...

Дэмжлэг: Үйл явдлыг товчлохоос өмнө гол гол санааг агуулсан хэсгүүдийг дэс дараалан байрлуулж болно.



ХЭРХЭН СУРАЛЦСАНАА ҮНЭЛЬЕ

1. Үлгэрүүдэд нийтлэг ямар шинж байна вэ?

	Жишээ, баримт	Тайлбар
Үлгэрийн эхлэл	Эрт урьд цагт...	Ерөнхий эрт цагийг үзүүлдэг
Үлгэрийн баатрууд		
Үлгэрийн төгсгөл		

2. Амьтны үлгэрийн баатар хийгээд аж байдлын үлгэрийн баатрыг харьцуулна уу. Аж байдлын үлгэрийн баатар амьдралын мэргэн ухааныг сургадаг гэвэл амьтны үлгэрт чухам юуг онцолдог вэ?

3. Шидэт үлгэр хийгээд аж байдлын үлгэрийг харьцуулна уу. Шидэт үлгэрт ид шидэт зүйлс гардаг бол аж байдлын үлгэрт юуг эрхэмлэн үзүүлдэг вэ? Жишээгээр тайлбарлаарай.



НОМ УНШЛАГАД УРИХУЙ

Хүүхдүүд ээ! Номын сангаас судлаач Д.Цэрэнсодномын эмхэтгэн хэвлүүлсэн “Монгол ардын үлгэр” (1982) номыг авч, “Гурван настай Гунаан улаан баатар”, “Цэцэн бэрийн үлгэр” үлгэрүүдийг уншаарай.

4. Уншсан үлгэрүүдээ дараах хүснэгтийн дагуу харьцуулан дүгнэж бичээрэй.

	Аргат улаан үнэг	Хааны хүү Гомбо, харцын хүү Гонгор	Арсландай мэргэн хаан	Гурван настай Гунаан улаан баатар
Амьтны үлгэрийн онцлог				
Шидэт үлгэрийн онцлог				
Аж байдлын үлгэрийн онцлог				
Баатарлаг үлгэрийн онцлог				

Дэмжлэг:

Амьтны үлгэр нь зан төрх хийгээд амьтны бэлгэдэлд тулгуурладаг.

Аж байдлын үлгэрт аж төрөхийн мэргэн ухааныг үзүүлдэг.



Шидэт үлгэрт үг аялгууны бэлгэдэл ба эд өлгийн бэлгэдэл, дохио зангааны бэлгэдэл чухал байдаг.

Баатарлаг үлгэрт хүний эр зориг, баатарлаг, шударга үйлсийг үзүүлдэг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЭЗЭМШИХ ЧАДВАР:

УНШИХ ЧАДВАР

- Зохиолыг мэдэрч ойлгох
- Зохиолчийн үг сонголтын шалтгааныг тайлбарлах
- Сэдэв гол санааг тайлбарлаж, үзэл бодлоо илэрхийлэх
- Уран дүрслэлийг тайлбарлах

ЯРИХ-СОНСОХ ЧАДВАР

- Шүлэг, зохиолоос сонгон цээжилж, дуу хоолойн өнгө, айзам хэмнэл тохируулан уран унших

БИЧИХ ЧАДВАР

- Шүлэглэсэн зохиолын хэлбэрийг дуурайн бичих

МОНГОЛ ЯРУУ НАЙРАГ



АМАН ЯРУУ НАЙРАГ: ЗУГАА ҮГ, ҮГЭН НААДАМ



Унших чадвараа хөгжүүлье

Уншихдаа

- Хэн анхааралтай, зөв, хурдан, тод уншиж байна вэ? Бие биеэ дэмжээрэй.
- Мэдэхгүй үгээ тэмдэглээрэй.

ХЭЛ ЗҮГШРҮҮЛЭХ ҮГ

Жолоо дардаг	Их бух
Жороо халтар	Бага мухар нухуур эвэртэй
Шаврыг усаар зуурна	Бага бух
Саврыг хусаар зорно	Их мухар нухуур эвэртэй
Арван тавны сар	Нарийн суран гөлчгөр гөлгөр олом
Алсуур хүрээлэв үү?	Морийг олойртуулахаас биш
Ойроор хүрээлэв үү?	Бүдүүн суран гөлгөр гөлчгөр олом
Хорин тавны сар	Морийг олойртуулдаггүй юм
Холуур хүрээлэв үү?	Сольж барьсан гэр
Ойроор хүрээлэв үү?	Сорьж тарьсан үр
Арван таван тарган тарлан	Шилж олсон шүр
Хар сарлагийн таргийг	Ширж оёсон ширдэг
Тараг биш гэж эс уугаад	Хойгуур яваа хорь гаруй
Ямар арван таван тарган тарлан	Хонгор халтар галуу
Хар сарлагийн таргийг	Хойгуур гарах нь уу
Тараг мөн гэж уух вэ?	Урдуур гарах нь уу
Дөрвөлжин сүлжсэн	Хүрэл илүүр, болор соруул
Дөрөөний угсуурга	Хүрэл илүүр, болор соруул
Дөрвөөр сүлжсэн	
Жирэмний угсуурга	

(Д.Цэрэнсодном, Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг, УБ., 2012 он)

Хэрхэн уншсанаа сурагч бүр эргэцүүлье.

1. Хэл зүгшрүүлэх үг хэлэхэд ямар бэрхшээл байна вэ?
2. Уншихдаа дараах шаардлагуудаас алийг нь хэрэглэх нь зөв бэ? Сонгоно уу.
 - Зөв унших
 - Хурдан унших
 - Тод унших
 - Ойлгож унших

Хосоороо хэлэлцэх дасгал

3. Дахин давтан өгүүлэхэд адилхан хэлэгдэх гээд байдаг ямар авианууд байна вэ? Гүйцээн бичээд, ялган хэлэх дасгал хийгээрэй.
Л - Р, М - Н, Б - ?, Ц - ?, Ш - ?, Ж - ?, Д - ?
4. Түргэн хэлэх дасгал ажиллахын ач холбогдлыг ярилцаад, дүгнээрэй.
5. Хэл зүгшрүүлэх үгийг олж цуглуулан, түргэн хэлэх дасгал ажиллаарай.

Уншихдаа

Ес хэлэлцэхдээ ижил авиагаар толгой холбосныг ажиглаарай.

ЕС ХЭЛЭЛЦЭХ ҮГ

Нэг есөд яах вэ?
Нэрмэл архи хөлдөнө

Хоёр есөд яах вэ?
Хорз архи хөлдөнө

Гурван есөд яах вэ?
Гунан үхрийн эвэр хуга хөлдөнө

Дөрвөн есөд яах вэ?
Дөнөн үхрийн эвэр хуга хөлдөнө

Таван есөд яах вэ?
Тавьсан будаа хөлдөхгүй

Зургаан есөд яах вэ?
Зурайсан зам гарна

Долоон есөд яах вэ?
Довын толгой борлоно

Найман есөд яах вэ?
Нал шал болно

Есөн есөд яах вэ?
Ерийн дулаан болно

(Д.Цэрэнсодном, Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг, УБ., 2012 он)

Үг сонголтын шалтгааныг тайлбарлан, утгыг мэдрэх

1. Үгийн утгыг тайлбарлах алхмаас суралцаарай. Хүүхдүүд ээ, ямар ч зохиолыг уншихдаа энэ алхмаар ажиллаж хэвшээрэй.



2. Ес хэдийд эхэлж, хэдийд дуусдаг вэ?

3. Хоёр ес нь нэг есөөс, дөрвөн ес нь гурван есөөс илүү хүйтэн гэдгийг ес хэлэлцэхэд хэрхэн илэрхийлсэн байна вэ?

4. Балчир гурван ес, идэр гурван ес, өтөл гурван ес гэж хэлэлцдэг нь ямар утгатай үг вэ?

Багаараа хэлэлцэх дасгал

5. Ес хэлэлцэх нь өвөл цагийн малын арчилгаа, маллагаатай холбогдож байна гэдгийг нотлоорой.

6. Шүлэглэн хэлэхдээ ямар ямар авиагаар толгой холбосон байна вэ? Энэ нь шүлгийг айзам хэмнэлтэй болгоход нөлөөлсөн байна уу?

Уншихдаа

Хүүхэд асуултад хариулахдаа цэцэн үг хэрхэн хэлж байгааг анзаараарай.

ЦЭЦ БУЛААЛДАХ ҮГ

Хүүхэд, хүүхэд хаашаа очих нь вэ?

- Хөндлөнгийн гол руу явж байна

Гол биш шалбааг биз дээ?

- Шалбааг нь шалбааг л даа
Шар шувуу нисээд гэтэлдэггүй л юм даа.

Шар шувуу биш дэгдээхэй биз дээ?

- Дэгдээхэй нь ч дэгдээхэй л дээ
- Дунд чөмгийн ясаар нь байшингийн тулгуур хийдэг л юм даа.

Байшин гэж өөвөн биз дээ?

- Өөвөн нь ч өөвөн л дөө
Үүдэнд нь илжиг орилоход хойморт суусан хүнд дуулддаггүй л юм даа.

Илжиг биш дудрай биз дээ?

- Дудрай нь ч дудрай л даа, далан пүү ачаатай

Дуутын давааг давгүй л давдаг юм даа.

Даваа биш гүвээ биз дээ?

- Гүвээ нь ч гүвээ л дээ
Оройгий нь харахад малгай унадаг юм даа.

Малгай биш тоорцог биз дээ?

- Тоорцог нь ч тоорцог л доо.
Дүн өвлийн хүйтэнд дааруулдаггүй л юм даа.

Хүйтэн биш хүйвэн л биз дээ?

- Хүйвэн нь ч хүйвэн л дээ
Хэлэлцэж байгаа хүний хэлний үзүүр хөлддөг юм даа.

Хэл юм уу, тэр чинь хэсэг мах биз дээ?

- Хэсэг мах нь хэсэг мах л даа
Хэнтэй ч хэлэлцэхэд гартдаггүй л мах даа.

(Д.Цэрэнсодном, Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг, УБ., 2012 он)

Үг сонголтын шалтгааныг тайлбарлан, утгыг мэдрэх

Хосоороо хэлэлцэх дасгал

1. Цэц сорих үгэнд гол, шар шувуу, байшин, илжиг, даваа, малгай зэргийн том гэдгийг тодруулахын тулд ямар ямар үгийг хэрэглэсэн байна вэ? Хэрвээ тэр үгс байхгүй бол эдгээрийн том гэдэг нь тодрох болов уу?
2. Эгц өндөр уултай нутагт уулын оройд бэлчиж яваа янгирын дүрс зуухан дээр тавьсан тогоотой усанд тусаж харагддаг гэдэг. Цэц сорих үгэнд ийм өндөр уулыг хэрхэн хэлсэн байна вэ?

Багаараа хэлэлцэх дасгал

3. Оюун ухааны хувьд онч мэргэн хүн цэц сорьдог байна. Цэц буюу цэцэн үгтэй хүүхэд гэдэгтэй та нар санал нэгдэж байна уу? Яагаад?
4. Хэрвээ та нараас энэ мэтээр асуувал яаж хариулах вэ? Багаараа хэлэлцээд хувилбарууд гаргаарай.

ЗҮЙР ЦЭЦЭН ҮГ

Зүйр цэцэн үг нь хэвшиж тогтсон байдаг. Тэрхүү хэвшиж тогтсон байдлаар нь хүмүүс хэлэлцдэг. Жишээ нь:

Хойд хормойгоо авч
Урд хормойгоо нөхөх гэсэн зүйр үгийг
Урд хормойгоо авч
Хойд хормойгоо нөхөх гэж хэлж болохгүй. Учир нь
Хойд хормойгоо авч
Урд хормойгоо нөхөх

гэсэн зүйр цэцэн үг нь нүдэнд ил урд хормойгоо хүний нүднээс далд хойд хормойгоороо нөхөх үйлээр дутуу муухайгаа хүний нүд хуурч түр зуур далдлах нь буруу гэсэн утгыг илэрхийлэх бөгөөд

Урд хормойгоо авч
Хойд хормойгоо нөхөх

гэхэд энэ утгыг илэрхийлж чадахгүй. Иймд зүйр цэцэн үгийг тогтсон байдлаар нь цээжлэн тогтоож хэрэглэх нь чухал.

Уншихдаа

Зүйр цэцэн үг бүрийн утгыг ухаарч уншаарай.

А. Ажил хөдөлмөр, хичээл зүтгэл, арга эв, сурч мэдэхийг эрхэмлэх тухай

Мэдье гэвэл мэрий
Чадъя гэвэл чармай

Сурахын дайсан бардамнах
Явахын дайсан залхуурах

Эрдэнэ ховор боловч олж болдог
Эрдэм гүн боловч сурч болдог

Ажил хийж хүн болдог
Ар давж хүлэг болдог

Ажилд дадлага
Ачаанд татлага

Аргыг олбол
Бэрхийг давна

Ажилч хүн амны хишигтэй
Залхуу хүн заяа муутай

Бага залхуугаас
Их залхуу болох

Эрт босвол нэгийг үзнэ
Орой унтвал нэгийг сонсоно

Алдыг нь аваад дэлэм дээр нь
Атгыг нь аваад чимх дээр нь

Усны гүнийг уургаар мэдэх
Ухааны гүнийг үгээр мэдэх

Ажил хийвэл ам тосодно

Дуудах нэрийг эцэг эх
Дуурсах нэрийг өөрөө

Буруу замаар будаа зөөсөн хүн
Буцахдаа шороо зөөнө

Хүн хэлээрээ, мал хөлөөрөө

Утгыг мэдэрч, санааг тайлбарлах

1. Зүйр цэцэн үгсэд сургамжтай ямар ямар санааг хэрхэн илэрхийлсэн байна вэ?
Жишээ нь:
Ажилд дадлага
Ачаанд татлага
гэсэн зүйр цэцэн үгэнд ачаа ачаад татлагагүй бол гээгддэг шиг, ажил хийхэд дадлагагүй бол цаг алдаж, үр бүтээл муутай байна. Иймд ажлыг үр бүтээлтэй сайн хийхийн тулд сурч мэдэх төдийгүй ахин дахин хийж дадлагажих хэрэгтэй гэсэн санааг илэрхийлсэн.

Багаараа хийж, хэлэлцэх дасгал

2. Залхуурахаас сэргийлэх, залхуурахын уршиг, залхуугийн шинж сэдвээр зүйр цэцэн үг цуглуулж, хэлэлцүүлэг зохион байгуулаарай.
3. Зүйр цэцэн үгсэд сурч мэдэх тухай хэрхэн сургасан байна вэ?

Б. Ач тус, зөв буруу, ёс журмыг сахих тухай

Ахаа алд хүндэл	Их малгай толгой дарна
Дүүгээ дэлэм хүндэл	Их зан бие дарна
Ам нь идэж, сүүл нь таргалдаг	Ааш зангийн номхон нь сайн
Ах нь сургаж, дүү нь сонсдог	Адуу малын тарган нь сайн
Ахмадаа хүндлэх нь цэцний шинж	Би гэсэн ганцаараа
Арсалдаж маргах нь тэнэгийн шинж	Бид гэсэн олуулаа
Бороотой боловч болзоондоо	Шунал ихэдвэл шулам болно
Хуртай боловч хугацаандаа	Шуурга ихэдвэл зуд болно
Өөрийн тусыг эхэнд нь	Өөрийгөө өмөөрөхдөө
Нөхрийн тусыг сүүлд нь	Өндгөө дарсан шувуу шиг
Буруу юм багадахгүй	Хүнийг хэлэхдээ
Зөв юм ихдэхгүй	Хүрэн эрээн бүргэд шиг

Утгыг мэдэрч, санааг тайлбарлах

1. Зүйр цэцэн үгсэд юу юуг зөв, юу юуг буруу гэсэн байна вэ?
2. Зүйр цэцэн үгсэд аливаа юмыг цагт нь хийх, цаг баримтлах тухай хэрхэн сургасан байна вэ?
3. Ямар ямар тохиолдолд дээрх зүйр цэцэн үгийг хэрэглэх бол? Хэлэлцээрэй.

В. Хүний харилцаа, зан чанар, нэр төр, үг хэл, өөрийгөө таних тухай

Гэгээн ухаантан гэмээ мэддэг	Онгиороо хүн олонд хүндгүй
Саруул ухаантан саараа мэддэг	Оготор хормой жаварт нөмөргүй
Цэцэн хүн хүний бэрхийг магтдаг	Туйлбаргүй хүн шантрах нь амархан
Тэнэг хүн өөрийн бэрхийг магтдаг	Тугалган жад шамрах нь амархан

Ховдог хүн хон хэрээтэй адил
Хэрүүлч хүн өмхий хүрээтэй адил
Нэр хугарахаар
Яс хугар
Орчлонг өргөстэй гэвэл гутлаа сайн улла
Олныг буруутай гэвэл өөрийгөө сайн шинж
Нөхрөө харж биеэ зас
Сүүдрээ харж бүсээ зас
Агт алдвал барьж болдог
Ам алдвал барьж болдоггүй
Үг давтвал улиг
Ном давтвал билиг

Үг сөрвөл хэрүүл
Үүл сөрвөл бороо
Зөөлөн үгэнд хүн бөхийнө
Зүлэг газарт морь бөхийнө
Ховын үгэнд хол ойр гэж үгүй
Хорт могойд бүдүүн нарийн гэж үгүй
Айл хүний амь нэг
Саахалт айлын санаа нэг
Эрхий хуруу эрдэмтэй ч
Чигчий хуруугүй бол дутмаг
Цуварч явсан барсаас
Цуглаж суусан шаазгай дээр

(Д.Цэрэнсодном, Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг, УБ., 2012 он)

Утгыг мэдэрч, санааг тайлбарлах

1. Зүйр цэцэн үг тус бүрийн утгыг шүүн ярилцана уу.
2. Зүйр цэцэн үгсэд нэг чухал санааг хэлэхдээ өөр нэг зүйлээр нэмж тодотгож өгснийг ажиглаж тайлбарлана уу.
3. Ховын үг, хорт могой хоёрыг нэг зүйр цэцэн үгэнд хамтатган хэрэглэсний учрыг тайлбарлана уу.
4. Зүйр цэцэн үгсийн санааг ухааран, өөрийгөө шинжээрэй.
5. “Хэн олон зүйр цэцэн үг цээжээр хэлж, утгыг нь тайлбарлах вэ?” уралдаан зохиогоорой.

Онъсого

Онъсого бол хорвоогийн хамаг амьтан, юм үзэгдлийн хамгийн гол тоо хэмжээ, дүр төрх, шинж тэмдэг, үйл хөдлөл зэргээс сонгон ил хэлж, уг зүйлийг далдалж нууцалсан, оюун ухаанаа сорьж тайлахад зориулсан уран асуулт шүлэг юм.

Тайлж тайлбарлахдаа:

Онъсого эртний уг сурвалжтай, түүхийн урт хугацааг хамрах тул онъсогод хуучин үг, зохиомол үг орсон байдаг. Иймд онъсогыг тайлахдаа онъсогод орсон үг бүрийг нягталж үзэх хэрэгтэй. Жишээ нь,

Янхлай хүү

Ясан өлгийтэй, тэр юу вэ?

гэсэн онъсогыг тайлахдаа “Янхлай” гэдэг нь тодорхой утгагүй зохиомол үг байна гэдгийг анхаарахын зэрэгцээ “Яс буюу яс мэт хатуу зүйл дотор байдаг тэр зүйл юу байх вэ?” гэж бодож онъсогыг тайлна. Онъсогыг тайлахад онъсогод дурдсан зүйл онъсогын хариу байж болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй. Жишээ нь:

Эрээгч үнээ

Эрдэнийн сүүтэй

гэсэн оньсогын хариу нь “Үнээ” байх боломжгүй. Харин үнээ биш боловч эрдэнэ мэт үнэ цэнтэй зүйл гаргадаг тэр юу вэ гэдгийг бодож олно.

1. Дараах оньсогыг тайлахдаа үг бүрийн утгыг нягталж ярилцана уу.
2. Зургийг ашиглан, оньсогын утгыг тайлаарай.

А. Тэнгэр, газар, од, эрхэс, байгалийн үзэгдлийн тухай

Алтай Хангайн ард гэнэ

Арван түмэн адуу гэнэ

Цойлсон долоо гэнэ

Цугласан зургаа гэнэ

Цуварсан гурав гэнэ

Хар, цагааныг ялгасан хоёр гэнэ

Хаягдаж хоцорсон нэг гэнэ

(Тэнгэр, од, долоон бурхан, мичид,
марал, сар, нар, үүрийн цолмон)

Тойрч болдоггүй нутагтай

Тоолж болдоггүй торомтой

Тахир цагаан ингэтэй

Тарган шар бууртай


(Тэнгэр, од, сар, нар)

Хөх торгыг хөшиж болдоггүй

Шар торгыг шаглаж болдоггүй

Хар торгыг хажиж болдоггүй

(Тэнгэр, газар, ус)



Уран дүрслэлийг тайлбарлах

Онсьсогыг тайлж хариуг хэлэхдээ товч хариуг хэлэх төдийгүй дүрслэл тус бүрийг тайлж тайлбарлана. Жишээ нь,

Зэрэглээт гурван тал

Жимст гурван нуруу

Хөхрөгч гурван гүвээ

Хөндлөн гурван даваа тэр юу вэ?

гэсэн онсьсогыг тайлахдаа “Жилийн дөрвөн улирал” гэж тайлах төдийгүй зэрэглээт гурван тал гэдэг нь “хавар”, учир нь хавар зэрэглээ маш их татдаг учраас зэрэглээт гэсэн байна. Жимст гурван нуруу гэдэг нь “зун”, учир нь зун жимс ногоо дэлгэрдэг учраас “жимст” гэсэн байна. Хөхрөгч гурван гүвээ гэдэг нь “намар”. Намар ургамал ногоо гандаж, буцаж буй цаг тул “хөхрөгч” гэсэн байна. Хөндлөн гурван даваа гэдэг нь “өвөл”.

Өвөл хүйтэн, бэрх хатуу цаг тул хөндлөн даваа гэсэн байна гэх зэргээр тайлбарлана.

1. Онсьсогын уран дүрслэлийг тайлбарлахдаа дараах хоёр асуултыг хэрэглээрэй.
Юуг юутай адилтгасан бэ?
Ямар шинжээр нь адилтгасан бэ?
2. Дөрвөн бүлэг болгож жагсаасан оньсогуудыг уншиж цээжлээд, бусдаар тайлуулна уу.



Дуу хоолойн өнгө, айзам, хэмнэл тохируулан уран унших, аялгуулан хэлэх

Уншихдаа

Дайралцах үгийг багшийнхаа удирдлагаар аялан уншиж, цээжилнэ үү.
Дайралцах үгийг хоёр хоёроороо харилцан дайралцаж уншина уу.
Утгыг ойлгосны дараа аль хэсэг дээр дуу хоолойны өнгө, удаан түргэн хэмнэл, дохио зангаа, нүүр царайгаа өөрчлөхөө ярилцаарай.

ДАЙРАЛЦАХ ҮГ

Дайралцах үг нь хэлбэрийн хувьд харилцаа шүлэг юм. Тэгэхдээ уран үг хэлээрээ дайралцах учраас егөө үгээр нааддаг онцлогтой.

Зэ! Хүү минь, тийм үү дээ
Зурмантааны нүхэнд нь
Зургаан салаа байна уу даа
Зулзган чиний цээжинд нь
Зургаан шүлэг байна уу даа
Алаг дааганы нүхэнд нь
Арван салаа байна уу даа
Аанай чиний цээжинд нь
Арван шүлэг байна уу даа

Зэ! Хүү минь, тийм үү дээ
Сарыг харваад алдвал
Саадаг бариад юу хийнэ
Чамтай хэлэлцээд гартвал
Шүлэг холбоод юу хийнэ
Мэлхий харваад алдвал
Мэргэнд ороод юу хийнэ
Мөнөөхөн чамд гартвал
Холбоо булаалдаад юу хийнэ

Зэ! Хүү минь, тийм үү дээ
Арван тавны сарыг
Ар дээр гартал хэлэлцье
Адуу үхэр хоёрыг
Бэлчээрт гартал хэлэлцье
Хорин тавны сарыг
Хойд дээр гартал хэлэлцье
Хонь ямаа хоёрыг
Бэлчээрт гартал хэлэлцье

Зэ! Хүү минь, тийм үү дээ
Эрээн эрээн илжиг чинь
Эмээлтэйгээ мэнд үү дээ
Илжиг саадаг суулга чинь
Ёроолтойгоо мэнд үү дээ
Ногоон ногоон илжиг чинь
Ногттойгоо мэнд үү дээ
Нохой саадаг суулга чинь
Ёроолтойгоо мэнд үү дээ
Алаг алаг илжиг чинь
Амгайтайгаа мэнд үү дээ
Аалз саадаг суулга чинь
Ёроолтойгоо мэнд үү дээ

Зэ! Хүү минь, тийм үү дээ
Уулан дээгүүр явдаг
Улаан халтар хэнийх вэ
Хадан дээгүүр явдаг
Хар халтар хэнийх вэ
Хамгаас түрүү дуугардаг
Тэр золбин хэнийх вэ

Зэ! Хүү минь, тийм үү дээ
Уулан дээгүүр явдаг
Улаан халтар манайх аа
Улсаас түрүү дуугардаг
Тэр золбин танайх аа
Хадан дээгүүр явдаг
Хар халтар манайх аа
Хамгаас түрүү дуугардаг
Тэр золбин танайх аа

(Д.Цэрэнсодном, Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг, УБ., 2012 он)

Үг сонголтын шалтгааныг тайлбарлан, утгыг мэдрэх

1. Хоёр талын аялгуулсан
“Зурмантааны нүхэнд нь
Зургаан салаа байна уу даа” гэснийг
“Зурамны нүхэнд нь
Зургаан салаа байна уу даа” гэж аялан хэлж үзнэ үү. Ямар өөрчлөлт гарч байна вэ?
Үүний учрыг тайлбарлаарай.
2. Дайралцах үгэнд “Илжиг саадаг суулга”, “Нохой саадаг суулга”, “Аалз саадаг суулга”
гэсэн үгийг юуны учир хэрэглэсэн байна вэ?
Дайралцах үгэнд танайх муу нохойтой, манайх сайн нохойтой гэсэн утгыг илэрхийлсэн
үг байна. Түүнийг олж тайлбарлана уу.

Хэрхэн уншсанаа баг багаараа эргэцүүлье.

1. Аялгуулан хэлэхэд ямар бэрхшээл байна вэ?
2. Аль хэсэг дээр дуу хоолой, удаан түргэн хэмнэл, дохио зангаа, нүүр царайгаа яаж
өөрчилсөн бэ? Яагаад өөрчлөх болсноо хоорондоо ярилцаарай.
3. Хамгийн сайн хэмнэл, аялга тохируулж уншсан багаа юуны учир сайн болсныг ярилцаж,
дүгнээрэй.



Бичих чадвараа хөгжүүлье

Шүлэглэсэн аман яруу найргийн хэлбэрийг дуурайн бичих

Сонгон ажиллана уу.

Бие даан ажиллах дасгал

1. Нэг есөд яах вэ? гэх мэт есөн асуултад өвлийн хүйтнээр эсвэл зуны халуунаар
баримжаалан “Ес хэлэлцэх үг” зохиож хэлэлцээрэй.

2. Хэл зүгшрүүлэх үг дуурайн бичих Хосоороо ажиллах дасгал	3. Оньсого зохиох Багаар ажиллах дасгал
<p>А. Хойгуур яваа хорь гаруй Хонгор халтар галуу Хойгуур гарах нь уу Урдуур гарах нь уу гэсэн хэл зүгшрүүлэх үгийн сүүлийн хоёр мөрийг өөр үгээр сольж хэр зэрэг зохиосноо хэлэлцэнэ үү.</p> <p>Б. “Хацар”, “газар” гэсэн үг орсон хэл зүгшрүүлэх үг зохиож түргэн хэлээрэй.</p> <p>В. Зохиосноо ноороглон бичээрэй.</p>	<p>А. Харандаа, компьютер, аргал, гэр гэх мэтээр ямар нэгэн бодит юм үзэгдлээс нэгийг сонгоорой.</p> <p>Б. Сонгосон зүйлээ оньсоголохдоо юутай, ямар шинжээрээ адилхан болохыг ажиглаж, төсөөлнө ҮҮ.</p> <p>В. Ямар үг хэрэглэн зохиохоо төлөвлөн, ноороглоорой.</p>
<p>Г. Ноороглноо засахдаа зөв бичгийн дүрмийн алдааг хянаарай. Д. Үг сонголт, найруулгыг хянаарай. Е. Бичсэнээ бусдад уншиж, зөвлөгөө аваарай. Ё. Дахин сайжруулан, хичээнгүй бичнэ үү.</p>	

ХЭРХЭН СУРАЛЦСАНАА ҮНЭЛЬЕ

Унших чадвараа үнэлэх даалгавар

1. Уншиж цээжилснээ үнэлъе.

Цээжилсэн зүйр цэцэн үгийн тоо	Цээжилсэн оньсогын тоо	Цээжилсэн хэл зүгшрүүлэх үгийн тоо

- 36-40 зүйр цэцэн үг цээжилсэн бол хангалттай
 - 25-35 зүйр цэцэн үг цээжилсэн бол дунд зэрэг
 - 25 хүртэл зүйр цэцэн үг цээжилсэн бол хангалтгүй
 - 41-45 оньсого цээжилсэн бол хангалттай
 - 30-40 оньсого цээжилсэн бол дунд зэрэг
 - 30 хүртэл оньсого цээжилсэн бол хангалтгүй
 - 10-15 хэл зүгшрүүлэх үг цээжилсэн бол хангалттай
 - 5-10 хэл зүгшрүүлэх үг цээжилсэн бол дунд зэрэг
 - 10 хүртэл хэл зүгшрүүлэх үг цээжилсэн бол хангалтгүй “Хангалтгүй” үнэлгээ авсан бол нэмж зүйр цэцэн үг, оньсого, хэл зүгшрүүлэх үгийг цээжлээрэй.
2. Ямар ямар шинэ үг сурсан бэ? Жагсаан бичээрэй.
3. Хүний зан чанартай холбоотой зүйр үгээс хэлнэ үү.
4. Монгол аман яруу найрагт ямар ямар төрлүүд байдаг вэ? Нэрлэнэ үү.
5. Онъсогыг яаж зохиож сурсан бэ? Дараах хариултыг зөв дараалалд оруулна уу.
- Онъсогоо ноороглон бичнэ.
 - Юуг юутай адилтгасныг ажиглана.
 - Ямар шинжээр нь адилтгасныг харьцуулан зохионо.
 - Юуны тухай онъсоголохоо сонгоно.
 - Ямар үг хэрэглэхээ бодно.
6. Юуг яагаад “Цэц” сорих үг гэж нэрлэсэн бол? Өөрийн үзэл бодлоор дүгнэнэ үү.

Сонсох, ярих чадвараа үнэлэх даалгавар

	Тийм	Үгүй	Сайжруулсны дараа дахин үнэлсэн нь
Дайралцаа үгийн утгыг ойлгосны үндсэн дээр дуу хоолойн өнгөө өөрчилсөн үү?			
Айзам хэмнэлийг утгад тохируулж аялгуулан хэлсэн үү?			
Дохио зангааг утгад тохируулсан уу?			
Ямар үгийг хурдан хэлэх, ямар үгийг удаан хэлэхээ төлөвлөсөн үү?			
Бусдын аялан, хэлэхийг анхааралтай сонссон уу?			
Сонсоод сайжруулах саналаа хэлсэн үү?			

Бичих чадвараа үнэлэх даалгавар

Дараах үйлийн алхмаар бичдэг бол сонгон тэмдэглээрэй.

- Юуны тухай бичихээ төлөвлөдөг, боддог
- Ямар санаа илэрхийлэхээ төлөвлөдөг.
- Бичих санаагаа цогцолборуудад байрлуулдаг.
- Цогцолбор бүрийг утгын уялдаа холбоотой холбодог.
- Төлөвлөснөө ноороглодог.
- Нооргоосоо зөв бичих дүрмийн алдаа, найруулгын алдааг олж, засан сайжруулдаг.
- Дахин сайжруулж, хичээнгүй бичдэг.

ШҮЛЭГ

ДАНЗАНРАВЖАА (1803-1856)



Төрсөн нутаг: Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошуу, одоогийн Дорноговь аймгийн Хөвсгөл сумын нутагт Өлзийтийн ганц хүү болон мэндэлжээ.

Гол уран бүтээл: “Үлэмжийн чанар”, “Дөрвөн улирал”, “Тунгалаг хөх огторгуй”, “Сэтгэлийг амраагч” зэрэг яруу найраг, “Саран хөхөөний намтар” жүжгээрээ алдартай.

Зохиолчийн хэлсэн онцлох үг:

Авах хүнд нэг үг ч эрдэнэ

Орхих хүнд мянган сургаал ч улиг

1. Үгийн утгыг тайлбарлахдаа 27 дугаар хуудасны бүдүүвчийг хэрэглээрэй.

ГУРВАН СҮЛЖЭЭ СУРГААЛ

Өсөхийн цагт санууштай нь
Бишрэл, хичээл, итгэл гурав...
Ачлахын дээдээр ачлууштай нь
Аав, ээж, эх орон гурав...
Ялахын түрүүнд ялууштай нь
Нойр, залхуу, атаа гурав
Яруу төгс сурууштай нь
Яриа, дуу, хөгжим гурав
Эгшин бүрийд цэгнүүштэй нь
Бие, хэл, сэтгэл гурав
Эгнэгт тордож явууштай нь

Билиг, ухаан, чадал гурав
Бадарч дээшлэхийн үндэс нь
Сэрэх, санах, тэмүүлэх гурав
Баларч доордохын тэмдэг нь
Унтах, мартах, тэрслэх гурав ...
Ажил бүтээхийн эрэмбэ нь
Мэдлэг, чадвар, дадал гурав
Аливаа шинжээс эрхэм нь
Мэргэн, түргэн, даамай гурав ...

*(XIX зууны суут соён гэгээрүүлэгч Д. Равжаагийн
Цаасан шувуу тэргүүт алтан сургаал,
УБ., 2011 он, 94-95 дугаар тал)*

Зохиолын утгыг мэдэрч, ойлгосноо ярилцах

1. Хос хосоороо бадаг бүрийн утгыг хэлэлцээрэй. Цээжлээрэй.
2. “Яруу төгс сурууштай нь
Яриа, дуу, хөгжим гурав” гэсэн хэсэгт чухам ямар ярианы тухай өгүүлсэн бэ?
Энд яагаад яриаг дуу, хөгжимтэй эн зэрэгцүүлж, яруу төгс сурууштай зүйл хэмээн онцолсон юм бол?
3. Бие, хэл, сэтгэл гурвыг яагаад эгшин бүрт цэгнүүштэй хэмээсэн бэ? Бие, хэл, сэтгэлээ цэгнэхгүй бол ямар үр дагаварт хүрч болох вэ? Тохиолдол, үр дагавар тус бүр нэгийг бичээрэй.
4. Энэ сургаалын шүлэгт буй хүний эрхэмлэх чанаруудыг нягталж үзээд, өөртөө зориулан “Зөв амьдрах 10 мөрдлөг” зохион бичээрэй.

Үлгэрлэвэл:

1. Ямагт өөртөө итгэлтэй байх
2.

Өөрийнхөө талаар үзэл бодлоо илэрхийлэх

1. Шүлгийг уншаад та нарт юу бодогдов? Хамгийн чухал, сургамжтай санагдсан мөр бадгууд аль нь вэ? Яагаад?
2. Үзэл бодлоо илэрхийлэхдээ зохиолоос жишээ татаарай.

ХУУЛЬЧ САНДАГ (1825-1860)

Төрсөн нутаг:

Түшээт хан аймгийн Говь мэргэн вангийн хошуу, одоогийн Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутагт төржээ.

Гол уран бүтээл:

“Хаврын хайлаад урсаж буй цасны хэлсэн нь”, “Тэжээсэн нохойн хэлсэн нь”, “Авын хоморгонд орсон чонын хэлсэн нь”, “Салхинд хийссэн хамхуулын хэлсэн нь” зэрэг үг зохиол ард олны дунд ихэд алдаршжээ.

Сандагийг “Хуульч” гэсний учир нь хуучин цагт үлгэр ярихыг хууль ярих гэх буюу үг хэлэнд цэцэн хүнийг хуульч гэж нэрлэдэг байжээ. Сандаг нь Монголын уран зохиолын түүхэнд “Үг” хэмээн нэрлэгдсэн богино хэлбэрийн шүлгийг цээжээр шүлэглэн зохиосон гоц авьяастай яруу найрагч юм. Түүний хэлсэн “Үг” бүр нь сургамжтай байдаг тул хүүхдүүд та нар сурвалжлан олж уншаарай.

Уншихдаа

Хамхуулыг хүнтэй зүйрлэвэл ямар зан чанартай хүн байж болохыг төсөөлөн уншаарай.

САЛХИНД ХИЙССЭН ХАМХУУЛЫН ХЭЛСЭН ҮГ

Үрийн сайнаар ургаж

Үндэсний муугаар ховхорлоо

Төрсөн газар төхөмд сөн

Төлдрийн салхинд гарсан сан

Нүүхийг салхи мэднэ

Буухыг бут мэднэ

Энэхэн бие минь

Эндэгнэж дэндэгнэж л явна

Эцэст нь эргийн мухарт хэвтэж

Элс сөлөнд хутгагдаж

Эрх багачуудын наадам

Ишиг хурганы тоглоом болов.

(МЗЭ. МУЗ-ын товчоон, 2 дугаар боть.
УБ., 2007, 384 дүгээр тал)

Утгыг мэдэрч, ойлгосноо ярилцах

1. Чи энэ шүлгийг уншаад хамхуулыг өрөвдсөн үү? Жигшсэн үү? Эсвэл гунигласан уу? Яагаад?
2. Хамхуул яагаад ховхров? Хамхуулд зорилго байсан уу?
3. “Нүүхийг салхи мэднэ
Буухыг бут мэднэ” хэмээх хэсгийг уншаад юу гэж бодож байна вэ?
4. Хамхуул явсаар хаана очиж, юу болж хувирав? Зохиолч яагаад ингэж бичсэн юм бол? Орчныг дүрслэн бодож дахин уншаарай.
5. Энд гарч буй үг чухам хэний хэлсэн үг вэ? Зохиолчийнх уу? Хамхуулынх уу? Ямар шалтгаанаар ингэж бодсоноо жишээгээр батлан тайлбарлаарай.
6. Хамхуулыг хүн гэж төсөөлбөл ямар зан чанартай хүн байх бол? Хамхуулын хэлсэн үгээс тухайн зан чанарыг батлах жишээ олж бичээрэй.

Өөрийнхөө талаар үзэл бодлоо илэрхийлэх

1. Чамд хамхуул шиг зан чанар, бодол санаа, зорилго байгаа юу? Үгүй гэвэл өөрийгөө тодорхойлоорой.
2. Хамхуул шиг хүнтэй таарвал, түүнийг өөрчилье гэвэл та нар юу гэж зөвлөх вэ? Хосоороо хэлэлцэнэ үү.



ДАШДОРЖИЙН НАЦАГДОРЖ (1906-1937)

Төрсөн нутаг: Одоогийн Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт төржээ.

Гол уран бүтээл: “Миний нутаг”, “Дөрвөн цаг” зэрэг шүлгүүд, “Ламбугайн нулимс”, “Харанхуй хад”, “Цагаан сар ба хар нулимс”, “Хөдөө талын үзэсгэлэн” зэрэг өгүүллэг, “Учиртай гурван толгой” жүжгээрээ алдартай.

Зохиолчийн хэлсэн онцлох үг:
Монголын үрс маш олон болтугай.

МИНИЙ ЭЖИЙ

Монголын үзэсгэлэнт сарангоо намайг төрүүлсэн эжий

Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн эжий

Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн эжий

Зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн эжий

(Д.Нацагдорж, Зохиолууд. ШУА. Улсын хэвлэлийн газар. 1961.140 дүгээр тал)

Утгыг мэдэрч, ойлгосноо ярилцах

1. Тодруулсан үгийг ажиглаад, зохиолч ямар зорилгоор хэрэглэснийг тайлбарлаарай.
2. Зохиолч эх хүний ямар ямар үйлдлийн тухай бичсэн байна вэ? Ийнхүү бичсэнийг та нар юу гэж бодож байна? Та нарын төлөө ээж эсвэл дотны хүн чинь юу юу хийдэг бол?
3. Энэ шүлэг дэх “эжий” гэдэг үг эх, ээж хэмээх үгсээс ямар ялгаатай вэ? “Миний эх” гэдэг гарчиг байвал ямархуу санагдаж байна вэ?

Шүлгийн сэдэв, гол санааг тайлбарлах

1. Энэ шүлэгт зохиолч юуны тухай бичихийг зорьсон бэ? Гол санааг илэрхийлсэн зөв хариуг сонгоорой.
 - А. Сайхан ээжийн тухай
 - Б. Эх хүний үр хүүхдээ хэрхэн өсгөж байгаа тухай
 - В. Зөөлөн цагаан гартай ээжийн тухай
 - Г. Сургаал хэлдэг монгол ээжийн тухай
2. Ээжийнхээ юм уу дотны хүнийхээ хэлдэг “зүйтэй” үгсээс санаж, дэвтэртээ маш сайхан бичиж, хадгалж аваарай.

Уран дүрслэлийг тайлбарлах

1. Дараах шүлэгт ямар нийтлэг шинж байгааг ажиглаарай.

А. Монголын үзэсгэлэнт сарангоо Намайг төрүүлсэн эжий	В. Наран гэрлийн илчтэй Саран гоо эжий минь
--	--
- Б. Дээрээс ээсэн наран аав минь
Дэргэдээс гийсэн саран ээж минь

“Наран аав минь” гэсэн нь урнаар дүрсэлсэн байна. Аавыг нартай адилтгажээ. Нар дэлхийг гийгүүлж, гэрэлтүүлдэг шиг аавынхаа хажууд байвал нөмөр нөөлөгтэй сайхан байдаг гэсэн санааг гаргаж урнаар дүрсэлжээ. Та нар өөрөөр бодож байна уу? Аав, нар хоёрыг ямар шинжээр нь адилтгасан бол?

2. Харин ээжийг яаж урнаар дүрсэлсэн байна вэ? Дараах хоёр асуултыг хэрэглээрэй.
 - А. Хэнийг юутай адилтгасныг бодоорой.
 - Б. Ямар шинжээр нь адилтгасныг тайлбарлана уу.

ПУНЦАГИЙН БАДАРЧ



Төрсөн нутаг:

1939 онд Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт төржээ.

Гол уран бүтээл:

“Есөн эрдэнийн орон”, “Алтан тоос”, “Морьд”, “Хэрлэн”, “Зургаан мөнгөн мичид”, “Ширхэг цагаан сувд” зэрэг яруу найргийн түүвэр хэвлүүлжээ.

Зохиолчийн хэлсэн онцлох үг:

“Эх орон” гэж аман дээр гардаг үг биш, зүрхний гүнд хадгалагддаг үг

Уншихдаа

Монголчууд 9-ийн тоог бэлгэдэн шүтдэг билээ. Монгол хүн юуг шүтэж дээдэлж явах учиртайг бодож уншаарай.

ЕСӨН ЭРДЭНИЙН ОРОН

(Шүлэг)

Ивээлт нарны нь цацрал алтан эрдэнэ
Элгэн уулсын нь оргил мөнгөн эрдэнэ
Илчийн улаан гал нь шүрэн эрдэнэ
Ээжийн цагаан сүү нь сувд эрдэнэ
Энгүй өргөн тал нь оюу эрдэнэ
Эрхэс наадах тэнгэр нь номин эрдэнэ
Элбэрлийн цагаан гэр нь тана эрдэнэ
Энх үүрийн туяа нь зэс эрдэнэ
Эрхт ардын эв нь ган эрдэнэ
Эх орон минь есөн эрдэнэ

Нарнаас эхлээд юу юуг шүтдэгийг бодож уншаарай. Та нар юуг мэдрэв?

Эргэх их дэлхийн уул усанд тэгшхэн
Илч гэрлийн гайхамшиг мандсан нар алтан билээ
Энгүй өргөн талын шимт хөрсөнд төлжиж
Эрдэнийн түрүү сугсруулсан амуу тариа алтан билээ
Энэ сайхан монголын удам залгасан бүл
Энхрий хос амрагийн дурсгалын бөгж нь алтан билээ
Энэрэлт төрийн далбаанд эгнэгт өнгөлөг гялалзсан
Эрдэнийн соёмбо үсэг элэгдэшгүй алтан билээ
Авралын гэгээн нар нь алтан
Ачит төрийн сүлд нь алтан
Арвайн түмэн түрүү нь алтан
Амраг хосын дурсгал нь алтан
Миний эх орон алтан эрдэнийн билээ



Та нар юуг эрхэмлэн алтан эрдэнэ гэх вэ? Зохиолч юу юуг эрхэмлэснийг анзаарч уншаарай.

Саваа дүүрэн мэлтэлзэх Онон, Хэрлэний урсгал
Сартай шөнөөр ажихад мөнгөн хээтэй байв

Саалийнхаа дээжийг өргөж, аянд хүүгээ үдсэн
 Санаа нь сүү эхийн, цацлын халбага мөнгөн байв
 Саатаж алсад суугаад аавдаа очиж золговол
 Санасан эцгийн зэхсэн эмээл мөнгөн байв
 Эцгийн зэхсэн эмээл нь мөнгөн
 Ээжийн цацлын халбага нь мөнгөн
 Сар наадсан ус нь мөнгөн
 Сархад мэлтэлзсэн хундага нь мөнгөн
 Миний эх орон мөнгөн эрдэнийн билээ



Зохиолч юу юуг мөнгөн эрдэнэ гэж тоочсон бэ?

Улсынхаа заяаг түшиж хувьсгалч ах нарын
 Уухайлан мандуулсан туг шүр адил улаан билээ
 Уламж эртнээс дээдэлсэн монгол хүний голомт
 Угалз дөлт гал минь шүр адил улаан билээ
 Удмаас буян төгс өргөө цагаан гэрийн минь
 Унь тооно бүхлээрээ шүр адил туяаран билээ
 Уул усны савд уран бие найгуулсан
 Удвал цэцгийн дэлбээ шүр адил дөлтөн билээ
 Хурын улаан цэцэг нь шүрэн
 Хувьсгалын улаан туг нь шүрэн
 Хурц улаан гал нь шүрэн
 Хорол улаан тооно нь шүрэн
 Миний эх орон шүр эрдэнийн билээ



Юу юуг онцолж шүртэй адилтгасан байна вэ?

Өргөн талын элгэнд чандманиланхан буусан
 Өргөө гэрүүд минь танан өнгөөр цавцайна
 Өчнөөн үеийг элээсэн хангайн буурал уулсын
 Өвгөн цаст оргил танан өнгөөр цагаарна
 Өлзийт ерөөл бэлгэдэж, өнөр буурал эхийн
 Өргөсөн сүүний дусал танан өнгөөр цацарна
 Өнөөдрийн сайхан үеийн бат цагаан харшууд
 Өвлөж хойчдоо үлдээх тана эрдэнэ байна
 Хайрын цагаан сүү нь танан
 Ханат цагаан гэр нь танан
 Хангайн цагаан оргил нь танан
 Хашийн цагаан орд нь танан
 Миний эх орон танан эрдэнийн билээ



Чандманиланхан буусан гэрийг зурна уу. Монгол гэрийг яагаад танатай адилтгав?

Үүлгүй шөнийн тэнгэрт сүүн заадас татуулж
 Өвч түгсэн одод сувд адил гялалзана
 Үелээ татсан талын энгээр тархан бэлчсэн
 Үржилт хонин сүрэг минь сувдранхан налайна
 Үнэрт тансаг өвсний ширхэг тоолон буусан

Үүрийн ариун шүүдэр сувдан далай байна
 Үр буяны “тэнгэр” саальчин монгол хүүхний
 Үсний гоёхон даруулга сувдан хээтэй байна

Хөх тэнгэрийн нь одод сувдан
 Хөдөө талын нь сүрэг сувдан
 Энх үүрийн нь шүүдэр сувдан
 Эгэл саальчны гоёл нь сувдан
 Миний эх орон сувд эрдэнийн билээ

Энэ хэсгийг уншихад юу нь сонин содон санагдав?

Хүүхдүүд ээ! Та нар зэс эрдэнэ, оюу эрдэнэ, номин эрдэнэ, ган эрдэнийн тухай шүлэглэсэн хэсгийг багшаасаа, гэр бүлийнхнээсээ асуух буюу бусад эх сурвалжаас олж уншаарай.

Төгсгөлийн бадагт зохиолч юуг илэрхийлэхийг хүссэн юм бол? Бодож уншаарай.

Мэргэд цэцэлсэн далай хөлгөн их судрыг
 Миний ард түмэн есөн эрдэнээр бичдэг билээ
 Мөнх бусыг дагасан ачит буурлаа хүндэлж
 Миний ард түмэн есөн эрдэнэ дэвсдэг билээ
 Мөхөлгүй эрдэнийн дээж есөн эрдэм төгс
 Миний ард түмэн улсаа бадруулж яваа билээ
 Мөрөөдөл хүслийн дээд эв хамтад хүрч
 Миний ард түмний есөн хүсэл бүрдэх билээ.

(П.Бадарч, “Есөн эрдэнийн орон”. Улсын хэвлэлийн газар. УБ., 1987, 169 дүгээр тал)



Унших чадвараа хөгжүүлэе

Мэдэрч ойлгосноо ярилцаж, гол санааг тайлбарлах

Ангиараа есөн эрдэнэ тус бүрээр баг болон дараах дасгалыг ажиллана уу.

1. Монгол хүн юу юуг шүтэж, дээдэлдэг соёлтой болохыг шүлгээс ажиглана уу. Багаараа ярилцан, зургаар илэрхийлнэ үү.

Монгол ахуйтай холбоотой үгс	Байгалийн юмс үзэгдэлтэй холбоотой үгс	Монголчуудын бүтээсэн соёлтой холбоотой үгс	Өөр юутай холбоотой үгс байна вэ? Багаараа сонгоорой.

2. Шүлгийн гол санааг төгсгөлийн бадгаас тайлбарлан бичээрэй.

3. Есөн эрдэнэ тус бүрийн өнгөний бэлгэдлээр өөрсдийн шүтэж дээдэлдэг зүйлсийг нэрлэн ярилцаарай.

Уран дүрслэлийг тайлбарлах

1. Хэсэг тус бүрээс нэг зүйлийг өөр нэг зүйлтэй адилтгасныг олж, тайлбарлаарай.

Хэсэг	Адилтгал	Юуг юутай адилтгасан бэ?	Ямар шинжээр нь адилтгасныг тайлбарлаарай.
1-р хэсэг			
2-р хэсэг			
.....			



ЖАМБЫН ДАШДОНДОГ (1941-2017)

Төрсөн нутаг:

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт төржээ.

Гол уран бүтээл:

“Аранзал зээрд”, “Вансэмбэрүү”, “Чулуун домог”, “Аав, ээж, би” зэрэг хүүхдийн зохиолын олон түүвэр хэвлүүлжээ.

Зохиолчийн хэлсэн онцлох үг:

Би хүүхэд гэдэг бурхан шүтдэг.

Уншихын өмнө бодъё.

Морины явдлыг үйл үгийн утгаар нь мэдрээрэй.

АРАНЗАЛ ЗЭЭРД

Аранзал зээрд морио
Алхуулан шогшууллаа
Шогшуулснаа хатирууллаа
Хатируулснаа ергүүллээ
Ергүүлснээ цогиуллаа
Цогиулснаа давхиуллаа.
Талаар талаар
Ташуур өгөн
Ташуур өгөн
Довтолгов.
Замаар замаар
Тоос босгон
Тоос босгон
Хурдалгав.
Хатан дэлхий
Дөрвөн туурай
Дөрвөн туурай
Бөмбөрдөнө.
Хайр чулуу
Арван зүгтээ
Арван зүгтээ
Цацагдана

Хөрст дэлхий
Хөлийн доор
Хөлийн доор
Жирэлзэнэ.
Хөтөл гүвээ
Холын холд
Холын холд
Торолзоно.
Сумын бараа
Тодорлоо
Тодорлоо
Сургуулийн байшин
Ойртлоо
Ойртлоо
Аранзал зээрд мориныхоо
Амыг татан цогиуллаа
Цогиулснаа ергүүллээ
Ергүүлснээ хатирууллаа
Хатируулснаа шогшууллаа
Шогшуулснаа алхууллаа.

(Жамбын Дашдондог, Аранзал зээрд,
УБ., 1993, 125-126 дугаар тал)




Унших чадвараа хөгжүүлье


Утгыг мэдэрч, ойлгосноо ярилцах

1. Хүүхэд юунд яарсан бэ?
2. Шүлгээс морины явдлыг илэрхийлсэн үгсийг түүж бичээд, толь бичгээс үгийн тайлбарыг уншаарай.
3. Шүлгийг уншихад ямар өнгө аяс мэдрэгдэж байна вэ? Аль хэсэгт нь хурдан уншмаар, аль хэсэгт нь удаан уншмаар санагдсан бэ? Ямар үгсээс мэдрэгдэв?


4. Морины явдлыг ямар үгээр илэрхийлснийг ажиглаарай.



шогшуулах



цоглуулах



ергүүлэх




давхиулах

5. Үйл явдлын дарааллыг ажиглаж, яаж уншихаа тохируулаарай.

Бүтэц	Үйл явдал	Хурдан унших хэсэг	Удаан унших хэсэг
Эхлэл			
Гол			
Төгсгөл			

6. Бүдүүвчийн дагуу унших дасгал хийгээрэй.



7. Морины явдал удаанаас хурдан болох нь унаж яваа хүний сэтгэлээс шалтгаалсан болов уу? Тэрхүү сэтгэлийн хөдөлгөөнийг ямар үгсээр илэрхийлсэн байна вэ?

Морь унаж яваа хүү сумын бараа хармагц жолоогоо сойж байгаа энэ хэсгээр уяан дээрээ хар хурдаар давхиулж ирдэггүй монгол ёсыг үзүүлжээ. Энэ нь давхиулж ирээд уяхад морины хөлд цус буудгийг мэддэг малч ухаантай холбоотой юм.

Уран дүрслэлийг тайлбарлах

1. Зохиолч шүлгээ уран давталтын аргаар бүтээжээ. Жишээлбэл, “Талаар талаар Ташуур өгөн Ташуур өгөн” гэж давтсан нь та нарт ямар санагдаж байна? Хурдан давхих мориог дүрслэхэд энэ уран давталт нөлөөлсөн үү? Шүүн хэлэлцээрэй.



СЭНДЭНЖАВЫН ДУЛАМ

Төрсөн нутаг:

1950 онд Баянхонгор аймгийн Баянбулаг сумын нутагт төржээ.

Гол уран бүтээл: “Цагаан түрүү”, “Задын чулуу”, “Зүүдний хэлмэр”, “Сэнхрэл уянга” зэрэг яруу найргийн түүвэр хэвлүүлжээ.

Зохиолчийн хэлсэн онцлох үг:

Монгол бичиг соёлд минь өвөг дээдсийн сүлд онгод оршдог.

НҮҮДЛИЙН ЦАЙ

Нүүдэл, нүүдэл гэж
Гадаа хүүхэд хөөрнө.
Уудал, уудал гэх шиг
Гал дээр цай оргино.
Өнгөрөөд явчих вий гэж
Ээж гэртээ сандарна.
Өрөм зөөхийд хөөрцөглөж
Хийц амтыг нь болгооно.
Өглөөхөн чанасан цай

Домбоны хүзүүгээр халуун ч
Өндөр хангайд зорьсон
Нүүдлийнхэнд шинээр хийцлэв.
Дайн дарсан баатар
Угтах гэж байгаа юм шиг
Дайраад л гарах нүүдлийг
Ээж минь амдан гүйнэм.

(С.Дулам, “Цагаан түрүү” УБ., 1978, 30 дугаар тал)



Унших чадвараа хөгжүүлье

Ойлгосноо ярилцаж, гол санааг тайлбарлах

1. Шүлгээс мэдэхгүй үгээ түүж бичээд, ойр орчмын үг хэллэгээс нь утгыг таамаглаж олоорой. Толь бичигт тэдгээр үгсийг хэрхэн тайлбарласан бэ? Чиний таамаглалтай таарч байна уу?
2. Ээжийн хийсэн үйлийг тоочин бичээрэй. Эдгээр үйл нь түүний ямар чанарыг харуулж байна вэ?
3. Амдан алхнам эсвэл явнам гэлгүй “Ээж минь амдан гүйнэм” гэж бичсэнийг та нар юу гэж ойлгож байна вэ? Ээжийн сандарсны шалтгаан юу бол?
4. Өглөө чанасан цай халуунаараа байсаар атал ээж яагаад дахин хийцэлсэн бэ?
5. Нүүн ирж буй айлыг шинэ цай барин угтдаг монгол ёс одоо үед байгаа болов уу?
6. Шүлэгт чиний амьдралд хэрэгтэй ямар санаа байна вэ? Та нар яаж хэрэгжүүлье гэж бодож байна?

Уран дүрслэлийг тайлбарлах

1. Шүлгийн эхний бадагт давтаж байгаа “нүүдэл, уудал” гэсэн үгсийг ажиглана уу. Нэг ба гуравдугаар шадыг эхлүүлж байгаа эдгээр үгсийн ижил төстэй авианы давталт нь авиагаар дүр бүтээхэд ямар үүрэгтэй оролцож байна вэ?
2. “Дайн дарсан баатар
Угтах гэж байгаа юм шиг
Дайраад л гарах нүүдлийг
Ээж минь амдан гүйнэм” гэсэн хэсгийн уран дүрслэлийн онцлогийг тайлбарлаарай.

Юуг юутай адилтгаж дүрсэлсэн бэ?

Ямар шинжээр нь адилтгасан бэ?



ЗАГДЫН ТҮМЭНЖАРГАЛ (1953-2012)

Төрсөн нутаг: Төв аймгийн Угтаалцайдам сумын нутагт төржээ.

Гол уран бүтээл: “Үүрийн тэнгэр”, “Арван найман нас минь”, “Уяхан цэнхэр хавар”, “Ус мөрөн олон чиг” зэрэг яруу найргийн түүвэр хэвлүүлжээ.

“Бага насаа би хайрлаж явна”, “Бөөн баяр”, “Арван найман нас”, “Цэцгэн зүйрлэл”, “Монголын тал нутаг”, “Ус мөрөн олон чиг”, “Уяхан цэнхэр хавар” зэрэг 200 гаруй дууны шүлэг бичжээ.

Зохиолчийн хэлсэн онцлох үг: Ухааны жигүүр эрт өдөлбөл

Уужуу орчлонд хоёр амьдарсны адил аа...

Уншихдаа

Сэтгэлдээ төсөөлөн бодоорой.

МОНГОЛЫН ТАЛ НУТАГ

Дүүжүү алсаас ирээд
Дүүрэн амьсгаа авахад минь
Мөнхийн уснаас амсах шиг
Цээж дүүрэн цэлмээд
Ямар цэнгэг юм бэ?
Монголын ариун агаар
Яасан цэлмэг юм бэ?
Монголын хөх тэнгэр
Алман цагаан саран
Тормос тормос мишээгээд
Алтан мөнгөн одод нь
Тодрон тодрон жирвэлзээд
Ямар цэлмэг юм бэ?
Монголын хөх тэнгэр
Яасан цэнгэг юм бэ?
Монголын ариун агаар

Аяны шувуудын цуваа
Алжаан цуцаж гатлаад
Алаг нүдний үзүүрт
Хаяа хязгааргүй цэлийгээд
Ямар уудам юм бэ?
Монголын тал нутаг
Яасан уужуу юм бэ?
Монгол хүний сэтгэл
Уруудах өөдлөх тавиланд
Сэтгэлийн цавгүй амгалан
Учрах ханилах заяанд
Итгэлийн сэвгүй цайлган
Ямар уужуу юм бэ?
Монгол хүний сэтгэл
Яасан уудам юм бэ?
Монголын тал нутаг

(З.Түмэнжаргал, “Гэрэл гэгээний хүлэг морин мэт”. УБ., 2007. 204 дүгээр тал)

Ойлгосноо ярилцаж, гол санааг тайлбарлах

1. Шүлгийг уншаад юу мэдрэв? Ямар санагдсан бэ?
2. Зохиолч дүүжүү-дүүрэн, цэнгэг-цэлмэг, тормос-тормос, тодрон-тодрон, алман-алтан, цавгүй-сэвгүй, уудам-уужуу зэрэг үгсийг ямар зорилгоор ашигласныг ажиглаж тайлбарлаарай.



3. Шүлгийн бадаг тус бүрийн утга санааны тухай багаараа хэлэлцээрэй.

Бадаг	Юуг дүрслэв?	Юуны тухай өгүүлэв?
1-р бадаг	Монголын агаарын тухай	Монголын агаар нь дүүрэн амьсгаа авах шиг цэнгэг, тэнгэр нь цэлмэг юм гэсэн санааг илэрхийлжээ.
2-р бадаг	Монголын тэнгэрийн тухай
3-р бадаг
4-р бадаг	Монгол хүний сэтгэл, Монголын тал нутгийн тухай	Монгол хүн цайлган, уужуу сайхан сэтгэлтэй байдаг тухай өгүүлжээ. Мөн ...

4. Багаар ажиллах чадвараа үнэлээрэй.

- | | | |
|---|------------|------------|
| А. Хүн бүр оролцоотой байсан уу? | Тийм | Үгүй |
| Б. Санал зөрсөн үү? Зөрсөн бол соёлтой үг хэрэглэсэн үү? | Тийм | Үгүй |
| В. Бусдын саналыг хүлээцтэй сонссон уу? | Тийм | Үгүй |
| Г. Зөв сонссон гэдгээ илэрхийлсэн үү? | Тийм | Үгүй |
| Д. Асуудлаа шийдвэрлэж дүгнэлт хийж чадсан уу? | Тийм | Үгүй |
| Е. Багаараа ажиллаж, шийдвэр гаргасандаа сэтгэл хангалуун байна уу? | Тийм | Үгүй |

Уран дүрслэлийг тайлбарлах

- “Алман цагаан саран Тормос тормос мишээгээд ...” гэсэн хэсэгт сарыг мишээгээд гэж бичсэнээр нь амьдчилан урнаар дүрсэлсэн гэж үзэж болох уу? Яагаад гэдгээ нотлоорой.
- “Сэтгэлийн цавгүй” хэмээх холбоо үгийн уран дүрслэлийг багштайгаа хамтран тайлбарлаарай.



Сонсох, ярих чадвараа хөгжүүлье

Шүлэг зохиолоос сонгон цээжилж, дуу хоолойн өнгө, айзам хэмнэл тохируулан уран унших

- Уншсан шүлгүүдээсээ сонгон цээжлээрэй.
- Аль үг, мөр, бадгийг хурдан унших вэ? Аль үгийн дараа түр зогсоц хийх вэ? Аль хэсгийг удаанаар унших вэ? гэдгийг ажиглан тэмдэглээрэй.
- Шүлгийн утга санаанд тохируулан дуу хоолойныхоо өнгө, нүдний харц, гарын дохио зангаа ямар байхыг төлөвлөөрэй.
- Төлөвлөсний дагуу уншихад бэлдээрэй.
- Уншихдаа ангийнхныхаа өмнө гарч чанга, тод дуугаар өөртөө итгэлтэй уншаарай.
- Бусдын анхаарлыг таттал уншаарай.
- Шүлэг уншиж буй найзууддаа урмын үг хэлж, баяр хүргээрэй.



Шүлгийн хэлбэрийг дуурайн бичих

Сонголтот даалгавар

1. Уншсан шүлгүүдээсээ сонгоорой.

- А. “Гурван сүлжээ сургаал” шүлгийн агуулгыг дуурайн зохиох дасгал
Шүлгийн аль нэг хэсгийн агуулгаар ертөнцийн гурав зохион бичээрэй.
Үлгэрлэвэл:

Ертөнцийн гурван ялууштай

Өдрийн ажлыг алдах тул нойрыг ялууштай
Өсөж дэвжихийг хязгаарлах тул залхууг ялууштай
Өөртөө итгэлгүйг илтгэх тул атааг ялууштай

- Б. “Салхинд хийссэн хамхуулын хэлсэн үг” зохиолын агуулга, хэлбэрийг дуурайн зохиох дасгал
Хамхуулыг хийсгэсэн салхи юу хэлэх сэн бол? “Салхины хэлсэн үг” зохион бичээрэй.

Бичихдээ:

1. “Салхинд хийссэн хамхуулын үг” шүлгийн бүтцийг сайтар ажиглаарай.
2. Ямар санааг илэрхийлэн бичихээ төлөвлөөрэй.
3. Ямар үгийг сонгож бичихээ тэмдэглээрэй.
4. Юуг юутай адилтган бичихээ төлөвлөөрэй.
5. Санаагаа цэгцэлж, бичих дарааллаа тогтоогоорой.
6. Ноороглон бичээрэй.
7. Зөв бичих дүрмийн алдааг хянаарай.
8. Бичсэнээ нягталж, засан сайжруулаад, сийрүүлэн бичээрэй.

- В. “Миний эжий” шүлгийн хэлбэр, агуулгыг дуурайн зохиох дасгал
“Ямар ямар юугаараа яаж яасан эжий” гэсэн асуултын дагуу шүлгийн санааг үргэлжлүүлэн зохионо уу. Зохиохдоо ээжийнхээ хамгийн нандин сайхан чанарууд, хийдэг үйлийг тоочин бичээрэй.

- Г. “Есөн эрдэнийн орон” шүлгийн хэлбэрийг дуурайн бичих дасгал
1. Дээрх шүлгийн нэг мөрд хэдэн үг байгааг ажиглаарай.
 2. Зохиолч толгой, сүүлийг хэрхэн холбосныг ажиглаарай.
 3. Дахилтыг ажиглаад яаж холбосныг анхаараарай.
 4. Агуулгын хувьд зохиолч эх орныхоо юу юуг харж бичсэн байна вэ? Чи тэгвэл агуулгадаа юу юуг оруулъя гэж бодож байна вэ? Сайтар төлөвлөөрэй.
 5. Агуулгаа сонгосны дараа хаана ямар үгийг оруулахаа байрлуулаарай.
 6. Ингээд шүлгээ эхний хувилбараар бичээд үзээрэй.
 7. Чиний бичсэн шүлэгт алдаа бий эсэхийг сайтар хянаарай. Чиний шүлэг, дээрх шүлэгтэй адил хэмнэлтэй болж чадсан уу?
 8. Засан сайжруулаад, сийрүүлэн бичнэ үү.

ХЭРХЭН СУРАЛЦСАНАА ҮНЭЛЬЕ

Унших чадвараа үнэлэх даалгавар

1. “Аранзал зээрд” шүлгээс морины хөдөлгөөн заасан ямар ямар үг мэдэж авснаа бичнэ үү.
2. “Өсөхийн цагт санууштай нь
Бишрэл, хичээл, итгэл гурав” гэсэн хэсэгт буй “бишрэл” хэмээх үг ямар утгаар орсон бэ?
 А. Шашин шүтэх тухай сургасан.
 Б. Өөрийн сонирхсон зүйлээ шимтэн суралцах тухай өгүүлсэн.
 В. Шүтэн биширдэг хүнтэй байх тухай өгүүлсэн.
3. Хамхуулын санааширсан, харууссан өнгө аяс ямар үгээр илэрч байна вэ?
 А. Төхөмд сөн, гарсан сан
 Б. Эндэгнэж дэндэгнэж л явна
 В. Ховхорлоо
 Г. Тоглоом болов
4. Нүүдэл өнгөрөхөд хүүхэд яагаад хөөрч баярласан бэ? Дараах хариултуудаас зөв гэж бодсоноо үндэслэл, нотолгоотойгоор тайлбарлаарай.
 А. Нүүдлийн хүмүүсийг тосон ээжтэйгээ хамт очих гэж хөөрсөн
 Үндэслэл нь
 Б. Нүүдлийн хүмүүст зориулж хийсэн идээнээс идэх гэж баярласан
 Үндэслэл нь
 В. Хүн бүл цөөтэй үед хүний бараа харагдахаар хөөрсөн
 Үндэслэл нь
 Г. Найз нь нүүдэл дунд яваа учир уулзах гэж баярласан
 Үндэслэл нь
5. Өөрийнхөө хамгийн эрхэм нандин зүйлсийг есөн эрдэнэтэй адилтгаж бичээрэй.
 Дэмжлэг болох асуулт:
 А. Юуг юутай адилтгамаар байна вэ?
 Б. Ямар шинжээр нь адилтгах вэ?

Сонсох чадвараа үнэлэх даалгавар

1. Дээрх асуултад хариулж, харилцан ярилцсаны дараа үнэлээрэй.

Өөрийн үнэлгээний шалгуур	Тийм	Үгүй	Заримдаа	Сайжруулах шаардлагатай
Ангийн хүүхдүүдийн ярьсныг анхааралтай, хүлээцтэй сонсдог				
Багшийнхаа ярьж тайлбарлаж байгааг анхааралтай сонсдог				
Багаараа ажиллахдаа өөрийнхөө хэр ярьж байгааг мэдэрч сонсдог				
Зөв сонссон гэдгээ илэрхийлж сурсан				

Ярих чадвараа үнэлэх даалгавар

- Шүлгийг уран уншихад юу юу чухал вэ? Жагсаан бичээрэй.
 - Шүлгийн утгыг ойлгох нь чухал.
 -
 -
 -
 -
- Ц.Дамдинсүрэнгийн “Зугаацахаар мордсон нь” шүлгийн хэсгийг яаж уншихаа бичээрэй.

“Мөчит дөрвөн хөлтний мөр нь гараагүй оргил
Мөгөөрст нимгэн хоолойтны дуу нь хүрээгүй оргил”

 - гэсэн хоёр үгийн хооронд түр зогсоц хийнэ.
 -

Бичих чадвараа үнэлэх даалгавар

- “Салхинд хийссэн хамхуулын хэлсэн үг”-ийг яаж дуурайсныг хэлэлцээрэй.

Үрийн шимээр ургаж
Үндэсний сайнаар цэцэглэлээ
Төрсөн газар ууланд сан
Төлдрийн салхинд найгасан сан
Энэхэн бие минь
Цэнгэж л явна
Ивээлт уулынхаа оройд
Ээх наранд гялалзаж
Хүүхэд багачуудын баяр
Хүн бүхний баясгалан болов
- Зохиосон шүлгүүдээ дараах шалгуурын дагуу үнэлээд, сайжруулаарай.

Өөрийн үнэлгээний шалгуур	Тийм	Үгүй	Заримдаа	Сайжруулах шаардлагатай
Шүлгийн хэлбэрийг дуурайж мөр бүрийн үгийн тооны тэнцүү байдлыг харгалзаж зохиосон				
Шүлгийн эхлэл, сүүл хэсгийг ижил авиагаар холбосон				
Үгийг оновчтой сонгосон				
Зөв бичгийн дүрмийн алдаагүй бичсэн				

- Найруулан бичих чадвараа шалгах шалгуурыг хэрэглээрэй.

- Бичсэн зүйл чинь ойлгомжтой байна уу?
- Үг өгүүлбэр нэмэх үү? Ямар үг өгүүлбэр нэмэх вэ?
- Үг өгүүлбэр хасах уу? Ямар үг өгүүлбэр хасах вэ?
- Үгийн байрлал солих уу?
- Үг солих уу?

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ЭЗЭМШИХ ЧАДВАР:

УНШИХ ЧАДВАР

- Зохиолыг мэдэрч ойлгох, зохиолчийн үг сонголтын шалтгааныг тайлбарлах
- Өгүүлэгдэхүүнийг ялгах
- Сэдэв, гол санааг тайлбарлаж, үзэл бодлоо илэрхийлэх
- Дүрийн үг, үйлдлээс зорилгыг тодорхойлох
- Орчны дүрслэлийг тайлбарлах
- Уран дүрслэлийг тайлбарлах

ЯРИХ-СОНСОХ ЧАДВАР

- Зохиолын үйл явдлыг өөрийн үгээр ойлгомжтой ярих

БИЧИХ ЧАДВАР

- Зохиолын гол санааг алдагдуулахгүйгээр үйл явдлыг товчилж бичих

МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ



ӨГҮҮЛЛЭГ



ПҮРЭВИЙН ХОРЛОО (1917-2008)

Төрсөн нутаг: Эрдэмтэн зохиолч П.Хорлоо нь Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Нарийнтээл сумын зааг дээр орших Өшгигийн нуруу гэдэг газар төржээ.

Гол уран бүтээл: 1933 оноос уран бүтээлээ эхэлж, хүүхдэд зориулан “Хар унага”, “Говийн хүү”, “Багш” зэрэг олон зохиол туурвижээ. “Жаргалтай хүүхдүүд”, “Алт, Мөнгө хоёр”, “Туулайн бөжин”, “Нарны туяанд” зэрэг ном хэвлүүлснээс гадна “Алтан үст охин”, “Багш”, “Шидэт толь” зэрэг жүжгийн зохиол бичжээ.

Үгийн утгыг тайлбарлахдаа 27 дугаар хуудасны бүдүүвчийг хэрэглээрэй.

АЛТ, МӨНГӨ ХОЁР

Эрт цагт нэгэн эцгийн хоёр хүүхэд холын уулнаас мод түүж ирэхээр явах болжээ. Явахад нь эх нь хоёр хүүхдэдээ замдаа идэж яв хэмээн нэг нэг боодолтой ааруул эззгий өгөөд “Хоорондоо эвтэй, ах нь дүүгээ асарч яв” хэмээн захижээ. Ингээд хоёр хөвгүүн алсын замдаа гарчээ.

Энэ хоёр хүүгийн ах нь Алт, дүү нь Мөнгө нэртэй юм байжээ. Алт, Мөнгө хоёр замдаа хүйтэн шуургатай шөнө хээр унтах болжээ. Мөнгө нь хэлж гэнэ.

-Ах аа! Энэ хүйтэн шуургатай шөнө их даарна шүү! Хоёулаа хадны агуй олж унтахыг бодъё гэж хэлэв. Алт нь миний дүүгийн зөв, хоёулаа хоёр тийшээ явж агуй эрье. Чи энэ уулын өвөр лүү яв. Би өөдөө явъя, аль түрүүлж агуй олсон нь бие биеэ дуудъя гэв. Дүү нь зөвшөөрөөд хоёр тийш салаад, хоргодож унтах хадны агуй эрэхээр явцгаажээ.

Мөнгө хүүд хадан агуй ер олдсонгүй. Унтахаар нөмөртэй газар олоод ахыгаа дууджээ. Юу ч дуугарсангүй.

Алт нь уулын оройд гараад нэг дулаан агуй олжээ. Хэвтээд үзсэн чинь хоёр хүн арай багтахгүй болохоор би өөрөө дулаан унтвал бусад хүн хамаагүй гэж бодоод дүүгээ дуудсангүй, агуйн мухарт орж тавтай унтаж гэнэ.

Хэрвээ чи Алтын оронд байсан бол яах байсан бэ? Дүүгээ дуудах уу?

Мөнгө дүү нь яасан бол?

Мөнгө нь ахыгаа хэзээ дуудах бол гэж чагнасаар суутал тас харанхуй шөнө болж, цасан шуурган дунд нимгэн хөдсөн дээлтэй Мөнгө тачигнатал чичирч, даарахын эрхэнд ахыгаа олон удаа дуудсан боловч огт чимээ гарсангүй. Мөнгө хүүгийн гар хуруу чимчигнэн, хөлдөх шахаад байтал адуу эрж явсан өвгөн тааралдаж, арваад настай бяцхан Мөнгө хүүг дулаан дээлэндээ хучиж, хөлдөж үхэх аюулаас аварчээ.

Тэр ууланд чоно элбэгтэй юм байжээ. Хоёр чоно үдэш агуйгаас босож, шөнө айлуудын хот руу ан хийж яваад юу ч олсонгүй, өлссөндөө гутсаар үүрлэдэг агуйдаа иртэл агуйд унтаж байгаа бяцхан хүүхдийг хараад тоймгүй их баярлаж, хэл амаа долоож, идэхээр завдаж, хэн нь эхэлж барих вэ? гэж ярилцаж байжээ.

Мөнгө хүү өвгөн адуучны хүчээр дааралгүй хоносон боловч ахыгаа харанхуйд төөрөөд хөлдөж үхсэн болов уу гэж бодсоор үүрийн цагаан гэгээнээр босож, ахыгаа эрэн хадны агуйн дэргэд ирээд, агуй руу мөлхөж яваа хоёр чоныг үзээд, чанга дуугаар хашхиртал цогтой хүүгийн дуунаар чоно зугтаад явчлав.

Алт арай гэж сэрээд чонын барааг харж айсандаа уушги зүрх нь дэлбэрэх шахжээ. Ингэж ах дүү Алт, Мөнгө хоёр үүрээр уулзжээ.

Хэрэв Мөнгө нь ирж, олоогүй бол Алтыг чоно яах байсан бэ? Та нар сайн бодоорой. Энэ юунаас болов?

(“Монголын хүүхдийн богино өгүүллэгийн дээжис” УБ., 2017 он, 78 дугаар тал)



Унших чадвараа хөгжүүлье

Зохиолын утгыг ойлгосноо ярилцах

1. Алт, Мөнгө хоёрыг мод түүхээр явахад нь ээж нь юу гэж захисан бэ? Тэрхүү захиасыг хэн нь зөрчсөн бэ?
2. Хоёр хүү ямар зорилгоор салж явахаар болов?
3. Алт ах нь агуй олоод, юу бодов? Тэр зөв бодсон уу?
4. Мөнгө дүүд нь юу тохиолдов? Та нар түүнийг өрөвдсөн үү?
5. Хэрвээ та нар Алт ахын хамт явсан бол түүнд юу гэж хэлж, бас зөвлөх вэ?
6. Зохиолыг уншаад дууссаны дараа юу бодов?

Өгүүлэгдэхүүний бүтцийг ялгах

Бид бага ангидаа эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялгаж сурсан билээ. Одоо зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал, төгсгөл хэсгийг ялган тайлбарлахын тулд 66 дугаар хуудсан дахь түлхүүр нэр томъёог судлан уншаарай.

Бие даан бодож хариулах дасгал

1. Эхний догол мөрд ямар ямар дүрүүдийг зохиолч танилцуулсан бэ?
2. Эхлэл хэсгийн үйл явдал нь хаана болж байна вэ?

Багаараа хэлэлцэх дасгал

3. Юунаас болж үйл явдал өрнөсөн бэ? Дараах хариултаас сонгоно уу.
 - Хүйтэн шуургатай шөнө болсноос
 - Хадны агуй хайх болсноос
4. Дүрүүд хоорондоо зөрчилдсэн үү? Хэнд нь бэрхшээл учрав? Хэнд нь боломж гарсан бэ?
5. Чонотой хэсгийн үйл явдлыг дахин уншаад, хамгийн сэтгэл хөдөлгөсөн, үйл явдал нь цаашид өрнөхгүй байх вий гэж бодсон өгүүлбэрүүдийг сонгон ярилцаарай.
6. “Ингэж ах дүү Алт, Мөнгө хоёр үүрээр уулзжээ” гэсэн өгүүлбэр нь тайлал хэсгийг илэрхийлж байна уу?
7. Эдгээр 6 асуулт нь өгүүлэгдэхүүний бүтцийн дагуу зохиогдсоныг ажиглаарай.

Дүрүүдийн үг, үйлдлээс зорилгыг тодорхойлох

1. Агуйг олж, хамтдаа байя гэсэн тэдний зорилго биелсэн үү?
2. Ямар зан чанараас болж зорилгодоо хүрсэнгүй вэ?
3. Дүр бүрийн зан төрхийг дараах хүснэгтийг хэрэглэн тодорхойлоорой.

Зохиолын үйл явдал	Алт		Мөнгө	
	Хэлсэн үг, бодсон бодол	Хийсэн үйлдэл	Бодсон бодол	Хийсэн үйлдэл
Хээр хонох болоход				
Хадны агуй эрэхээр явахад				
Үүрийн гэгээтэй золгох үед				
Үүр цайх үед				
Чи энэ дүрийг хэрхэн үнэлж дүгнэж байна вэ? Яагаад?				
Та нар эдгээр дүрийн оронд байсан бол ямар үг хэлэх вэ? Ямар үйлдэл хийх вэ?				

Сэдэв, гол санааг тайлбарлаж, үзэл бодлоо илэрхийлэх

1. Зохиолын сэдэв, гол санааг тодорхойлоход аль хэлцийн утга илүү тохирч байгааг олж тайлбарлаарай.

Санаа зөв бол, заяа зөв Муу санаа эзнээ отно Ах нь сургаж, дүү нь сонсдог. Ахаа алд хүндэл Дүүгээ дэлэм хүндэл Аавын сургаалт алт Ээжийн сургаал эрдэнэ Мордохын хазгай болох	Нэг чихээрээ оруулаад Нөгөө чихээрээ гаргах Нэрээ хугалах Өөрийгөө хөөдөх Урмыг нь хугалах Хонио чоноор мануулах Хувь заяа нь хутганы ирэн дээр ирэх
--	--
2. “Хоорондоо эвтэй яв, ах нь дүүгээ асарч яв” гэснийг сонсоод Алт, Мөнгө хоёр юу бодсон бол?
3. Энэ зохиолыг бусдад ярихаар бол юуг нь онцолж ярих вэ?
4. Мөнгө ирж туслаагүй бол Алт яах байсан бол? Энэ юунаас болов? Ангидаа хэлэлцүүлэг зохион байгуулаарай.

Хэлэлцүүлэг зохион байгуулахдаа

- Бусдын хэлсэн үг, үзэл бодлыг няцаахгүй байхыг анхаарна уу.
- Өөрийн үзэл бодлоо илэрхийлэхдээ бусдынхаа үгийг таслахгүй байж, зэрэгцэж ярихгүй, бусдыгаа ярьж дууссаны дараа ярина уу.
- Өөрийн үг, үзэл бодлоо нуршихгүйгээр, богино хугацаанд цөөн үгээр илэрхийлээрэй.
- Бусадтай санаа давхацсан нөхцөлд давтахгүйгээр, шинэ санаа гаргахыг хичээгээрэй.
- Үзэл бодлоо илэрхийлэхдээ “Миний санаа туйлын зөв” гэсэн үзэл хандлагаас бус, миний бодлоор бол.... гэсэн үг хэллэгийг ашиглаарай.

ДАНИГАЙН ДАВААНЯМ



Төрсөн газар:

1943 онд Хөвсгөл аймгийн Жаргалант сумын нутагт төржээ.

Уран бүтээл:

“Ойн субботник”, “Өндөр өвөө”, “Жирийн түүх”, “Чихэр”, “Шинэ айл”, “Найман жаал”, “Зуун даага”, “Амьтдын үлгэр”, “Жаргалтай нутгийн хүүхдүүд”, “Өвөө хэдэн намтай вэ?”, “Цаасан хүү”, “Илжигний уралдаан” гэх мэт хүүхдэд зориулсан бүтээл туурвижээ.

ЗҮРХ ЦАГААН

Жинчид хол нутагт ачаа бараагаа тушаагаад буцаж явлаа. Шөнө дөлөөр нэгэн хот айлын хажуугаар өнгөрч байв. Гэтэл угсраа тэрэгний цаанаас том халтар нохой босон ирж, учир зүггүй боргоов. Далхаа тэр нохойд яс хаяж өглөө. Нохой олзоо шүүрэн авч харанхуй дунд уусан алга болов.

Тэгтэл зүүн жалганы наанаас зүрх цагаан нохой дайраад ирж гэнэ. Далхаа тэр нохойд яс хаяж өгөв. Зүрх цагаан улам ч догширч уул толгодыг доргиулан боргоож гарлаа. Далхаа тэр нохойд дахин нэг яс хаяж өгөв. Зүрх цагаан бүүр ч гаарч уул, нуруу, хөндий талыг доргитол боргоож амар заяа үзүүлэхгүй байлаа. Далхаа:

-Энэ чинь ёстой монгол нохойн үр сад байна. Удам чинь улам олшрог гэж баярлан хашхирав. Хажууд хүрэн ат унаад зэрэгцэн явсан Цэрэнхүү:

- Түрүүчийнх нь монгол удмын нохой биш үү гэхэд Далхаа:

- Биш ээ, биш. Олз олонгуутаа аваад таг чиг болчихдог тийм өчүүхэн амьтныг би хэзээ ч хүндэлдэггүй юм гэв.

(Монголын хүүхдийн богино өгүүллэгийн дээжис, УБ., 2017, 124 дүгээр тал.)



Унших чадвараа хөгжүүлье

Зохиолчийн үг сонголтын шалтгааныг тайлбарлаж, зохиолын утгыг мэдэрч ойлгох

Бие даан ажиллах дасгал

1. Үгийн утгыг тайлбарлана уу. 27 дугаар хуудасны бүдүүвчийг хэрэглэнэ үү.
2. Хүснэгтийн дагуу ажиллана уу.

Тайлбарлах үг	Чамд ямар мэдээллийг өгч байна вэ?	Ойр орчмын үг өгүүлбэртэй холбон ямар утгаар орсныг таамаглаарай.	Энэ үгийн ерөнхий утга нь юу вэ?	Өөр ямар утгыг агуулж болох үг вэ?
Зүрх цагаан				

3. Жинчин гэж юу хийдэг хүмүүс вэ? Багшаасаа лавлаарай.
4. Нохдын хийсэн үйлийг тоочно уу. Ялгаа нь юунд байна вэ?

Том халтар нохойн хийсэн үйлээс	Зүрх цагаан нохойн хийсэн үйлээс
Тэрэгний цаанаас босож ирсэн	Зүүн жалганы наанаас дайрсан
Учир зүггүй	Яс хаяхад
Ясыг	Уул толгодыг
Харанхуйд	Дахин яс хаяж өгөхөд
	Уул, нуруу, хөндий талыг
	Амар заяа үзүүлэхгүй байсан

5. Хоёр нохойн аль нь хоттой хонио сайн манана гэж бодож байна? Яагаад?
Яс өгөөд байхад Зүрх цагаан нохой дахин дахин боргоогоод байсны учир юу бол?

Багаараа хэлэлцэх дасгал

6. Монгол нохойн тухай та нар юу мэдэх вэ? Дараах бодомжийг ажиглаад, монгол нохойн тухай эргэцүүлээрэй.
- Хэрвээ эзнээсээ өөр хүний өгсөн ясыг аваад байсан бол хоттой хонио манаж чадах болов уу?
 - Хэрвээ Далхаа эзэн нь байсан бол өгсөн ясыг нь авах болов уу?
 - Зүрх цагаан нохой, том халтар нохой шиг яс авангуутаа алга болсон бол...?
7. “Харанхуйд уусан алга болов?” гэсэн өгүүлбэрийн утгыг та нар юу гэж ойлгож байна? Өөр үгээр солин найруулж болох уу?
8. Далхаа “Өчүүхэн” амьтан гэж ямар амьтныг хэлсэн юм бол? Та нар юу гэж бодож байна?

Зохиолын агуулгыг ойлгосноо ярилцаж, сэдэв, гол санааг тайлбарлах

1. Зохиолын сэдвийг зөв тодорхойлсныг сонгоно уу.
 - Зоригтой зүрх цагаан нохойн тухай
 - Эзэндээ үнэнч монгол нохойн тухай
 - Хоёр өөр нохойн тухай
2. Энэ өгүүллэгийг өөр хэн нэгэнд ярихаар бол ямар асуудлыг онцолж ярих вэ? Ямар жишээ татах вэ?

Гол санааг тайлбарлахдаа

1. Зохиолч уншигчдад юуг хэлэхийг хүссэнийг ярилцаарай.
2. “Том халтар нохой” гэж зохиолыг нэрлээгүйн учрыг тунгаан бодно уу.
3. “Олз олуут аваад таг чиг болчихдог тийм өчүүхэн амьтныг би хэзээ ч хүндэлдэггүй юм” гэж хэлсэн Далхаагийн хэлсэн үгийг эргэцүүлээрэй.

Орчны дүрслэлийг тайлбарлах

1. Ноход хаана, хаанаас гарч ирсэн бэ? Орчноос нь түүний тухай мэдээллийг таамаглаж болох уу? Таамаглан бичээрэй.
2. Зохиолч нохдын дүрийг тодруулан гаргахын тулд ямар ямар үгийг сонгож хэрэглэсэн бэ? Далхаагийн дүр болон нохдын дүр дээр тогтож ярилцаарай.



ЧАДРААБАЛЫН ЛОДОЙДАМБА (1917-1970 он)

Төрсөн газар: Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт төржээ.

Уран бүтээл: «Алтайд», «Тунгалаг тамир» роман, «Манай сургуулийнхан» тууж, «Малгайтай чоно», «Солонго», «Дусал нулимс юу гэж хэлсэн бол» зэрэг олон арван шилдэг өгүүллэг бичсэнээс гадна «Гарын таван хуруу», «Өөрийн замаар», «Итгэж болно» драмын жүжиг, «Энэ хүүхнүүд үү» кино зохиол туурвижээ.

Уншихын өмнө

1. Хүүхдүүд ээ! “Шаргачин” хэмээх зохиолд юуны тухай өгүүлэх бол? Баг болж, дараах түлхүүр үгсийг ашиглан, зохиолын үйл явдлыг таамаглан ярилцаарай.

Ашиглах үгс: Зээр, шаргачин, янзага, архи, хурдан буу, мөндөр шиг сум, зугаа цэнгэл, машин, тэмцэл, байгаль, ан амьтан, хайр, нинжин сэтгэл, эх үр хоёр, хагацал, хүний мөс чанар

2. Хэсэг тус бүрийг уншсаны дараа тохирсон гарчиг, нэр өгөөрэй.

ШАРГАЧИН

(Өгүүллэг)

Хаврын хурц нар нэлээд дээр мандаад ойр орчмыг хөхөмдөг манан бүрхэж өргөн талд байгаа юмс цөм зэрэглэн жирвэлзэж байлаа. Цайдам хөндийн зүүн зах нь болсон хэсэг дэрс рүү эхээс гараад хэдхэн хоносон цайвар цагаан янзага дагуулсан шаргачин орж ирлээ.

Янзага нь тонгочин тоглож орчин тойронд өөрөөс нь өөр юмгүй мэт бүхнийг мартан явахад эх нь тал бүр сэрвэлзэн өчүүхэн чимээг ч сэрэмжлэн чагнаж нүдэнд нь торсон бүхнийг «Юу вэ? Яах гэж байна?» гэсэн бололтой нарийвчлан ажиглаж явлаа. Уураг нь дуусаагүй өөг сүүндээ гэдэс нь цадсанаас ч юм уу нялх бие нь тоглоомдоо ядарснаас ч юм уу, аль зуу зуун жилээр үргэлжилсэн хатуу амьдралын сургаал ч юм уу, бүү мэд. Юу ч гэсэн дэрсэнд орсны дараа янзага нь удалгүй нуугдан унтав.

Ер нь шаргачин өдрийн цагт нялх янзагаа бут буюу дэрсэнд хяруулж нуугаад өөрөө шинэхэн ургасан ногоо чимхлэн иддэг. Энэ үед ямар нэгэн аюул ирвэл хурдан хөлийн хүчээр дагуулан зугтаж төөрүүлээд эргэж ирэхэд, унтаж хоцорсон үрдээ аюулыг зайлуулсан баярт уулзалтаар цэцэглэсэн амьдралаар амтлагдсан сүүгээ өгдөг. Янзагаа нуусны дараа шаргачин зүг бүр гоо чихээ соотгонуулан дээр дээр үсрэн тоглодог. Энэ үед нь түүнийг бүжигчин хүн харвал уран хөдөлгөөний хуримтлал болсон гоёмсог хөдлөлийг тусган авах нь дамжиггүй билээ. Нөгөө шаргачин цовхрон харайлан дэгдэж хэсэг тоглоод хурц үнэр нь хамар луу цоргин соёолж байгаа нялх тааныг амтархан идэв.

Эхний хэсгийг уншаад чамд ямар мэдрэмж, сэтгэгдэл төрсөн бэ? Өөрийнхөө мэдрэмжийг найз нөхөд болон багшдаа илэрхийлэн яриарай. “Баяртай, аз жаргалтай, эрх чөлөөтэй, дураараа, тайван, амгалан, эрх дураараа, хайраар бялхсан, амьдралын баяр баясал, хүн байгалийн хүйн холбоо” гэсэн үгсээс хэрэглэн илэрхийлээрэй.

Гэтэл шаргачны хажуугаар гарсан замаар жолоочоос гадна гурван зугаалагч суусан машин тоос манаруулан давхиж ирлээ. Хурдлан яваа машин дотор архины эхүүн үнэр, тамхины

гашуун утаатай холилдон ханхалж, жолоочийн ар талд суусан хүнээс бусад нь нэлээд согтсон тул нүд нь чиглэсэн юмгүй гөлөлзөн эргэлзэж, толгой нь моторын жигд ажиллагаатай цохилт нийлүүлэх гэсэн юм шиг хаялан ганхаж явлаа. Хэрэв жолоочийн хажууд суугч тамхиа ноцоох хэрэг гараагүй бол шаргачин эх үр хоёр гашуун зовлонд учралгүй өнгөрч болох байсан билээ. Гэтэл тамхиа ноцоолгох гэж жолооч руу эгцлэн харсан нүдний нь үзүүрт талд идэж байгаа ганц шаргачин харагдав.

-Зээр гэж хашхирахад яг хойно нь суугч ухасхийн:

-Хаана? гэж хариу хашхираад нойрмог нүдээр тал бүхэн рүү харлаа.

-Янзагатай шаргачин бололтой. Тэгээд ч өдийд цаазалсан шүү дээ гэж жолоочийн ард суугч хэлэв.

-Зугаалж яваа бидэнд ямар хамаатай юм бэ! Буудаж л байвал барав. За бэлтгээрэй гэж жолооч нь хэлээд машинаа эргүүлж чимээнээс цочин сэрэмжилсэн шаргачны зүг хурдлан давхилаа.

-Хууль биелүүлэхийн тулд гарсан хуулийг харин биелүүлэхгүй бол хариуцлага байдаг шүү дээ гэж жолоочийн ард суугч хэлсэнд:

-За энэ чинь хууль хамгаалагч гарав бололтой гэж жолоочийн хажууд суугч хэлээд их хөгжилтэй инээснээ:

-За хөөгөөд гэж хэлэв.

*Жолоочийн ард суугч юу гэж хэлсэн бэ? Жолоочийн хэлсэн үг зөв үү?
Зохиол цаашаа яаж үргэлжлэх бол? Эх үр хоёрт юу тохиолдох бол?*

Уул талд янзага нь унтаж байгаа тул ирж байгаа аюулыг холдуулан зайлуулах гэж шаргачин өргөн цагаан тал руу дэгдэн үсэрч, гоо чихээ босгон солбиж, цойлон давхив.

Цонхоор нь буунууд шоролзон гарсан машин, зээрийн хойноос байдаг хурдаар довтлон ирлээ. Хурдан хөлдөө **гүн итгэсэн** шаргачин дүүлж **дөрвөн хөл нь газар хүрч байгаа эсэх нь үл мэдэгдэн** хурдлав.

Гэвч энэ удаа түүний хойноос эцэстээ эцдэг булчин шөрмөстэй амьтан хөөж байгаа биш эцэх цуцахыг үл мэдэх хурдан хөлөг унаж, будаан сумаар зэвсэглээд, гүйцэгдэхгүй зугтаж байгаа зээрийг юу болсон ч алах ангийн шунал оргилсон дайсан мөрдөж яваа тул хэдий хүч тавин хурдлавч холдож хоцрохгүй харин улам ойртов.

Буу зогсолтгүй шахам нижигнэж машины дохио чимээ үргэлжлэн дуугарч шаргачны үсрэн цойлох нь ховордон, цэлмэг нүд нь бүлтгэнэн манантаж, босоо чих нь алгуураар хойшоо бууж байлаа. Машин дотроос «Хар барам чинь оногдохгүй нь. Ёо ёо ямар их донсолдог юм бэ? Толгой хагалчих нь, аль вэ сум аваад аль. Өмнө нь барьж байгаад мулталж орхи. Аа мондиос болж гараа шалбалж орхилоо. Чамайг уу даа» гэх зэрэг дуу сонсогдож байлаа.

Шаргачин яагаад өргөн тал руу цойлдон давхив? Янзага руугаа очихгүй байхын шалтгаан юу байв? Шаргачныг хөөх үед та нар хамт явсан бол юу гэж хэлэх байсан бэ?

Гагцхүү жолоочийн ард хөдлөлгүй суугаад хөмхийгөө зуун салхинд бага зэрэг гандсан нүүрээ барайлган, барьж ядсан заналхийлэл нүдэнд нь туяарсан нэг хүн дуугаралгүй «Толгойгоо цохих гараа шалбалах чинь юу ч биш. Харин гэмгүй амьтны амьдралаар хууль зөрчиж тоглон эрхлэх чинь л дэндэж байна» гэж сэтгэлдээ дахин дахин шивнэн явжээ. Үнэндээ хөөгчдөд энэ явдал богино хугацааны **хөгжилтэй тохиол** байсан бол шаргачинд хоёр амины төлөө хийж байгаа **ширүүн тэмцэл** байжээ.

Шаргачин уул руу зугтсан бол өдийд мөрдөгчөөсөө салж, хөшсөн булчингаа амраагаад хярсан үр лүүгээ гэлдрэн явж болох сон билээ. Гэтэл шаргачин хөөх тусам зах хязгаар нь үл

мэдэгдэх өргөн талын гүн рүү тэмүүлж байв. Хэчнээн километр хөөснийг хэн ч хэмжсэнгүй. Хэд дахин буудсаныг хэн ч тоолсонгүй. Эцэстээ шаргачин хоёр чихээ шилэндээ нааж амаа ангайн богинохон сүүлээ хавчин **давлан** урсах жигд хөдөлгөөнөө алдаж, өндгөнөн цогих буюу заримдаа бүр шогшдог болов. **Будаан** сум цайран эхэлж байгаа бөгсийг нь **сийчин** оноод **ухаа ягаан цус хонгыг нь дагаж** урсан эхлэв.

Гэвч шаргачин сүүлчийнхээ хүчийг дайчлан харайсаар байв. Амьдралдаа хэд хэдэн янзагыг бойжуулан торниулж түмэн бэрхшээл мянган саадыг давж гарсан энэ шаргачин, хөөсөн дайсныг хурдан хөлийнхөө хүчээр зайлуулаад унтсан үрдээ эргэн очиж байсан удаа олонтоо нь эргэлзээгүй. Учир нь зээр ямар ч амьтанд өчүүхэн ч хор хүргэдэггүй боловч түүний дайсан мундах биш дээ.

-Сум байна уу? гэж хашхирах дуу машин дотроос хэд дахин сонсогдсоноо хэсэг чимээгүй болоод цонхоор арзайн гарсан буунуудаа татаж аваад хөл рүүгээ хаяцгаав.

-За одоо яадаг билээ гэж нөгөө жолоочийн дэргэд суугч хоосон буугаа хажуу тийшээ хаях зуур хэлэв.

Хүүхдүүд ээ! Шаргачин гэж ямар амьтан бэ? Дараах мэдээллээс уншиж мэдээрэй.



Цагаан зээр нь Монгол орны өмнө, дорнын уудам тал, ухаа толгодоор идээшиж бэлчдэг. Зээрийн сүрэг Их нуурын хотгорын өмнөд хэсэг, нууруудын хөндий, зүүн гарын говь, Алтайн өмнөх говь, Өмнөговь, Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудын нутгаар тархсан. Цагаан зээрийн **эрэгчнийг** ооно, **эмэгчнийг** шаргачин, **төлийг** янзага гэнэ. Зургаадугаар сард үр төлөө гаргадаг. Янзага нь хоёр долоо хоногийн дараа эхийгээ дагаж, 8-10 хоногийн дараа өвс, ногоо идэж чаддаг байна.

Цагаан зээр үет ургамлаар хооллодог, нэг газар удаан амьдардаггүй, бэлчээрийн соргогийг даган, хэдэн арван км аялал хийдэг. Сонсгол сайтай, маш хурдан амьтан бөгөөд цагт дунджаар 55-62 км туулж чадна. “Монгол орны улаан” номын усташ аюулд орсон ба орж болзошгүй амьтан, ургамлын жагсаалтад бүртгэгдэн, 1965 оноос агнахыг хуулиар хориглосон байна.

-Муу золигийг дайруулж орхиё гэж жолооч хэлээд хурдаа нэмлээ.

Амьд гарч янзагандаа эргэн очоод **язарч чинэрсэн** дэлэнгээ хөхүүлж **учралаар гэрэлтсэн** хайраар янзагынхаа **годгонон тоглож** байгаа **жижигхэн сүүлийг** үнэрлэх **хүсэл их боловч** хөшиж зангирсан хөл нь урагшаа хөдлөхгүй болоод бүх бие нь салганан, амьсгал нь **цээжиндээ багтахгүй оволзон**, саяхан үзэсгэлэн болон сэрвэлзэж байсан хоёр чих нь **дараа болон дэлдгэнээд**, эцсийн эцэст өөрийн эрхгүй **сөгдөн шургачиж** хэвтлээ.

Машин зогсож, хэдэн цаг зугтаж зовоосон зөрүүд муу шаргачин амьдаараа гарч орох болсонд баярласан хоёр инээлдэн гарч ирлээ. Хэрэв сувай шаргачин буюу ооно байсан бол хөшиж нугараад мод болсон хөлөө хүчлэн тэнийлгэж босоод зугтаж чадахгүй байсан биз ээ. Гэвч энэ шаргачин тийм биш болохоор ухасхийн босоод манаран хөхөрч байгаа нүдээ бүлтгэнүүлэн шогшив. Тэд явгалан хөөсөн боловч барьж чадсангүй. Гүйцэгдэхгүй байгаад нь уурлан бухимдаж, том том чулуугаар шидсэн боловч оносонгүй. Тэгээд тэд хараал тавин буцаж машиндаа суугаад дахин хөөв. Шаргачин дахин шурган сөгдөн хэвтэв. Машин түүний дээгүүр өнгөрөхдөө өрөөсөн дугуйгаараа дайрлаа. Машин эргэж зогсоход түүнээс анчид гүйцэгддэггүй шаргачныг босох чадалгүй болгосондоо баярлан инээлдэж хөгжил болон гарч ирлээ. Тэрийн хэвтсэн бөгөөд бүх бие нь үхлийн өмнөх чичрэлтээр татганаж байгаа шаргачин эцсийн хүчээ дайчлан янзагаа нуусан зүг рүү амьдралын оч орхин хаяж байгаа нүдээр харлаа.

-Гүйцэгдэхгүй, оногдохгүй байх чинь яав? гэж нэг нь хэлээд нөгөө нэг нь шаргачны дэргэд ташаагаа тулж ханхалзан зогсоход шаргачин дахин өндийж янзага нь амгалан сайхан унтаж байгаа зүг рүү дахин харах гэтэл хүнд төмөр манивил толгой руу нь тас хийтэл бууж, эцсийн амьсгал нь тасрав. Жолооч нүд рүү нь манивилын үзүүрээр хатгаж үзсэнээ:

- Талийгаач болжээ гээд өврөөсөө хيام гаргаж зулгаан идлээ.

Шархадсан шаргачны байдлыг ямар үг хэрэглэн дүрсэлсэн байна вэ?

Хамгийн өрөөдөлтэй санагдсан хэсгийг сонгон ярина уу.

Энэ хүртэлх хэсгийг унших явцад юу бодогдож байна вэ?

Шаргачны чинэрсэн дэлэнгийн хоёр хөх нь зугтахын өмнө сэрвэлзэн, соотгонож байсан хоёр чих шиг нь босож сэрийгээд түүнээс шахагдан гарч байгаа цагаан шаргал сүү нь элсэрхэг хөрсөнд шингэн орж борлуулан байлаа.

Жолоочийн дэргэд суугч хөдлөлгүй хэвтэж байгаа шаргачныг өшиглөн хөрвүүлснээ:

-За явъя. Туранхай хөхүүл шаргачнаар юу хийх юм. Тарган сан бол оноо засааг нь чанаж, өөх үмхэх юмсан. Чамд юм үлдсэн үү гэхэд нь нөгөө нь:

-Хагас шил юм үлдсэн гээд ягаан цус шүүрч байгаа шаргачин руу ажиглан харснаа мөн догь буудаж шүү гээд бардам гэгч нь инээмсэглэв.

Тэгээд тэд машиндаа сууж явахдаа жолоочийн хажууд суугч:

- Ярих сонинтой боллоо гэж хэлэхэд:

“Хууль зөрчсөн та нартай ярих юм надад бүр ч их бий” гэж жолоочийн ар талд суугч боджээ. Машин тоос татуулан хурдалж далд орлоо. Дээр мандсан нарны гэрэл шаргачны дээрээс жигнэн, ямар ч анир чимээгүй өргөн тал мэлтийн, тэнгэрийн хаяанаас том гэгчийн хар тас алгуур дэвсээр улам тодрон гарч ирлээ.

(Ч.Лодойдамба, Шаргачин, УБ., 2007, Интер пресс хэвлэлийн газар)



Унших чадвараа хөгжүүлье

Зохиолчийн үг сонголтын шалтгааныг тайлбарлаж, зохиолын утгыг мэдэрч ойлгох

Бие даан хийх дасгал

1. Төгсгөлийн хэсгийг уншаад та нар юу мэдрэв? Яагаад?

Өөрийнхөө мэдрэмжийг найз нөхөд болон багшдаа илэрхийлэн яриарай.

Эмгэнэлтэй, өрөвдмөөр, өр өвтгөм, харуусалтай, харамсмаар, уйлмаар, үзэн ядмаар, сэтгэл өвдмөөр, элэг эмтрэм, нүгэл нүдээрээ гарах, ухамсар, хүний ёс, нинжин сэтгэл, хатуу сэтгэл, хүний үнэргүй зан, хайрлан энэрэх гэх мэт үгсийг хэрэглээрэй.

2. Аль хэсэг чамд хамгийн гүн сэтгэгдэл төрүүлэв? Зохиогч энэ хэсгийг ямар үгээр дүрслэн гаргасан байна вэ?

Багаараа хэлэлцэх даалгавар

1. Тодруулсан үгсийг ажиглаарай. Зохиолч яагаад эдгээр үгийг сонгон хэрэглэсэн юм бол? Энэ тухай ярилцахдаа баг болон ажиллаарай. Баг бүр нэг өгүүлбэрийг сонгон, доорх асуултын дагуу ярилцаарай.

- Уншигчдад юуг хэлэхийг хүсэж, зохиолч энэ үгийг хэрэглэсэн юм бол?
- Энэ үгийг сонгож бичсэн нь оновчтой байна уу?
- Энэхүү үг зохиолын агуулга, утга санааг тодруулахад хэр нөлөөлж байна вэ?
- Хэрвээ чи зохиолчийн оронд байсан бол энэ үгийг сонгон хэрэглэх байсан уу?
- Өөр үгээр солин найруулж болох уу?

Зохиолын агуулгыг ойлгосноо ярилцаж, сэдэв, гол санааг тайлбарлах

1. Шаргачин хэний төлөө, юуны төлөө амиа алдав?
2. Шаргачин хүмүүсээс зугтаж байхдаа юу бодсон бол?
3. Шаргачныг хөнөөсөн хүмүүс хариуцлага хүлээх ёстой юу? Та нар ямар санал дэвшүүлэх вэ?
4. Ийм үйлдэл хийж болохгүй гэдгийг хэрхэн ухааруулж, ойлгуулах вэ?

Дүрүүдийн зан төрхийг ярилцан тодорхойлох

1. Багаараа хэлэлцэх дасгал

№	Дүрүүд	Зохиогчийн дүрслэл		Энэ дүрийг хэрхэн үнэлж, дүгнэж байна вэ?
		Үйл хөдөлгөөн	Бодол	
1	Шаргачин			
2	Янзага			
3	Жолооч			
4	Жолоочийн хажууд суугч			
5	Жолоочийн ард суугч			
6	Ард суугч			

2. Баг бүрийн илтгэгчийг дараах шалгуураар үнэлж, ангийнхаа шилдэг илтгэгчийг шалгаруулаарай.

№	Үнэлгээний шалгуур	Үнэлгээ 1-5
1	Ярьж буй асуудлынхаа чухал зүйлийг олж, үндэслэлтэй ярьж буй эсэх	
2	Яриа нь дэс дараалал, эмх цэгцтэй эсэх	
3	Үг хэллэг нь оновчтой эсэх	
4	Ярианы хурд зохистой эсэх	
5	Өөртөө итгэлтэй байгаа эсэх	
6	Зохиолоос баримт, эшлэл ашигласан эсэх	
7	Сонсогчдын анхаарлыг өөртөө татсан эсэх	

3. Хүүхдүүд ээ! <https://www.youtube.com/watch?v=ebu71MN28iU> линкээр орж, байгаль хамгаалах сангийн тэтгэлгээр “Макс Фрейд” студид бүтээсэн “Шаргачин” богино хэмжээний киног үзэж, дүр бүр дээр хийсэн дүгнэлтээ баталгаажуулаарай.



Орчны дүрслэлийг тайлбарлах

Түлхүүр нэр томъёо

“Зохиолын орчин нь тухайн зохиолын үйл явдал хаана, хэзээ болж байгааг илэрхийлдэг. Орчин нь үйл явдал болж буй газар, орон байр, цаг улирал, цаг хугацаа, цаг агаарын байдал зэргээс бүрддэг.

1. Зохиолч орчныг яаж бүтээсэн бэ?

Орчин (Орон, цаг)	Зохиолын үйл явдал нь:	Зохиолч энэ хэсгийг ямар үгээр, хэрхэн дүрсэлсэн байна вэ?
Хаана болж байна вэ?		
Хэзээ болж байна вэ?		
Цаг агаар, байгаль дэлхий ямар байсан бэ?		

2. Зохиолын эхлэл ба төгсгөл хэсгийн орчны дүрслэлийг харьцуулан, юуг мэдэрснээ илэрхийлээрэй.

Зохиолын эхлэл хэсэг			Зохиолын төгсгөл хэсэг		
Зохиогчийн дүрслэл	Орчны дүрслэлийг уншаад чамд ямар мэдрэмж төрөв? Аймшигтай, хөгжилтэй, амар амгалан, жаргалтай, баяртай, гунигтай, харамсалтай аль нь вэ?	Яагаад?	Зохиогчийн дүрслэл	Орчны дүрслэлийг уншаад чамд ямар мэдрэмж төрөв? Аймшигтай, хөгжилтэй, гашуудам, ерөвмөөр, баяртай, уйтай, гунигтай, харамсалтай аль нь вэ?	Яагаад?
Янзага нь тонгочин тоглож орчин тойронд өөрөөс нь өөр юмгүй мэт бүхнийг мартан явахад нь эх нь тал бүр сэрвэлзэн өчүүхэн чимээг ч сэрэмжлэн чагнаж нүдэнд нь торсон бүхнийг «Юу вэ? Яах гэж байна?» гэсэн бололтой нарийвчлан ажиглаж явлаа.			Дээр мандсан нарны гэрэл шаргачны дээрээс жигнэн, ямар ч анир чимээгүй өргөн тал мэлтийн, тэнгэрийн хаяанаас том гэгчийн хар тас алгуур дэвсээр улам тодрон гарч ирлээ.		

- Эх үр хоёрын жаргалтай байгаа хэсгийг зохиолч ямар үгээр дүрсэлсэн бэ?
- Аюул тохиолдохоос өмнөх эх үр хоёрын амар амгалан байдал, байгаль дэлхийн байдлыг зохиолч ямар үгээр дүрсэлсэн бэ?
- Аюулд орсны дараах гунигт байдлыг зохиолч ямар үгээр дүрсэлсэн бэ? Эхийгээ эндсэнийг янзага мэдэж байгаа болов уу? Мэдээд яах бол?
- Анир чимээгүй тал, хар тас хоёрыг зохиолын төгсгөлд дүрсэлсний учир юу вэ?

Өгүүлэгдэхүүний бүтцийг ялгах

Хүүхдүүд ээ! “Шаргачин” өгүүллэгийн өгүүлэгдэхүүний бүтцийг хэрхэн ялгасныг анхааралтай уншиж үзээд, дараачийн зохиол дээр бие даан ажиллаарай.

Өгүүлэгдэхүүний бүтэц	Хэрэглэх асуулт	Тодруулсан нь
Эхлэл	Юуны тухай танилцуулж байна вэ? Байгалийн ямар байдлыг ямар үгээр бичсэн бэ? Дүрээ тодруулахдаа ямар үгийг хэрэглэсэн бэ?	Хаврын хурц нар нэлээд дээр мандаад ойр орчмыг хөхөмдөг манан бүрхэж өргөн талд байгаа юмс цөм зэрэглэн жирвэлзэж байгаа байгалийн байдлыг зураглан үзүүлсэн байна. Янзагаа нуусны дараа шаргачин зүг бүр гоо чихээ соотгонуулан дээр дээр үсрэн тоглож буй байдал, янзага шаргачин хоёрын тайван, жаргалтай байгаа байдлыг эхлэл хэсэгт харуулжээ.
Зангилаа	Үйл явдал юунаас болж эхэлж байна вэ? Гол үйл явдал өрнөх шалтгаан нь юу байна вэ? Хэрвээ ийм зүйл болоогүй байсан бол үйл явдал цаашид өрнөх байсан болов уу?	Хэрэв жолоочийн хажууд суугч тамхиа ноцоох хэрэг гараагүй бол шаргачин эх үр хоёр гашуун зовлонд учралгүй өнгөрч болох байсан билээ. Гэтэл тамхиа ноцоолгох гэж жолооч руу эгцлэн харсан нүдний нь үзүүрт талд идэж байгаа ганц шаргачин харагдсан нь зохиол өрнөх, шаргачныг намнан хөнөөх шалтгаан болж байна.
Өрнөл	Баатруудад юу юу тохиолдов? Зохиолын үйл явдал хэрхэн өрнөв? Баатруудын зөрчлийг яаж үзүүлэв? Баатрууд юу ярилцав? Баатруудад ямар бэрхшээл учрав? Тэдэнд боломж байсан уу?	Амьтныг хайрлах сэтгэлгүй муу хүмүүс шаргачныг агнах гэж улайран дайрч байгаа үйл явдал, өөрийн үр лүү хандуулахгүй гэсэндээ зүг буруулан амь тэмцэн зугтаж байгаа үйл явдал нь өрнөл хэсгийг бүтээжээ.
Туйл	Цаашид үйл явдал өрнөх боломжгүй болсныг яаж бичив?	- Гүйцэгдэхгүй, оногдохгүй байх чинь яав? гэж нэг нь хэлэхэд ... шаргачны эцсийн амьсгал нь тасрав. Шаргачны эцсийн амьсгалаа хурааж буй хэсэг нь зохиолын туйл хэсгийг илэрхийлж байна.
Тайлал	Үйл явдал өрнөсөөр юу тайлагдав? Зохиолчийн хэлэх гэсэн санаа тайлагдав уу?	“За явъя. Туранхай хөхүүл шаргачнаар юу хийх юм. Тарган сан бол оноо засаг нь чанаж, өөх үмхэх юмсан... Мөн догь буудаж шүү гээд бардам гэгч нь инээмсэглэв” гэсэн хэсэг буюу шаргачныг ямар ч зорилгогүйгээр буудсан нь тодорхой болсон хэсэг. Ан амьтныг хайрлах сэтгэлгүй хүмүүс тэднийг алж идэхийн төлөө ч биш, наргиж зугаацахын төлөө амьтны амь хороож байгаагаар үйл явдал тайлагдаж байна.
Төгсгөл	Хэрхэн төгсөв?	Дээр мандсан нарны гэрэл шаргачны дээрээс жигнэн, ямар ч анир чимээгүй өргөн тал мэлтийн, тэнгэрийн хаяанаас том гэгчийн хар тас алгуур дэвсгээр улам тодрон гарч ирлээ гэсэн хэсэг. Цэлгэр талд тас шувуунаас өөр үзэгдэх зүйлгүй болж төгсөж байна.



ЛУВСАНГИЙН ОДОНЧИМЭД (1942-2016)

Төрсөн газар: Дорноговь аймгийн Дэлгэрэх суманд төржээ.

Уран бүтээл: “Чулуу иддэг жаал”, “Хоржоонтой дурсамж”, “Ээжтэй орчлонгийн наран”, “Наран ивээлт нутаг”, “Нарны хэлтэрхий”, “Хоржоонтой дурсамж-1”, “Хоржоонтой дурсамж-2”, “Нарлаг хорвоогийн жимээр” гэсэн бүтээлийг багц болгон хэвлүүлжээ.

1. Мэдэхгүй үгийг зохиолоос олж, тэмдэглээрэй.
2. Мэдэхгүй үгээ ойр орчмын үг, өгүүлбэрээс нь хажууд суугаа найзтайгаа таамаглан ярилцаарай.
3. Толь бичгээс тухайн үгээ хайж, олон утгатай үг байвал аль утгатай нь дүйж байгааг олж, дэвтэртээ тэмдэглээрэй.
4. Мэдсэн үгээ өөрийнхөө таамаглалтай харьцуулан, хамтрагчтайгаа дүгнэн ярилцаарай.

ХҮҮХДИЙН БОР

(Өгүүллэг)

Хүрэнтэн ягаарах бударгана, шар модны товцог холилдон багсайж, хоорондуур нь нялх хүүхдийн зулайн үс шиг шингэн зөөлөн хургалж, халиуран ургасан бяцхан хөндийг Хүйсийн говь гэх. Биднийг бага байхад манайх гэдэг айл энэ ширээ шиг тэгш хөндийн дөрвөн талд нь ээлжлэн нүүж, эргэх улирлыг бардаг сан. Хүйс гэдэг нь хар шилбээр зангидсан малгайн оройн сампин шиг барзгар бяцхан овоо. Тэр овоо бол миний хүн болсоор анх орой дээр нь гарч үзсэн хайрхан уул. Хүйс дээр гараад харахад тэр хавийн бүхий л бараа алган дээр тавьсан юм шиг торойн үзэгдэнэ. Хүйсийн овооны чанх араас буурын шилний бохь шүүрэн дааварлах адил бяцхан булгийн дэргэд чухам хэзээ хэн гаргасныг хэн ч үл мэдэх, тонгойгоод гараа сунгахад хүрмээр ойрхон татлагатай худаг байна.

Зуны аагим халуунд асгар дээр нь хар ялаа бас олон өнгийн шумуул шавах. Хүйсийн худаг дээр ирж, дэвтээсэн гүзээ шиг ширэн ховоогоор нь чадлынхаа хэрээр ус татаж, шүдээ хага ташуулан уугаад, бас бяцхан түнжгэр толгойгоо норгож шавшаад, Хүйс дээр гарч малынхаа барааг харчхаад, бор атандаа мордон алхуулж явахад нэг ёсны жаргал байдаг сан. Урд бөх нь зөв тийшээ, хойд бөх нь буруу тийшээ солбисон бор ат бол ах дүү бид зургааг зогдрөө дэвсэж өсгөсөн, хонь хурганы унаанд ээлжгүй зүтгэдэг гулуузан хөх тэмээ. Бид зургаа балчирхан байхдаа тэр номхон амьтны дөрвөн хөлийнх нь хоорондуур гүйлдэж, сөөглөн хэвтүүлж, хажууд нь араг тавин, буруу зөв талаас нь авирч байхад “Та нар эрхэл, эрхэл” гэх шиг гув ч гэхгүй нулимс гүйвгэнэсэн тунгалаг дөлгөөн нүдээ хааяа нэг цавчиж байдаг сан.

Зуны нозоором халуунд бид зургаа Хүйсийн худаг дээр очиж, хүйтэн усаар тоглох гэж бор атаа хэвтүүлээд мордоход хоёр бөхнийх нь хооронд бүгдээрээ багтахгүй болохоор зарим нь хүзүүн дээр нь мордож, хамгийн сүүлчийнх нь хойд бөхийг нь тэвэрч, арагш харж суугаад явцгаадаг сан.

Намар болоход манайх сумын төвөөс холгүй буугаад бор атандаа тэрэг хөллөж, сургуульдаа явцгаана. Өглөө сургуулийн гадаа буугаад, бор атныхаа бурантгийг эвхэж, гэрийн зүг харуулаад

хөдөлгөхөд өөрөө шулуухан яваад харьчихна.

Мал юм болохоор хөөрхий минь хааяа замдаа ганц хоёр удаа өвс шүүрдэг л байсан биз. Ээж минь бор атандаа биднийг даатгаад харж суудаг сан. Нэг өглөө биднийг хүргэсэн бор ат үд болтол харьсангүй.

Гайхаж цөхөрсөн ээж мориор тосож очиход тэрэгнийх нь өрөөсөн дугуй мухар эргэнд зоогдчихсон, бор ат маань “Хэн ирж туслах юм бол доо” гэсэн шиг алсыг хараад зогсож байсан гэдэг. Түүнээс хойш явсан мөрийг нь үзэхэд нөгөө мухар эргээс нэлээд холуур тойроод гарчихдаг болсон байсан. Манай нутгийнхан бор атыг маань андахгүй “Хүүхдийн бор” гэцгээх.

“Хүүхдийн бор” Хүйсийн худаг дээр ирж байна. Ус уугаад баруун тийшээ гарвал буцаах юм шүү гэж ярилцаж байтал худаг дээр ирэнгүүт бор атнаас баахан хүүхдүүд буугаад торхонд ус хийж эхэлж билээ гэж саахалт айлынхан хуучилна. Холоос харахад бид бөхнөөс нь ялгарч харагдахгүй байсан хэрэг.

1. Хүйсийн говь гэж ямар хөндийг хэлсэн бэ?

2. Хүйсийн овоог юутай адилтгасан бэ?

3. “Хүүхдийн бор” гэж ямар амьтныг хэлэв? “Би баатар” бор атны тухай хэрхэн дурсав?

Гэтэл манай нутагт нэгдэлжих хөдөлгөөн гэгч үүслээ. Малаа нэгдэлд нийгэмчлэх тухай бөөн яриа болж, цагаан баадантай данс, сампин бүсэлсэн “Нийбүү” хэмээх хүмүүс айл айлаар эргэлдэх боллоо. Тэд зуны нэг өдөр манайд ирцгээлээ. Манай хотныхон бөөн хөл болж, адуугаа хурааж, хонио холбож, цөөхөн тэмээгээ ч гаднаа авчирлаа. Нэгдэлд малаа тоо зүсээр нь хүлээлгэн өгөх ажил үргэлжилсээр хамгийн сүүлд тэмээн дээр ирлээ. Ээж, манайх тэмээгээ бүгдийг нь уналга эдэлгээнд сургасныг дурдаад, хэдэн сувай тэмээгээ ялгаж билээ. Гэтэл нэгдлийн “Нийбүү” бор атыг зааж:

- Шинэ тутам нэгдлийн төвийн барилгын ус зөөх ажилд яг таарна, үүнийг чинь авна гээд зүтгэлээ. Ээж:

- Хэдэн хүүхдийн минь хайртай ат хэмээн баахан цааргаллаа. Энэ яриаг сонссон бид хэд бие биеэ хараад дэмий л бүлтгэнэлдэв. Албаны хүн дийлж, бор атыг маань авахаар боллоо. Ээж, бор атаа үзүүрийг нь улаан даавуугаар бүрсэн шинэ бурантгаар бурантаглаж, хүлээлгэн өглөө.

Бид цөмөөрөө бор атаа тойрч зогсоод гадаад төрх байдлаараа “Нэгдэлд яасан ч өгөхгүй” хэмээн эсэргүүцэл илэрхийлсэн ч биднийг хэн ч тоож үзсэнгүй. Том эгч сэмээрхэн мэгшин уйлж эхэллээ. Бид цөм дагаад уйллаа. Би бүр чанга ориллоо. Гэтэл нэгдлийн төлөөлөгч:



-За ганц муу хөгшин атны төлөө юун ч сүртэй юм бэ хэмээн зандрахад бүгд айгаад дэмий л бие биеэ харан нусаа татаж, нулимсаа арчицгаалаа. Бид ингэж бор атнаасаа салсан юм даа. Намар сургууль цуглахад бор ат маань нэгдлийн шинээр барьж байгаа барилгын гадаа том гантай тэрэгнээс уяатай зогсож байлаа.

Бид удаан уулзаагүй эцэг эхээ үзсэн мэт гүйлдэн очиход нөгөө л нулимс гүйлгэнэсэн нүдээрээ биднийг тойруулан харж, “Та нар минь намайг эндээс салгаж аваач дээ” гэх мэт зөөлөн гунганаснаа биднийг цөмийг ээлжлэн үнэрлэж билээ. Бор атны хоёр хүнхрээ нь хонхойж, нэлээд турсан байв. Түүнээс хойш бид хичээлээ тараад л бор ат руугаа очно. Очихдоо дотуур

байрны хомсхон олдох боов боорцог аваачиж өгнө. Тэр намар байцай хэмээх олон давхар бөөрөнхий ногоо анх удаа байрны хүүхдийн хоолонд гэж шуудангаар ирүүллээ. Бид болсон, түүхий байцайны хальс бас хатуу голыг нь бор атандаа өгдөг боллоо. Бор ат ч гараас идэх юм горьдох болж, байрны хүүхдүүд бараг л бүгдээрээ түүнд маань идэх юм өгдөг болов.

*Хүүхдүүд бор атыг нэгдэлд авахыг сонсоод юу бодсон бол?
Нэгдлийн төлөөлөгч хүүхдүүдийн уйлсны учрыг ойлгосон болов уу?
Ээж нь бор атыг яагаад нэгдэлд өгөхөөс харамлав?*

Говь нутагт оройхон өвөл болж, барилгын ажил зогслоо. Бор ат маань нэг л өдөр харагдахаа болилоо. Нэгдлийн ус зөөдөг Гонгор гуайгаас бор атаа сураглахад:

- Хөдөө гаргасан гэхээс өөр олигтой үг дуулсангүй. Тэр өвөл цас их унаж, мал олноороо хорогдож байгаа гэж сонсогдох боллоо. Би бор ат маань яасан бол хэмээн үе үе бодож, Хүйсийн говь руу очоогүй байгаа даа хэмээн горьдсоор хавартай золгов.

Нэгдлийн төвийн барилгын ажил эхэллээ. Гонгор гуай тэс өөр ат хөллөчихсөн ус зөөж явна. Би Гонгор гуайгаас бор атаа асуухад:

- "Зуднаар алга болсон" хэмээн тоомжиргүйхэн хэлэв. Чухам хаана яаж эндсэнийг хэн, хэрхэн мэдэх вэ? Ямар ч гэсэн бид бор атнаасаа ингэж хагацсан юм. Бор атыг маань нэгдэлд авна гэж зүтгэсэн "Нийбүү", эцэж туртал нь эдэлсэн Гонгор гуай хоёрт би том болтлоо үнэн голоосоо гомдон явж билээ. Одоо ч гэсэн олон тэмээний хажуугаар өнгөрөхдөө нэг л мэдэхэд бор аттайгаа адилхан тэмээ нүдээрээ хайж байгаагаа мэдэрдэг. Нэг ёсондоо ээжтэй минь хамт биднийг өсгөлцсөн бор ат минь ганц ч өдөр амсхийлгүй, ажилд нухлагдсаар малд ч гэсэн байх ёстой нуур ногоонд умбаж, дураар тарвалзан жаргахын учиргүй төрсөн амьтан байж дээ, хөөрхий.

*Бор ат нь хаачсан бол?
Та нар хүүгийн бодлоос юуг мэдэрч байна вэ?
"Зуднаар алга болсон" хэмээн тоомжиргүйхэн хэлж байгаа хүнд та нар юу хэлмээр байна вэ?*



Унших чадвараа хөгжүүлэе

Өгүүлэгдэхүүний бүтцийг ялгах

Түлхүүр нэр томьёо

Зохиолын өгүүлэгдэхүүн нь дараах хэсгээс бүтнэ.

Эхлэл - Зохиолд ямар дүрүүд тоглох гэж байгааг, үйл явдал хаана болох гэж байгааг танилцуулдаг хэсэг

Зангилаа - Үйл явдал өрнөх шалтгааныг тодруулж бичсэн хэсэг

Өрнөл - Баатруудын хоорондох зөрчил, баатруудын амьдралд тохиолдсон элдэв тохиолдлууд, бэрхшээл, боломжийн тухай өгүүлдэг хэсэг

Туйл - Үйл явдлын хамгийн хурц, сэтгэл хөдөлгөсөн хэсэг буюу цаашид үйл явдал өрнөх боломжгүй болж туйлдаа хүрэх хэсэг

Тайлал - Зохиолын үйл явдлын шийдэл хэсэг

1. Асуултын дагуу зохиолын өгүүлэгдэхүүний дарааллыг тогтоож ярилцаарай. 63 дугаар хуудасны мэдээллийг дахин уншиж болно.

Эхлэл	<ul style="list-style-type: none"> Байгалийн ямар байдлыг ямар үгээр бичсэн бэ? Ямар дүрийг зохиолч эхлэл хэсэгт танилцуулсан бэ? 	
Зангилаа	<ul style="list-style-type: none"> Бор атыг нь албаны хүмүүс авч явах үйл явдал юунаас болж эхэлж байна вэ? Бор атыг нэгдэлд авч явсан үйл явдлын өрнөх шалтгаан нь юу байсан бэ? Хэрвээ ийм зүйл болоогүй байсан бол үйл явдал цаашид өрнөх байсан болов уу? 	
Өрнөл	<ul style="list-style-type: none"> Бор атанд юу тохиолдов? Зохиолын үйл явдал хэрхэн өрнөв? Хэнд юунд ямар бэрхшээл тохиолдов? Дүрүүдийн хооронд ямар зөрчил илрэв? 	
Туйл	<ul style="list-style-type: none"> Ямар үйл явдал өрнөж, туйлдаа хүрсэн бэ? Үйл явдал цаашаа үргэлжлэх боломжгүй болсныг яаж гаргасан бэ ? 	Бор ат нэг л өдөр харагдахаа больсон тэр үед өвөл их цас унаж мал олноороо хорогдох болжээ. “Яасан бол...” гэсэн хүүгийн бодол зохиолын туйл хэсгийг илэрхийлнэ.
Тайлал	<ul style="list-style-type: none"> Бор ат алга болсон нь яаж тайлагдав? Зохиолчийн хэлэх гэсэн санаа тайлагдав уу? 	Сүүлийн цогцолборыг ажиглаарай.
Төгсгөл	<ul style="list-style-type: none"> Зохиол яаж төгсөв? 	Сүүлийн өгүүлбэрийг тайлбарлаарай.

Уран дүрслэлийг тайлбарлах

1. Уран дүрслэл бүхий хэсгийг дахин уншаад, асуултын дагуу тайлбарлаарай.

№	Зохиолоос авсан эшлэл	Юуг юутай адилтгасан бэ?	Ямар шинжээр нь адилтгасан байна вэ?
1	Хүрэнгэн ягаарах бударгана, шар модны товцог холилдон багсайж, хоорондуур нь нялх хүүхдийн зулайн үс шиг шингэн зөөлөн хургалж...	Хүйсийн хөндийг дүрслэхдээ бударганыг хүүхдийн зулайн үстэй адилтгажээ.	
2	Хүйс гэдэг нь хар шилбээр зангидсан малгайн оройн сампин шиг барзгар бяцхан овоо...		
3	Хүйсийн овооны чанх араас буурын шилний бохь шүүрэн дааварлах адил бяцхан булгийн дэргэд...	Худгийг буурын шилний бохь шүүрэн гаргахтай адилтгажээ.	
4	Биднийг бага байхад манайх гэдэг айл энэ ширээ шиг тэгш хөндийн дөрвөн талд нь ээлжлэн нүүж...	Хөндий тал нутгийг-тэй адилтгасан.	
5	Хүйсийн худаг дээр ирж дэвтээсэн гүзээ шиг ширэн ховоогоор нь чадлынхаа хэрээр ус татаж...	Ховоогтэй адилтгасан	Ховоо савны хатуу чанар нь алдагдаж, зөөлөрсөн хэлбэр нь дэвтээсэн гүзээтэй адил болсон байна.



Сонсох, ярих чадвараа хөгжүүлэе

Уншсан зохиолын үйл явдлыг өөрийн үгээр ойлгомжтой ярих

1. Уншсан өгүүллэгүүдээс сонгоорой.
2. Сонгосон өгүүллэгийнхээ уран дүрслэлт үг, таалагдсан үг хэллэг, содон санагдсан үг хэллэг зэргийг түүвэрлэн бэлдээрэй. Эдгээр үгсээ цээжлээрэй.
3. Сонгосон өгүүллэгийн үйл явдлыг дэс дараалан ярихад бэлдээрэй. Тухайлбал, “Шаргачин” өгүүллэгийг ярихын тулд дараах байдлаар дэс дарааг төлөвлөж болно.

- Шаргачин янзагаа дагуулан гарч ирсэн тухай ярина. Энэ хэсгийг ярихдаа орчныг дүрсэлсэнийм ийм үгсийг хэрэглэнэ.
- Шаргачин аюулаас сэрэмжлэн бодсон тухай ярина. Энэ хэсгийг ярихдаа шаргачны бодсонийм ийм үгсийг хэрэглэнэ.
- Шаргачны аз жаргалтай байгаа хэсгийг ярина. Энэ хэсгийг ярихдаа.....ийм ийм дүрслэлтэй үгсийг хэрэглэнэ.
- Шаргачныг машинтай хүн хөөсөн тухай ярина.
- Шаргачны зугтаж байгаа хэсгийг ярина... гэх мэт

4. Бусдын сонирхлыг татахын тулд дараах аргуудаас сонгоорой.
 - А. Үйл явдлын дарааллыг зурж, бусдад үзүүлж ярих
 - Б. Үйл явдлын дарааллыг оюуны зураглалаар илэрхийлж ярих
5. Сонсох, ярих чадвараа дараах шалгуураар дүгнээрэй.

	Маш сайн	Хангалттай	Дахин сайжруулах шаардлагатай гэж бодож байна.
Өгүүллэгийн үйл явдлыг ярихдаа уран дүрслэл эсвэл сонирхол татсан үг хэллэг ашиглаж ярьсан уу?			
Оюуны зураглал юм уу эсвэл зураг хэрэглэж ярьсан уу?			
Уран дүрслэлийг цээжилж чадсан уу?			
Ярихдаа ойлгомжтой, өөртөө итгэлтэй, бусдын сонирхлыг таттал ярьж чадсан уу?			
Бусдынхаа ярьсныг анхааралтай сонссон уу?			
Сонссоны дараа тодруулж асуусан уу?			



Бичих чадвараа хөгжүүлэе

Уншсан зохиолын гол санааг алдагдуулахгүйгээр товчилж бичих Сонгон ажиллана уу.

1. Уншсан өгүүллэгүүдээс сонгоорой.
2. Сонгосон өгүүллэгийнхээ дүрийн үйлдлийг тоочин бичээрэй.
3. Сонгосон өгүүллэгийн үйл явдлын дэс дарааг тогтоон төлөвлөөрэй.
4. Гол санааны тухай бичсэнийг хэрэглээд, дүрийн үйлдлийг дэс дарааллаар товчилж бичээрэй.

Дэмжлэг:

Алт Мөнгө хоёр	Зүрх цагаан
Дүр бүрийн хийсэн үйлдлийг тоочин бичнэ үү.	56 дугаар хуудасны дүрийн үйлдлийг тоочин бичсэнийг ашиглана уу.
Зохиолын гол санаа: Амин хувиа хичээж, зөвхөн өөрийгөө бодох нь хүний хамгийн муу зан болохыг Алтын дүрээр харуулжээ.	Зохиолын гол санаа: Хоттой хонио харахын тулд эзнээсээ өөр хүнээс яс авахгүй байгаа жинхэнэ Монгол нохойн тухай өгүүлсэн зохиол юм.
<ul style="list-style-type: none"> • Товчлон ноороглож бичээрэй. • Ноороглон бичсэнээ эхлээд өөрөө хянаж, сийрүүлэн засаарай. • Хажууд суугаа найзтайгаа солилцон уншаарай. • Дараа нь бие биеийнхээ найруулгын болон зөв бичих дүрмийн алдааг засахад саналаа хэлээрэй. • Эргэлзэж буй зүйл дээр багшаасаа зөвлөгөө аваарай. • Дараа нь хичээнгүйгээр сийрүүлэн бичээрэй. 	

5. Товчлон бичсэн жишээг ажиглаад, дуурайн ажиллаарай. Тодруулсан үгс нь зохиолын гол санааг илэрхийлсэн үг юм.

ШАРГАЧИН ЗОХИОЛЫГ ТОВЧИЛСОН НЬ

Нэгэн шаргачин саяхан төрүүлсэн янзагаа дагуулан, тал нутагт тааваараа идэшлэн, тоглож, үр хүүхдээ хайрладаг эх хүний адил аюул ослоос сэрэмжлэн явна. Гэтэл **амьтныг хайрлах сэтгэлгүй хэдэн хүмүүс** шаргачныг машинаараа хөөн давхина. Шаргачин өөрийн янзагыг аюулд өртөх вий гэсэндээ янзага руугаа биш зориуд өөр зүг рүү хөлийн хурдаар зугтаан давхиж байгаагаас **эх хүний үрээ гэсэн сэтгэлийг** харж болно. Эцэст нь муу хүмүүсийн уршгаар амиа алдаж байгаагаар зохиол төгсөнө. Харин машинтай хүмүүс өөрсдийн буруу үйлдлийг тунгаан бодсонгүй. Энэ зохиолд **үрээ хайрлах амьтны тухай, ан амьтныг хайрлах тухай, буруу үйлдэл хийсэн бол тунгаан бодож байх тухай** өгүүлжээ.

6. Товчлон бичсэний дараа 50 дугаар хуудсан дахь найруулан бичих шалгуурыг хэрэглээрэй.

ХЭРХЭН СУРАЛЦСАНАА ҮНЭЛЬЕ

Унших чадвараа үнэлэх даалгавар

Өөрийн үнэлгээ

1. Хүүхдүүд ээ! Сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг ойлголт болон өөрийн идэвх оролцоог дараах асуултын хүрээнд дүгнэн, өөртөө үнэлгээ өгөөрэй.

№	Үнэлэх шалгуур	1-5 оноо
1	Зохиол бүр та нарт юуг хэлэхийг зорьсон байна вэ? Энэ талаар бодож эргэцүүлсэн үү?	
2	Багийн ажлаар өөрийнхөө үзэл бодлыг бусдадаа ойлгуулан ярьж чадсан уу?	
3	Өөрийгөө зохиолын аль нэг баатрын оронд байгаагаар төсөөлөн бодсон уу?	
4	Өгүүлэгүүдэд байгаль, ан амьтнаа хайрлах, хүн хүнээ дэмжих, ойлгох зэрэг олон санаануудыг хөндсөн байгаа. Энэ талаар эргэцүүлэн бодсон уу?	
5	Зохиолоос өөрт таалагдсан хэсгийн дүрслэлүүдээс цээжлэн тогтоож чадсан уу?	
6	Багаар ажиллах явцад бусад нөхдийнхөө саналыг сонсон, хүлээцтэй байж чадсан уу?	
7	Бусдыгаа ярьж байх үед зөв гэж үзсэн саналыг дэмжсэн үү?	
8	Зохиолоос жишээ татан өөрийнхөө санаа бодлыг хамгаалж чадаж байсан уу?	

2. Зохиолын дүрийг задлан шинжлэхдээ алийг нь анхаардаг вэ? Сонгоно уу.

- Дүрийн хэлсэн үг
 - Дүрийн хийсэн үйлдэл
 - Дүрийн бодол
 - Харилцан яриа
 - Хаана амьдарч байгааг

3. Адилтган дүрсэлснийг тайлбарлахдаа ямар ямар асуулт хэрэглэдэг вэ?

4. Дараах асуултын дагуу хажууд суугаа найзтайгаа ярилцан, сурсан мэдсэн зүйлдээ дүгнэлт хийн, нэгтгээрэй.

№	Үнэлгээний асуулт	Хариулт
1	Бидний сурсан зүйлээс хамгийн чухал нь юу байв?	
2	Сэдвийн хүрээнд ямар ямар шинэ зүйлийг мэдэж авсан бэ?	
3	Бидний сурсан зүйлсээс юу нь хамгийн гайхалтай байв?	
4	Сэдвийн хүрээнд тодорхой биш зүйл юу байв?	
5	Бидний судалсан зүйлээс юу нь хамгийн хэцүү байв?	

6	Хичээлүүдээс хамгийн сонирхолтой нь аль хичээл байв?	
7	Өөр юуг илүү их гүнзгийрүүлж мэдмээр байв?	
8	Уншиж судалсан эх зохиолоос хамгийн сайхан санагдсан нь ямар эх зохиол байв?	
9	Эх зохиолын дүрүүдээс хамгийн уран дүрслэлтэй, сургамжтай нь ямар дүр байв?	
10	Эх зохиолуудын санаанаас хамгийн сургамжтай санагдсан нь аль зохиолын ямар санаа байв?	

Сонсох чадвараа үнэлэх даалгавар

- Ж.Дашдондогийн “Мазаалай” өгүүллэгийг олж уншаад, дараах асуултын дагуу яриарай.
 - Зохиолыг уншаад ямар ямар шинэ үг мэддэг болсон бэ?
 - Мазаалай хаана амьдардаг вэ?
 - Амьтад яагаад говь нутгаасаа явах болов?
 - Мазаалай бусад амьтдаас үзэл бодлын хувьд ямар ялгаатай байна вэ? Тэр өөрийн бодолдоо үнэнч байсан уу?
 - Мазаалай юуны хүчинд байгалийн үзэгдлийг даван туулав?
 - Бусад амьтдын дүрийн цаана хүний ямар үйл ажиллагааны тухай ярилцаж болох вэ?
 - Мазаалайн дүрээр зохиолч бидэнд юуг хэлэхийг хүссэн бол?
- Бусдынхаа ярьсныг хэр сонсож байгаагаа үнэлээрэй.

Өөрийн үнэлгээний шалгуур	Тийм	Үгүй	Заримдаа	Сайжруулах шаардлагатай
Ангийн хүүхдүүдийн ярьсныг анхааралтай, хүлээцтэй сонсдог.				
Багшийнхаа ярьж тайлбарлаж байгааг анхааралтай сонсдог.				
Багаараа ажиллахдаа өөрийнхөө хэр ярьж байгааг мэдэрч сонсдог.				
Зөв сонссон гэдгээ илэрхийлж сурсан.				

Бичих чадвараа үнэлэх даалгавар

- Гол санааг алдагдуулахгүйгээр товчилж бичих чадвараа үнэлээрэй.

Өөрийн үнэлгээний шалгуур	Тийм	Үгүй	Заримдаа	Сайжруулах шаардлагатай
Товчилж бичихдээ дүрийн хийсэн үйлдлүүдийн дэс дарааллыг харгалзсан				
Товчлохоос өмнө зохиолын гол санааны тухай ярилцсан				
Үгийг оновчтой сонгосон				
Зөв бичгийн дүрмийн алдаагүй бичсэн				
Найруулгын шаардлагыг хангасан				

МОНГОЛ ТУУЖ

Монголын эртний уран зохиолын дотор “Чингисийн хоёр эр загалын тууж”, “Гэсэрийн тууж”, “Чойжид дагинын тууж” гэх зэрэг тууж бий. Монголын орчин үеийн уран зохиолд тууж нь бие даасан төрөл зүйл болж хөгжжээ.

Тууж бол өгүүллэгтэй нэг адил хүүрнэл зохиол бөгөөд хэмжээний хувьд өгүүллэгээс дэлгэрэнгүй, том хэмжээтэй зохиол юм.

Өгүүллэгт баатрын амьдралын нэгэн үе, учрал тохиолдлыг үзүүлдэг бол тууж нь гол дүрийн амьдралын аль нэг талыг сонгож харьцангуй чөлөөтэй үзүүлдэг.



ЛОДОНГИЙН ТҮДЭВ

Төрсөн нутаг:

1935 онд Говь-Алтай аймгийн Наран суманд малчин ардын гэр бүлд төржээ.

Гол уран бүтээл: “Уулын үер”, “Нүүдэл”, “Оройгүй сүм” зэрэг роман болон өгүүллэг, эсээ зохиолуудаараа алдартай.

Зохиолчийн хэлсэн онцлох үг:

Танин мэдэхийн их аян өлзийтэй байх болтугай.

Уншихын өмнө

1. Л.Түдэвийн “Хорвоотой танилцсан түүх” туужийн “эхлэл” болон “Зурагтай танилцсан минь” гэсэн хэсгийг анхааралтай уншиж, хорвоотой танилцаж буй би баатар, зургийн дүрслэлийг мэдэрч, сонирхож байгаагаас эхлээд зурж, дүрсэлж сурч байгааг хэрхэн бичсэнийг анхаарч уншина уу.
2. “Хорвоотой танилцсан түүх” туужийн тэргүүн дэвтэр нь “Чулуутай танилцсан минь”, “Дуутай танилцсан минь”, “Зурагтай танилцсан минь”, “Салхитай танилцсан минь”, “Цүнхтэй танилцсан минь” гэх зэрэг 17 хэсэгтэй бөгөөд тэдгээрээс бага ангид “Чулуутай танилцсан минь”, “Дуутай танилцсан минь”, “Салхитай танилцсан минь” хэсгүүдийг уншсан тул тэдгээрийг эргэн санаарай.
3. Зохиолыг бүхэлд нь уншиж зохиолчийн бичсэн хорвоотой танилцсан түүхийг өөрийнхөө хорвоотой танилцсан түүхтэй харьцуулна уу.

ХОРВООТОЙ ТАНИЛЦСАН ТҮҮХ

(Туужийн хэсэг)

Хорвоо мэндлэлцсэн тэр цагаас эхлээд нэг талд би, нөгөө талд хорвоо эсрэг ширтэлцэн орших болов оо. Намайг өмссөн цамц ч үгүй гар хоосон төрөхөд хорвоо яндашгүй баян байлаа. Би энгийн хялбар амьтан төрж байхад хорвоо ээдрээтэй нарийн ертөнц байлаа.

Хорвоо нууц. Хорвоо сүртэй. Би нялх. Би гэнэхэн. Гэвч би хорвоог таних ёстой. Хорвоо бол намайг таних хэрэгцээгүй байж. Хорвоог таних гэмээж нь миний төрсний хэрэг бүтэх учиртай

юмсанж. Тэгээд би ээж, аавын заяасан бие сэтгэлийн эрдмийг нээгдүүлэхээр хорвоогийн учрыг танин мэдэх аянд гарч дээ. Тэр аян төгсгөлгүй урт, нэг нас богинодож, нэгэн насны бие хэврэгдэх байж. Тэгэвч аянаас зүрхшиж, алжаалаас айлгүй одсон эцэг өвгөдийн зам намайг хөтөлжээ.

Над таван сайн зэвсэг байлаа. Ихийг үзэж ихийг сонс гэж нүд чихийг хосоор, бага чалч гэж амыг ганцаар заяажээ. Зэвсгээ тийн агсаад танин мэдэхүйн аянд гарсаар гучин гурав дахь жилдээ явж байнам.

Анх намайг харахад хорвоо үлгэрийн орон шиг байжээ. Хүүхдийн нүдээр би түүнийг харж дээ. Одоо надад хорвоо гэгч гэр шиг минь үзэгднэм. Хожмын нэг өдөр хорвоо над таван хуруу шиг минь бодогдох болуужин.

Танин мэдэхийн их аян өлзийтэй болтугай.

*Хорвоог танин мэдэх аянд гарсны учир юу вэ?
Яагаад нүд, чих, амыг “зэвсэг” гэсэн бэ?*

ЭХЛЭЛ

Энэ түүх арван зургадугаар жарны цагаагчин гахай жилийн шинийн наймны үдэш эхэлжээ. Тэр үдэш тэр эгшинд хорвоогийн ам бүл нэгээр нэмэгдэж, хоёр миллиард таван зуун гучин гурван сая дөрвөн зуун наян ес болжээ. Хорвоогийн эр хүний тоо мөн нэгээр өсөж дахиад нэг хүлэг морин эмээл хазаартайгаа хэрэгтэй болжээ.

Энэхүү өгүүлэгдэн буй намтар түүхийг бүтээгч тэр эр хорвоотой танилцсан эхний зургаан жилийнхээ явдлыг өөрөө эргэн санахгүй юм билээ. Эхлээд л уйлж сурсан юмсанж. Уйлахаараа айлгаж хоол олж иддэг юм байж дээ. Удахгүй инээмсэглэж, тэгээд уурлаж, тэгснээ мөлхөж төдөлгүй явж улмаар ярьж сурсан бололтой. Тэгээд л зураг зурж сурсан юм байх. Анхны бүтээлүүдээ шороонд хоцроосон тул архивт үлдээгүй юм гэдэг.

Нялх оюунд тогтож үлдээгүй тэрхүү зургаан жилийн явдлыг ээж хожим цухас цухас дурдсан билээ. Нэг өдөр нарны талыг үүл халхалчихсан байхыг чи үзээд:

- Ээж ээ, нар хэмхэрчихсэн байна гэж их л санаа зовон хэлж билээ.

Бас нэгэн өдөр эмгэн ээжийгээ уул даваад явахыг үзмэгц уйлагнаж:

- Ээж ээ, буурал ээж тэр уулын цаад руу өнхрөөд орчихлоо гэж билээ.

Чи бяцхан цагаан явуугаар тоглодог байлаа. Түүнийг амандаа үмхэж яваад залгичихжээ. Шөнө дунд түүнээ санаж уйлсан. Юу болов гэхэд гэдэс рүүгээ зааж:

- Явуу минь энэ рүү орчихсон гэж гаслан уйлж билээ.

Хуурсан тариа тээрэмдэж байтал “Өг” гэж ууртай нэхэв. “Зодчихоод ав” гэж тоглоход үнэмшиж, залтасны хэлтэрхий авч ирээд намайг нэг цохиж аваад, дараа нь тариа авахаар хоёр гараа сарвайв. Тэгэхдээ баганын хоёр талаар тэвэрч тоссон юмсан. Нэг атга тариа аваад буцах гэтэл багана тээглэж хоёр гараа салгая гэхэд нь тариагаа асгачих болж их сандарсан билээ.

Энэ мэт олон учрал хэрэг төвөг тарьж явсан тэрхүү зургаан жил өнгөрөхөд мань эр юу хийж, хэлж явснаа өөрөө мартаггүй болсон юмсанжээ.

Бага насныхаа тухай хөгжилтэй дурсамжтай яриаг ангидаа өрнүүлээрэй.

ЗУРАГТАЙ ТАНИЛЦСАН МИНЬ



Та нар анх юу зурж эхэлсэн бэ?

Жаалхүү гэдэг өвгөнийх олон хүүхэдтэй айл байв. Нэгэн өдөр тэдний хамгийн том хүүхэд гэрийнхээ гадаа завилж суугаад, өвөр дээрээ дөрвөлжин мод тавьж, ямар нэгэн юм хийж байхыг харлаа. Юу хийж байгааг нь үзэх сэн гэхээс тэсэж суух аргагүй болов. Ороо хонь барих гэж байгаа юм шиг сэм сэмхэн гэтсээр, тэр хүүхдийн ар талд очоод өнгийн харвал, онц сонин юм үзэв. Модон самбар дээр үнс түрхжээ. Нарийхан үзүүртэй савх модоор үнсэн дээгүүрээ нааш цааш зурж байгааг нь харахад гайхмаар ажээ. Даваасамбуу гэж тэр хүүг нэрлэдэг юм. Даваасамбуугийн гар нь нааш цааш уяхнаар хөдлөх бүрийд үнс түрхсэн самбар дээр дүрс гарч байлаа. Саваг үсэндээ дарагдсан сүртэй том сарлагийн бухны дүрс гараад ирлээ. Бух урд хөлөөр газар цавчлан хэлээ унжуулан туужуу мэт сүүлээ хондлой дээрээ агсжээ.

Даваасамбуу намайг ар талдаа ирээд ажиглаж байхыг мэдсэнгүй. Цааш тавтайяа үргэлжлүүлэн зурсаар байв. Удаж төдөлгүй дахиад нэг сарлагийн бух зурчихлаа. Хоёр сарлагийн бух өөд өөдөөсөө харж сааглан мөргөлдөхийг завдаж буй ажээ. Би тэр сонин зургийг нүдээ бүлтэртэл гөлрөн зогсож, хамаг юмыг нэгэн агшнаа мартжээ.

Модон дээр модоор тэгж сайхан зурж болдгийг анх удаа тийнхүү мэдэж авлаа. Гол нууц нь модон самбар дээр түрхсэн аргалын үнс гэдгийг нь би мэдлээ. Даваасамбуу гэв гэнэт нөгөөх зургаа үнс асган балласанд би харамсаж, “Хүүе, битгий” гэж дуу алдав. Даваасамбуу над руу эргэж харснаа ухасхийн босож гэрийн зүг одлоо.

Санамсаргүй нээж олсон нууцаа туршиж үзэхээр би гэрийн зүг салхи мэт дэгдэн одлоо. Гэрт орж ямар нэгэн дөрвөлжин мод хайж гарлаа. Гэрт хэн ч үгүй тул би дураараа загнах эрхтэй байлаа. Гай болоход гэрт нэг ч хавтгай мод байсангүй. Цорын ганц боломжийн мод гэвэл өрөм хатаадаг тос нэвчсэн бор мод эргүүл дээр байв. Хэсэг эргэлзсэний эцэст би тэр модыг олзлон авч, тулганы захаас аргалын цагаан үнс хайж олоод дээр нь нунтаглан түрхэв. Дөрвөлжтэй түлээн дотроос бяцхан мод олж хутгаар үзүүрлэв. Зурах ажилдаа орлоо. Сарлагийн бух зурж эхлэв. Даваасамбуу шиг уран зурах гэгч огт хялбар биш ажил байжээ. Хөлсөө гартал ноцолдоод нэг бух зурсан чинь хөрш айлын доголон халтар нохойтой адилхан амьтан болчихлоо. Эсрэг талд нь ахиад нэг бух зурах гэж улайран сууж байтал, гэв гэнэт хацар дээр халуу оргив.

“Чи яагаад өрөм хатаадаг мод бузарлав. Ээжид чинь хэлж турсгыг чинь хуулуулна даа!” гэж загнах дуунаар өндийн үзвээс авга эгч зогсож байлаа. Бид нар авга эгчийг “Айдаа” гэж авгайлна. Харин хүмүүс “тарган” гэж дуудна. Нэр хоч хоёр нь яг адилхан тийм хүн манай тэр голд ганцхан л Айдаа байж дээ.

- Айдаа, үүнийг хараа, юу вэ? гэж би зурсан зургаа заалаа.

- Аль вэ? Яагаав Донтор л байна гэж Айдаа хөхөрч гарав. Донтор гэж хөрш айлын доголон халтар нохойн нэр л дээ.

- Донтор биш ээ. Ааяа Балдангийн халзан бухыг зурсан юм гэж би ярьсанд Айдаагийн инээд улам хүрч бүр сүүлдээ эвхрэн ойчоод нүдний нь нулимс цувж, цээж нь хэржигнэн хөхөрсөөр байлаа. Айдаа инээдээ барьж чаддаггүй. Тийм хачин хүн л дээ. Түүнийг хөхөрч

хэвтэх хоорондуур би гарч зугтаалаа. Үнс түрхсэн самбараа аргал дотор нуув. Түүнээс хойш миний хийдэг юм зураг боллоо. Зун бол голын хөвөөний нойтон шавар, торгон элс, өвөл бол цасан дээр элдэв амьтны дүрс зурна. Заримдаа хөөтэй мод олж цагаан чулуу, байшингийн ханан дээр зурна. Нэг удаа манайд айлчлан ирсэн Ехөөмянган өвгөний арьсан дээлийн ар дээр могой зурж орхив. Өвгөн түүнийг мэдсэнгүй. Өглөө эрт босоод дээлээ өмсөх гэснээ могойг үзэж нүд бүлтрэх шахан айж:

- Ай, хан хурмаст минь! гэж хашхираад дээлээ чулуудчихав. Тэр могойноос айдаг юмсанжээ.

Би тэр могойноос болж хоёр хацраа хорстол “илүүлэв”. Би нэрэлхэж “Ехөөмянган гуай миний хоёр хацрыг халуу шаттал илсэн” гэж найзууддаа ярьсан юм. Тэд нар инээлдэж нэг хэсэгтээ намайг “илүүлдэг” гэж хочлох болж билээ.

Даваасамбуугийн зурж байгааг хараад “Би баатар” юу бодсон бол?

Модон дээр модоор зурдгийн нууц юу байв?

Олж авсан нууцаа яаж туршсан бэ?

Би бас эмгэн ээжийг яг адилхан зурчхад тэр хэргийн учир хэд сайн чимхүүлж авсан... Муу ёрын золиг, сүг зураад, нүгэл, “чигяа тархи” гэж буурал ээж их л зэвүүцэн загнасан. Буурал ээж хэр баргийн юманд уурладаггүй байтлаа өөрийг нь зурахад яагаад сэжиглэдгийг би огт ухаардаггүй байлаа.

Нэг мэдсэн би сайн зурдаг боллоо. Сайн зурдаг болсноо Мана хөгшнөөс сонсов. Би тэр өвгөний толиод орхисон арьсан дээр муур зурчихсан юм. Мана өвгөн бас мууранд дургүй хүн байлаа. Тэр жилийн намар би сургуульд орлоо. Аймгийн төв дээр авчирч нагац ахынд суулгах болов. Нагац ах маань нэгэн өдөр над хэдэн янзын өнгөтэй дүгрэг юм үзүүлээд:

- Энэ юу вэ? гэлээ.

- Энэ лав товч байх гэтэл нагац ах инээж:

- Энэ усан будаг шүү гэв.

- Яадаг юм бэ? гэж би асуухад нагац:

- Үүгээр зураг зурдаг юм гэв. Тэр үгийг сонсмогц миний сонирхол оволзлоо.

- Яаж зурдаг юм бэ?

- Ингэж зурна. Чи сайн хар гээд нагац үзүүртэй, хурганы сүүл шиг үстэй савх модыг усанд дүрж, нөгөө дүгрэг юман дээрээ нийлж байгаад цаасан дээр зурлаа. Цэнхэр өнгө гарлаа.

Цэнхэр өнгөтэй ямар юм байдаг билээ? Аа, тийм яргуй гэж нагац ах яриад цаасан дээр яргуй шиг юм зурлаа. “Ай миний гар ч эвлэх юм биш. Ай даа, би чам шиг байсан болоосой. Тэгвэл цуутай зураач болох сон. Даанч хождож орхисон юм. Гар минь төмөр нүдэхээс өөр юманд хөдлөхөө байжээ. Миний дүү ахынхаа мөрөөдлийг ав даа” гэж нагац хэлээд над нэг ширхэг хөх будаг өгөв. Бусдыг нь цааш далд хийлээ.

Өгөх болоогүй. Чи хөх будгаараа хөх өнгөтэй юм юу байдаг вэ, түүнийг цөмийг зурж сур. Тэгээд надаас улаан будаг нэмж ав гэж нагац хэлэв. Би улаан будаг авахын тул бүхнийг мартан чармайлаа. Тэгж хичээн зүтгэсээр хоёр сарын дараа солонгын долоон өнгө бүрдлээ. Би солонго зурав. Их талын элгэн дээр нумран тогтсон долоон өнгийн солонго зураад нагацдаа үзүүлэв. Ай даа, одоо чи зураад бай. Над өөр будаг байхгүй шүү гэв. Би зурсаар л байлаа...

(Л.Түдэв, Хорвоотой танилцсан түүх. УБ., 2007, 19-22 дугаар тал)



Унших чадвараа хөгжүүлэе

Зохиолын утгыг ойлгосноо ярилцах

1. Даваасамбуу хүүгийн зурсан зургийн тухай бичсэн дүрслэлийг “Бухын мөргөлдөөн” зурагтай харьцуулан ярилцана уу.
2. Даваасамбуу хүүгийн зурж байгаагаас зохиолын “Би баатар” ямар нууцыг олж мэдэв? Ямар санаа зорилготой болов?
3. “Зурагтай танилцсан минь” хэсэгт “Би тэр сонин зургийг нүдээ бүлтэртэл гөлрөн зогсож хамаг юмыг нэгэн агшнаа мартжээ” гэж дүрсэлсэн нь “Дуутай танилцсан минь” хэсэгт “Миний өчүүхэн бор зүрх уяран хайлж, бадран догдолж, баясан цовхчиж туранхай цээжний минь чанад багтаж ядан донсолж байлаа” гэж дүрсэлсэнтэй юугаараа төстэй, юугаараа ялгаатай байна вэ?
4. Би баатрын зурсан зургийг хараад авга эгч Айдаа нь юуны учир инээв?
5. Би баатар юу юун дээр, юу юугаар хэрхэн зурж байв? Энэ нь зохиолд дүрслэгдсэн цаг, оронтой хэрхэн холбогдож байна вэ?
6. Би баатрын зурж сурсан гэдгийг зохиолд хэрхэн өгүүлэв? Би баатар долоон өнгөөр солонго зурахын тулд ямар ямар өнгөөр юу юу зурсан байж болох вэ?



(О.Цэвэгжав. Бухын мөргөлдөөн)

Дүрийн үг, үйлдлээс зорилгыг тодорхойлох

1. Би баатар өөртөө ямар зорилго тавив? Зорилгодоо хүрэхийн тулд юу хийв? Өөртөө юу гэж хэлсэн бэ?
1. Би баатрын зурж сурахын тулд хийж байгаа үйлдлүүдээс түүний зан төрхийн гол шинжийг хэрхэн тодорхойлж болох вэ?
2. Би баатар, Ехөөмянган гэгч хүнд алгадуулсныгаа “Ехөөмянган гуай миний хоёр хацрыг халуу шаттал илсэн” гэж найзууддаа хэлснийг түүний зан төрхтэй холбон тайлбарлаарай.

Өгүүлэгдэхүүний дарааллыг тогтоож ялгах

Зохиолын өгүүлэгдэхүүнийг дараах асуултын дагуу тодорхойлоорой.

Эхлэл - Энэ хэсэгт ямар ямар дүрүүдийг, үйл явдал хаана болж байгааг хэрхэн танилцуулсан бэ?

Зангилаа - Үйл явдал өрнөх шалтгаан нь юу вэ? Юунаас болж үйл явдал өрнөв? Даваасамбууг өвөр дээрээ мод тавьж, ямар нэгэн юм хийж байхыг харсан нь үйл явдал өрнөх шалтгаан болжээ. Түүнийг хараагүй байсан бол “Би баатар” зураг зурах хүсэлд автахгүй байх байсан.

Өрнөл - Баатруудад юу юу тохиолдов? Гол баатарт ямар бэрхшээл гарав? Түүнд боломж юу байв? Ямар ямар баатрууд хоорондоо зөрчилдсэн бэ? Юунаас болов?

Туйл - Үйл явдлын хамгийн хурц, сэтгэл хөдөлгөсөн хэсэг нь аль вэ?

Тайлал - Зохиолын үйл явдал яаж төгсөв?

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЭЗЭМШИХ ЧАДВАР:

УНШИХ ЧАДВАР

- Зохиолыг мэдэрч ойлгох, зохиолчийн үг сонголтын шалтгааныг тайлбарлах
- Өгүүлэгдэхүүнийг ялгах
- Сэдэв, гол санааг тайлбарлаж, үзэл бодлоо илэрхийлэх
- Дүрийн үг үйлдлээс зорилгыг тодорхойлох

БИЧИХ ЧАДВАР

- Уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичих

ДЭЛХИЙН УРАН ЗОХИОЛ



ҮЛГЭР

Хүүхдүүд ээ! Энэ бүлгээр дэлхийн сонгодог үлгэр, өгүүллэгийг унших юм.

Уншсан үлгэр, өгүүллэг тус бүрийн утгыг тодруулаад асуулт зохиож, ярилцаарай.

ЛАКШМИЙН СОЁРХОЛ

(Энэтхэг ардын үлгэр)



Эрт урьд цагт Эрлэг номун хаан, эд баялгийн тэнгэр Лакшми хоёр нэгэн удаа хүмүүсийг сорьж туршихаар азарган бороотой хүйтэн үдшээр өвгөн эмгэн хоёрын дүрд хувилан хүний ертөнцөд бууж иржээ.

Хотын нэгэн баян худалдаачны хаалган дээр ирж тогшсонд баян эр хаалгаа нээж, тэднийг хараад:

- Шавар шавхайтай хөлөөрөө шал бохирлох гээ юу? Шалавхан тонилж үз! гэж хэлжээ. Эмгэн гуйж залбиран:

- Баянтан гуай! Энэ харанхуй шөнө бид хаа очих юм бэ? Хүйтэн нойтонд бид хөлдөх нь байна. Хүү минь болгоож, саатан хонуулаач дээ гэжээ. Гэвч баян эр хаалгаа тасхийтэл хаажээ.

Гэтэл баяны өргөөний ойролцоохон нэг муу яйжийсан овоохой байх агаад эвдэрхий хаалганы нь завсраар зулын гэрэл сүүмэлзэн харагдах ажээ. Өвгөн нь эмгэндээ хэлж гэнэ:

- Нааш ир. Тэр айлд очиж, толгой хоргодох байр гуйж үзье. Тэгтэл эмгэн нь хэлж дээ:

- Ийм том баян толгой хоргодох газар өгөөгүй байхад энэ айл юугаа өгөх билээ? Өвгөн өгүүлрүүн:

- За юутай ч болсон, одоо би явах тэнхэлгүй боллоо гээд урагшилж очоод хаалгыг нь тогшжээ. Төдөж удсангүй гартаа дэнлүү барьсан, тос ис болсон уранхай орхимжтой нэг хүүхэн хаалга нээж, тэр хоёрын байдлыг хармагцаа л өрөвдөж хайрласан аялгаар:

- Ээ хөөрхийс, эмээ өвөө нар минь! Энэ харанхуй шөнөөр хаа хүрэх гэж явнам бэ? Алив, нааш ор. Дотогшоо морилоорой гэж гэнэ. Чингээд тэднийг түшиж тулсаар дотогш нь авч оржээ. Бөгс эргэхгүй шахам овоохойд эвдэрч хэмхэрсэн хоёр муу сийрсэн орноос өөр юм байсангүй. Гэрийн эзэгтэй нэгийг нь зайчилж, суухыг урьжээ. Өвгөн эмгэн хоёрын ноорхой хувцаснаас ус шүүрч, овоохойд чийг даасан боловч мөнөөх хүүхэн шалавхан тулгандаа гал ердөн тэднийг дулаацуулжээ. Дараа нь хэцэн дээрээс баахан хуучирсан боловч цэвэрхэн хоёр хувцас авчран:

- Эмээ өвөө нар минь нойтон хувцсаа тайлж, үүнийг углаж үзэхгүй юу. Бид их ядуу улс шүү. Та нарын хувцсыг хэцэн дээр тавиад хатаачихъя гээд тэдний хувцсыг тайлуулж аваад гарчээ. Буцаж ирэхдээ хоёр жижигхэн гуулин тавганд загалмай өвсний сүмс, хар гурилын бин хийж авчиржээ. Тэрээр эмгэнд хандаж:

- Ээж минь! Өнөөдөр манайд байгаагаас энэ л байна. Ядахдаа гэрт маань тос ч алга. Сүү ч дууссан, элсэн чихэр ч үгүй, хэцүүхэн л байна гэлээ. Өвгөн эмгэн хоёр хоол идэх зуураа:

- Зүгээр, зүгээр охин минь! Энэ хоол чинь их сайхан амттай байна гэж хэлжээ. Тэгтэл төдий л удсангүй гэрийн эзэн иржээ. Хөөрхий эр өдөржин бор хоногийн хоолны эрэлд яваад, сульдаж ядарсан амьтан буцаж ирсэн байв. Ирсэн зочдодоо хамаг хоолоо өгснөө эхнэр нь эр нөхөртөө сэмхэн шивнэхэд эр нөхөр нь ч баяртай байжээ. Дараа нь өөрсдийнхөө нөмрөг хучлагыг эмгэн өвгөн хоёрт өгч, сийрсэн орон дээрээ унтуулаад өөрсдөө нэг муу өрмөг даавуу нөмрөн газраар хэвтжээ. Үүрээр бороо арилсанд эмгэн өвгөн хоёр явахаар завдав. Гэрийн эзэгтэй алга хавсран наманчилсаар тэднийг нар гартал саатуулж, байсан буурцгаа нүдэж, гамбир хайраад хоёуланд нь хувааж өгөх зуураа:

- Ээж минь! Бид ядуу хоосон улс. Байгаагаараа л та нарыг дайлах гэсэн ч санаанд хүрсэнгүй. Уучилж өршөөнө байх гэж найдаж байна гэжээ.

- Ээ охин минь! Ядуу бидэнд та нар сайхан найр тавилаа. Үүнийхээ үр шимийг тэнгэр бурхнаас хүртэнэ. Өнөөдөр та хоёрт орж ирсэн юм өдөржингөө барагдахгүй байх болно гэж эмгэн хэлж гэнэ.

Ингээд тэд явж одсонд гэрийн эзэгтэй загалмай өвсний сүмс хийж байсан хувингаа цэвэрлэхээ гэнэт санаж, гал зуухныхаа овоохойд орж хувингаа автал юу байсан гэж санана. Хувинд нь дүүрэн алтан зоос байсанд мэл гайхаж, цэл хөхөрч гэнэ. Хөмөрч асгаад үзвэл дахиад л хувин нь дүүрээд иржээ. Хүүхэн тэдгээр алтан зоосыг газар овоолоод, хувингаа өөд харуулахад дүүрчихсэн л байдаг байж. Тэд алтан зоосоор үзэсгэлэнтэй сайхан орд өргөө худалдан авч, бөс даавууны дэлгүүр нээж, морин тэрэг, түүгээр ч үл барам хос морь бүхий сүйх тэрэг хүртэл худалдан аваад, аз жаргалтай амар сайхан жаргах болжээ.

Тэд тусархаг сэтгэлийнхээ ачаар сайхан амьдрахаар болсон уу? Эсвэл тэдэнд бурхан туслав уу?

Ядуу хөршийнх нь ганцхан шөнө л хэмжээгүй баяжсан тухай мэдээг нөгөөх баян худалдаачин сонсоод, эхнэр нөхөр хоёроос учрыг асуужээ. Хүүхэн болсон бүхий л явдлыг бодож тунгаалгүй хэлж гэнэ. “Хэрэв тэр ид шидтэй эмгэн өвгөн хоёртой учирдаг юм бол бид ч гэсэн хувин дүүрэн алтан зоостой болох нь шүү дээ” гэж баян эр, эхнэр хоёр өдрийн бодол, шөнийн зүүд болон гиюүрч суух болжээ. Золоор харин тэнгэр бурхан, хүний юу хүсэж байгаа чин зүрхний хүслэнг мэддэг байж л дээ. Азарган бороо шавшиж, мөндөр нүдсэн нэгэн хүйтэн шөнө мөнөөх эмгэн өвгөн хоёр баян худалдаачны хаалган дээр дахин иржээ. Хаалга тогших чимээг сонсонгуутаа баян худалдаачин цахилгаан дэнлүүгээ унтраан, оронд нь тосон дэн барьж, баяны эхнэр гарч ирээд, хуурамч зан гаргаж:

Ээ хөөрхийс, эмээ өвөө нар минь! Энэ харанхуй шөнө хаа зорьж явнам бэ? Алив нааш ир, дотогшоо ор! гэж гэнэ. Адгийн муу эвдэрхий сийрсэн орон дээр тэднийг суулгаж дээ. Дулаан хувцас олон байсан боловч гэрийн эзэгтэй урагдаж хуучирсан хоёр муу хувцасны тамтаг авчран өгөхдөө:

Эмээ өвөө нар минь, одоохондоо гэрт маань байгаагаас энэ л байна гэж хэлээд эмтэрч цуурсан тавганд ногооны сүмс, арвайн бин хийж өгчээ. Хаа нэгтээгээс урагдаж ноорсон хоёр

хөнжил өгч гэнэ. Баян худалдаачин, эхнэртэйгээ тэр л өрөөнд шалан дээгүүр гудас хаян хэвтэж гэнэ.

Үүрийн харанхуйгаар эмгэн өвгөн хоёр явахаар завдсанд гэрийн эзэгтэй буурцаг нүдэж бин хийгээд тэдэнд өгөх зуураа:

Ээж минь бид туйлын ядуу хоосон улс аа. Та нарыгаа тавтай тухтай цайлж дайлж ч чадсангүй. Гэвч бид бүхнийгээ өршөөн уучлах биз ээ гэж найдаж байна гэж өгүүлжээ. Эмгэн “Охин минь, бидэнд яаж л хандсан, яг түүнийхээ үр шимийг тэнгэр бурхнаас хүртэнэ. Өнөөдөр чиний гарт орж ирэх юм өнө мөнхөд үргэлжлэх болно” гэж хэлжээ.

Эмгэн өвгөн хоёрыг явахтай зэрэг эр эм хоёр хэрэлдэж гарчээ. Учир нь ногооны сүмсний хувинг би нээнэ, би нээнэ гэж маргалдсан ажээ. Адаг сүүлд нь хоёул тэр хувинг зэрэг зэрэг барьж авч, булаалдсанаас болж хувин нь хэмхэрч, өрөөгөөр дүүрэн загалмай өвс бутарчээ. Эхнэр нь өрөөгөө шүүрдэж эхлэв. Өрөөнийхөө нэг захаас цэвэрлэсээр явтал нөгөө талаас нь яах ийхийн зуургүй ялзарч илжирсэн загалмай өвс бутран гарсаар байлаа. Үүрээс эхлээд үдэш болтол өрөөгөө цэвэрлэж ядах болжээ. Үйл ажил ямар л байна, үр шим нь мөн тийм байдаг ажгуу.

*(Энэтхэг, балба, фижи ардын үлгэрүүд.
Хинди хэлнээс орчуулсан О.Сүхбаатар АБЯХ, УБ., 1980, 57-59 дүгээр тал)*

Уншиж ойлгосноо ярилцах

1. Бурхдууд ямар зорилгоор эмгэн өвгөний дүрээр ертөнцөд бууж ирэв?
2. Тэд хүмүүсийн ямар ямар зан чанарыг ойлгож авсан бэ?
3. Лакшмийн сорилтод тулгарсан хоёр гэр бүлийн тухай уншаад, юуг харьцуулж бодов?
4. Эмгэн өвгөн хоёрыг хаалга тогших үед баян худалдаачин цахилгаан дэнлүүгээ унтраан, оронд нь тосон дэн сольж байхдаа юу бодсон бол?

Үзэл бодлоо илэрхийлэх

1. Багаараа хэлэлцээрэй. Ярилцах сэдвээ сонгож болно.

1-р багийн ярилцах сэдэв:

Шуналтай зан чанарын талаар багаараа хэлэлцэнэ үү. Хэний дүртэй холбон тайлбарламаар байна вэ? Өнөө цагтай холбоно уу.

2-р багийн ярилцах сэдэв:

Хүний тусч сайхан сэтгэл ямагт сайн сайхныг дагуулдаг гэсэн утгыг хэний дүртэй холбон тайлбарлаж болох вэ? Өнөө үеийн хүмүүстэй, өөрийн зан чанартай холбоно уу.

3-р багийн ярилцах сэдэв:

Сайхан амьдралыг хүмүүст бурхад соёрхож, эсвэл хэн нэгэн хүн бэлэглэдэг үү? Аль эсвэл?

4-р багийн ярилцах сэдэв:

“Үйл ажил ямар л байна, үр шим нь мөн тийм байдаг” гэж дүгнэсний учрыг хэлэлцээрэй. Бодит амьдралаас жишээ татаж болно шүү.

5-р багийн ярилцах сэдэв:

Хуурамч зан чанар гэж юу вэ? Та нартай ийм хүмүүс таарч байсан уу? Юу гэж зөвлөхөө хэлэлцээрэй.

Уншихын өмнө

- Өөрөө өөрөөсөө асуу.
- Хүслийг биелүүлдэг шидэт бийртэй байсан бол юуг зурах вэ?
- Дараах үлгэрийг уншиж байхдаа хүний хүсэл, үл ханах шунаг сэтгэлийн тухайд эргэцүүлж бодно уу.

ШИДЭТ БИЙР

(Хятад ардын үлгэр)

Урьд Ма Лянь гэдэг өнчин хүү байжээ. Өвс зулгааж, гишүү түүсэн шиг амь зууна. Багаасаа л зурах дуртай ч ядмаг түүнд бийр авах мөнгө яаж олдох билээ. Гэсэн ч Ма Лянь шантарч мохсонгүй. Элсэн дээр гишүүгээр нисэж яваа шувуу дүрсэлж, усанд хуруугаа дүрэн, чулуун дээр сэлж яваа загас урлаж, орогнож буй агуйнхаа ханан дээр элдэв зураг зурсаар байлаа. Өдрөөс өдөрт, жилээс жилд зураг нь сайжирч амьд юм шиг л болсоор байв.

Нэгэн үдэш Ма Лянь харьж ирүүтээ чийрсэн дээр шууд л хэвтээд өгчээ. Өдөржин ажиллаад ядраа биз дээ, хөөрхий. Тэгтэл өмнө нь гэнэт цагаан сахалт өвгөн үзэгдэж:

- Шидэт бийр юм шүү! Зураад үз, хүү минь! гэснээ нэгэн бийр өгөв гэнэ. Бийрнээс алтан туяа цацарч байлаа. Хүү учиргүй баярлаад:

- Гялайлаа, өвөө! гэж хэлүүт нөгөө өвгөн алга болсон байв. Зүүдэлжээ. Хачин юм даа. Зүүд үү гэтэл гарт нь бийр атгаастай байв. Ма Лянь нөгөө бийрээрээ шувуу зураатахсан чинь тэр нь далавчаа дэвэн нисэж одов гэнэ. Тэр ч байтугай сайхан дуу нь хүртэл тэнгэрээс сонсогдож байв. Загас зурсан чинь усны гүнд сүүлээ шарван сэлж одлоо гэнэ.

Түүнээс хойш Ма Лянь тосгоны ядууст өдөр бүр хэрэгтэй бүхнийг нь зурж өгдөг болжээ. Анжисгүйд нь анжис, зээтүүгүйд нь зээтүү, хувингүйд нь хувин, дэнлүүгүйд нь дэнлүү зурж өгөх жишээтэй. Тэр чимээ чихнээс чих дамжсаар нутгийн хамгийн баян хүнд сонсогдов гэнэ.

Баян даруй зарц нараа явуулж, шидэт бийрт хөвгүүнийг баривчлан авчруулж, юу хүссэнээ зуруулах гэв. Хүү баяны бачит санааг мэдэх тул юу ч зурж өгсөнгүй... Мөр нүцгэн, гэдэс өлсгөлөн тосгоны ядууст хоргодовч ондоо газар бараа-дахаас аргагүй болсон хүү шидэт бийрээрээ морь зурж, түүнийгээ унан давхиж одов. Морин туурай тачигнамагц баян түүний араас илд далайсан зарц нарынхаа хамт нэхэн хөөв гэнэ. Хүү нум сум зурж, эргэн харватал баян мориноосоо халин унажээ.



Ма Лянь өдөржин шөнөжин давхисаар багавтар нэгэн хотод хүрч, тэндээ суурьшихаар шийдээд, зурсан зургаа худалдан аж төрж гэнэ. Өөрийгөө хэнд ч мэдэгдэхгүйн тулд зургандаа амь оруулалгүй дутуу зурдаг байжээ. Нэгэн удаа өрөвтас зурахдаа нүдийг нь дутуу орхив. Тэгтэл гай болж нүдний нь оронд яльгүй бэх дусчихаж гэнэ. Нөгөө өрөвтас ч нүдээ цавчлан харснаа гэнэт нисэн оджээ. Энэ мэдээ хотоос хот дамжсаар эзэн хааны чихэнд хүрэв гэнэ.

Эзэн хаан сайд түшмэдээ илгээж, зураач хүүг авчруулан өмнөө сөхрүүлж, юу хэлснийг минь зурсугай! хэмээн зарлиг буулгажээ. Ядуу хүмүүсийн зовлон дээр залран суугаа эзэн хаанд юу ч зурж өгөх билээ дээ. Эзэн хааныг “Луу зур!” гэхэд нь бах, “Хангарьд зур!” гэхэд нь тахиа зуржээ. Үзэшгүй муухай нүцгэн бах, үс нь зулгарсан тахиа хоёр хааны ордонд дэвхрэн чарлан түйвээж гарав. Эзэн хаан хилэгнэж шидэт бийрийг нь цэргийн хүчээр булааж, хүүг шоронгийн мухарт хаяжээ.

Тэгээд хаан өөрөө зураг зурж гарчээ. Эхлээд алтан уул зурлаа. Шунаг хаанд нэг алтан уул юу ч биш. Маш олон алтан уул зурлаа. Зурсаар байтал алтан уул нь бөөн чулуу болж, хөл доор нь бутран унажээ. Тэгэхээр нь хаан алтан тоосго зурж эхлэв. Хомхой сэтгэл нь хөдөлж өндрөөс өндөр болгож давхарлан зурсаар байтал уртаас урт могой болон хувирч, хааныг залгихаар амаа ангайв. Хэрэв хаан Ма Ляныг шоронгоос суллаж, шидэт бийрийг нь өгөөгүйсэн бол өдийд аварга могойн гэдсэнд залран суух байсан биз ээ.

Чингээд эзэн хаан хүүд ус зурахыг тушаав. Хүү толин цэнхэр тэнгис зуртал хаан:

- Наадах чинь загасгүй юм уу? гэв. Хүү түм буман загас сүлжилдүүлэн зурлаа. Эзэн хаан хүүд:

- Бушуухан далбаат онгоц зураатах! Тэнгист бид аялмаар байна гэв. Хүү модон онгоц зуртал эзэн хаан, хатан, хунтайж, гүнж, сайд, түшмэдтэйгээ түүнд суулаа. Ма Лянь бийрээ хэд эргүүлэн салхин зураас таттал далбаат онгоц ч хөвж эхэллээ. Эзэн хаан:

- Салхиа нэм! Салхиа нэм! гэв. Хүү шидэт бийрээ улам хүчтэй эргэлдүүлэн салхин зураас нэмтэл тэнгисийн ус цалгилж, далбаат завь дайвалзаж гарав. Эзэн хаан:

- Одоо болно. Салхиа багасга! гэж хоолойгоо сөөтөл хашхирсаар байсан ч хүү түүнийг үл сонсон, салхины хүчийг улам нэмэн зурсаар байв. Далбаат завь тэнгисийн эрчилсэн усанд цохигдож, эзэн хаан шураг модноо асаж, хүүгийн зүг гар даллан хашхирсаар байлаа.

Хүү эрчилсэн их зураас татаж салхины хүчийг улам нэмтэл их шуурга үүсэж, тэнгэр тэнгис орчилдон эргэлдэж, далбаат онгоц хэмх үсрэн, эзэн хааныхан живж үхжээ. Түүнээс хойш шидэт бийрт Ма Лянь хүү хааш одсоныг хэн ч үл мэднэ. Тосгондоо буцан очиж, тариачидтайгаа хамт аж төрж байгаа гэж зарим нь ярилцана. Тийм ч байж магад.

(Дэлхийн хүүхдийн хүүрнэл зохиолын дээж. II боть. Эмхэтгэгч, орчуулагч Ж.Дашдондог. УБ., 2012, 276 дугаар тал)

Уншиж ойлгосноо ярилцах

1. Ма Лянь хүү юунд шандардаггүй байв?
2. Хүү тосгоны ядууст хэрэгтэй зүйлийг нь зурж өгсөнд тэд юу гэж хэлсэн бол?
3. Хүү тэнгисийг зурж, эрчилсэн их зураас зурж байхдаа юу бодож байсан бол? Чи юу гэж төсөөлж байна вэ? Яагаад ингэж төсөөлөв?
4. Хаан, хүү хоёрын харилцааг чи хэрхэн үнэлж байна вэ?
5. Энэ үлгэрийг өөр хэн нэгэнд ярихаар бол чи юуг нь онцолж ярих вэ? Ямар жишээ татах вэ?

Үг сонголтын шалтгааныг тайлбарлах

1. Хүснэгтэн мэдээллийг уншаад, дүгнэж ярилцаарай.

Асуулт	Зохиолоос олж хариулсан нь	Үлгэрийг зохиосон хүмүүсийн бичсэн шалтгаантай та нар санал нийлж байна уу?
Шидэт бийр гэдгийг зохиолд юу гэж дүрсэлсэн байна вэ?	...бийрнээс нь алтан туяа цацарч байна...	Бийрийг шидтэй гэдгийг нь дүрслэхдээ бийрийг амьдшуулж биеэсээ туяа цацруулдаг, амьтай мэтээр бичжээ.
Хүүгийн зурсан зураг нь амьд мэт болсон гэдгийг ямар үгээр илэрхийлсэн байна вэ?	Шувуу далавчаа дэвэн ниссэн, дуу нь хүртэл тэнгэрээс сонсогдож, загас усны гүнд сүүлээ шарвасан	Зураг зурна гэдэг нь амьд мэт сэтгэгдэл төрүүлэх хэрэгтэй гэсэн санааг илэрхийлжээ.
Хааны хомхой сэтгэлтэй гэдгийг ямар үгээр, ямар орчныг бүтээснээр бичсэн бэ?	Шунаг хаанд нэг алтан уул юу ч биш. Алтан тоосго давхарлан зурсаар байтал урт могой болон хувирч, хааныг залгихаар амаа ангайв.	Ард түмнээ боддоггүй хааныг шүүмжилж, шуналтай зан хүнийг эвдэж, хүн биш болгодог гэдгийг харуулжээ.
Тэнгисийн орчны байдлыг ямар үгээр гаргасан байна вэ?	Тэнгисийн ус цалгилж, далбаат завь дайвалзаж, далбаат завь тэнгисийн эрчилсэн усанд цохигдож, их шуурга үүсэж, тэнгэр тэнгис орчилдон эргэлдэж...	Ма Лянь хүүгийн зургийн хүч чадал, хүүгийн авьяасыг гаргахын тулд эдгээр үгийг зохиолч хэрэглэжээ.

Үзэл бодлоо илэрхийлэх

1. Аливаа зүйлд шантрахгүй, оролдлого сайтай байна гэдгийг чи хэрхэн ойлгож байна вэ?
2. Та нар уншиж байхдаа хаанд хэрхэн хандаж байсан бэ?
3. Үлгэрийг уншиж дуусаад чи юу бодсон бэ?
4. Хэрэв чиний зурсан зураг бүр амилдаг бол чи юу зурах вэ?
5. Хүссэн зүйлээ бодитоор бүтээх боломж бидэнд бий юү? Тэгвэл чи юу хийх вэ?

Дүрийн зорилгыг тодорхойлох

1. Хүүгийн эрчилсэн их зураас татаж зурсны далд учир шалтгаан юу байв?
2. Хааны зурсан зураг яагаад нурж унаад, эсвэл могой болоод байсан бэ? Зохиолч энэ дүрээр юуг хэлэхийг хүссэн бэ?
3. Ма Лянь хүүгийн зурсан зураг амилчихдаг гэдгийг хаан яаж мэдэв? Тэр ямар зарлиг буулгасан бэ? Түүний зарлигаас хааны зорилгыг тодорхойлоорой.

Орчныг төсөөлөх

1. Уншиж байхдаа үйл явдлын орчныг яаж төсөөлж байв?
2. Төсөөлсөн орчноо зургаар илэрхийлнэ үү.



АС-СИНДБАД ХААНЫ ҮЛГЭР

(Араб үлгэр)

Урьд эрт цагт перс газар наадам зугаа, ан гөрөөнд их дуртай нэгэн хаан байжээ. Тэр хаан нэгэн шонхор тэжээж, түүндээ их хайртай учир өдөр шөнөгүй дэргэдээ байлгах агаад анд явахдаа авч явна. Хүзүүнд нь алтан аяга зүүж, түүнд хоол хийж өгдөг байжээ.

Хаан нэг өдөр анд явж нэгэн их хөндийд хүрээд өгөөш тор тавьсанд нэг шаргачин оржээ. Хаан:

- Шаргачныг толгой дээгүүрээ харайлган алдсан хүнийг ална гэжээ. Анчид торыг хумисаар байтал мөнөөхөн шаргачин хааны урдаас ирж, урд хоёр хөлөө нугалан, яг л мэхийн сөгдөх мэт болж, хаан дохитол толгой дээгүүр нь харайн гараад алга болов. Нөгөө анчид өөр хоорондоо нүд ирмэн, ярилцан байхыг хаан харж:

- Аяа, шадар сайд эд нар юу ярилцнам бэ? хэмээвээс

- Шаргачныг толгой дээгүүрээ харайлган алдсан хүний толгойг авна гэж хаан хэлсэн гэгцгээж байна гэсэнд хаан:

- Би заавал тэр шаргачныг намнан алмуй гээд мөрдөн хөөж оджээ.

Шаргачин нэгэн хонхорт далд орохын даваан дээр бүргэдээ тавьсанд гүйцэн очиж, далавчаар нүдийг сох цохитол хаан хүрч очоод, бороохойгоор цохин алаад, дор нь өвчиж ганзагалав. Жин үдийн алдад тэрхүү их цөл газар усгүй учир хаан ч цангаж, морь нь ч ихэд цангажээ. Эргэн тойрон хартал нэгэн модноос тос мэт өтгөн ус гоожин буй дор бүргэдийн хүзүүнээс алтан аяга авч тосоод, уух гэтэл бүргэд далавчаар аягыг цохиж хөмрүүлэв. Бүргэдийн ам бас цангажээ гэж бодоод дахин аягаа тосон дүүргэж, өмнө нь тавитал далавчаар цохиж хөмрүүлэв.

Хаан баахан хилэгнэн, дахин тосож дүүргээд, морины аманд тавьтал бүргэд аанай л далавчаараа цохиж хөмрүүлжээ. Хаан:

- Аяа, муу заяат жигүүртэн чамайг Аллах залхаах болтугай! Чи надад, миний моринд, өөртөө юунд унд эс уулгана! гэж хилэгнэн сэлмээ сугалан далавчийг тас цавчив. Гэтэл бүргэдийн дээш заах маягтай өлийсний дагуу харваас модны оройд хорт могойн зулзага хороо гоожуулж байжээ. Хаан тэндээс мордож, майхандаа очоод, улмаар хотдоо буцав. Харьж мөнөөхөн алсан шаргачныг тогоочид өгөөд ордондоо ирж суутал бүргэд нь нэг удаа муухай хашхираад үхжээ. Хаан аминд орсон бүргэдээ алав гэж ихэд гашуудсан гэдэг.

(Мянга нэгэн шөнийн үлгэр, Орос хэлнээс орчуулсан С.Бадраа, УБ., 1985, 34 дүгээр тал)

Уншиж ойлгосноо ярилцах

1. Наадам зугаанд дуртай хаан ямар ямар муу үйл хийв?
2. Шонхор яагаад далавчаараа аягыг цохиж хөмрүүлээд байсан бэ? Шонхор шувуу юу бодсон бэ?
3. Шувууныхаа хүзүүнд нь алтан аяга зүүж, хоол өгдөг гэдгийг уншаад та нар юу бодов? Хаан шонхор шувуугаа хайрлаж чадсан уу?
4. Шонхор шувуу үг хэлж чаддаг бол юу гэж хэлэх байсан бол? Хүнийг үгээр нь биш үйлдлээр нь танихын тухай сургасан зохиол гэж дүгнэвэл та нар санал нийлэх үү? Яагаад?

Дүрийн үг, үйлдлээс зорилго тодорхойлох

1. Хааны дүрийг Ч.Лодойдамбын “Шаргачин” өгүүллэг дэх дүрүүдийн зорилготой харьцуулаарай.

ӨГҮҮЛЛЭГ



ЛЕВ НИКОЛАЕВИЧ ТОЛСТОЙ (1828-1910)

Төрсөн нутаг: Оросын их зохиолч Л.Н.Толстой нь Тул мужийн ойролцоо оршдог Ясная Поляна гэдэг газар язгууртны гэр бүлд төржээ.

Гол уран бүтээл: “Дайн ба энх”, “Анна Каренина”, “Сэхээрэлт” гэх мэт олон зохиол нь дэлхий дахинаа алдаршжээ.

Зохиолчийн хэлсэн онцлох үг: Мууг таслан зогсоох ганц л арга буй. Тэр нь муу хүмүүст сайнаар хандах явдал юм.

ШУДАРГА ШҮҮГЧ

Алжирын хаан Бауакас өөрийнх нь нэгэн хотод маш шударга шүүгч байдаг, түүнээс нэг ч зальт этгээд бултан гарч чаддаггүй гэж сонсоод үнэн худлыг нь нүдээр үзэхээр явжээ. Бауакас худалдаачны хувцас өмсөж, шүүгчийн суудаг хот руу мориор гарчээ. Хотын зах руу орж ирэхэд нэгэн доголон эр:

- Ивээл үзүүлээч гэж Бауакасаас гуйжээ. Бауакас түүнд мөнгө өгөөд цааш явах гэтэл доголон, хувцаснаас нь зууралдаад тавихгүй байв гэнэ.

- Чамд юу хэрэгтэй юм бэ? Би чамд мөнгө өгсөн биш билүү? гэж Бауакас асуухад доголон:

- Өгсөөн өгсөн, гэхдээ дахин нэг ивээл үзүүлээч дээ, намайг сундлан талбай хүргээд өгөөч, морь малын хөлд гишгэгдчих гээд хөөрхий надад хэцүү байна гэжээ.

Бауакас түүнийг сундалсаар талбай хүрээд зогстол ядуу хүн буусангүй гэнэ. Бауакас:

- Яагаад суугаад байгаа юм бэ? Бид талбайд ирлээ, буу гэхэд ядуу:

- Яагаад би буудаг билээ? Энэ морь чинь минийх, эвээр хэлээд морийг минь өгөхгүй бол шүүгчид очъё гэжээ.

Тэр хоёрыг ийнхүү маргалдахыг сонссон хүмүүс:

- Шүүгчид очицгоо! Шүүгч учрыг нь дор нь олно гэж хашхиралджээ.

Бауакас, доголон эр хоёр шүүгчид очиж гэнэ. Тэнд бас л олон хүн иржээ. Шүүгч тэднийг дэс дараалан дуудах аж.

Бауакасын ээлж болохоос өмнө шүүгч эрдэмтэн, хархүү хоёрыг дууджээ. Тэр хоёр эхнэрээс болжээ. Хархүү эхнэрийг минийх гэж, эрдэмтэн бас л минийх гэжээ. Шүүгч тэр хоёрыг анхааралтай сонсоод:

- Эхнэрээ орхиод явцгаа. Маргааш ирцгээгээрэй гэв.

Эрдэмтэн, хархүү хоёр явсны дараа махны худалдагч, тосны худалдагч хоёр шүүгч дээр очжээ. Махны худалдагч нил цус, тосны худалдагч цул тос болсон байв. Махны худалдагч гартаа мөнгө барьчихсан байх агаад тосны худалдагч махны худалдагчийн гараас зуурчээ. Махны худалдагч:

- Би үүнээс шар тос аваад мөнгөө төлөх гэж хэтэвчээ гаргатал энэ хүн гараас минь шүүрч мөнгийг минь булаах гэв. Ингээд бид тан дээр ирлээ. Би өөрийнхөө хэтэвчийг барьж байна, харин энэ хүн миний гараас зуурчхаад байна. Мөнгө минийх, энэ хүн хулгайч гэв. Тосны худалдагч:

Энэ худлаа, махны худалдагч надаас тос авахаар ирсэн. Би түүний домбонд дүүрэн шар тос хийгээд өгтөл намайг нэг алтан зоос задлах уу? гэлээ. Би мөнгөө гаргаад лангуун дээрээ тавьтал энэ хүн аваад зугтах гэлээ. Ингээд би гараас нь шүүрч аваад энд авчирлаа гэв. Шүүгч дуугүйхэн сонссоноо:

- Мөнгөө орхиод явцгаа, маргааш ирээрэй гэжээ.

Бауакас, доголон хоёрын ээлж болоход Бауакас юу болсныг ярьжээ. Шүүгч түүний хэлэхийг сонсоод ядуугаас юу болсон бэ? гэж асуув. Ядуу:

- Энэ бүгд худлаа. Би хотоор дайран давхиж явтал энэ хүн газар сууж байснаа намайг хүргэж өгөөч гэж гуйсан юм. Би түүнийг сундалж хэрэгтэй газар нь хүргээд өгтөл мориноос буухгүй, харин миний морийг өөрийнхийгөө гээд байх юм. Энэ бол худлаа, морь минийх гэж ярив. Шүүгч бодолхийлснээ:

- Морио орхиод явцгаа, маргааш ирээрэй гэжээ. Дараа өдөр нь шүүгчийн шийдвэрийг сонсохоор олон хүн цуглав.

Эхлээд эрдэмтэн, хархүү хоёр орлоо. Шүүгч:

- Эхнэрээ аваад харь гэж эрдэмтэнд хэлээд харин хархүүг тавин удаа саваад гэв. Эрдэмтэн эхнэрээ авч, хархүүг дор нь шийтгэв. Тэгээд шүүгч, махны худалдагчийг дуудан:

- Энэ мөнгө чинийх гэж өгөөд тосны худалдагчийг бас л тавь саваад гэв. Дараа нь Бауакас, доголон хоёрыг дуудав.

- Хорин морин дотроос өөрийнхөө морийг таних уу? гэж Бауакасаас асуув.

- Танина аа. Аа чи?

- Би ч танина гэж доголон бас хариулав. Тэд агтны хашаанд орцгоолоо. Бауакас хорин морины дотроос өөрийнхөө морийг дор нь л заав. Дараа нь доголонг дуудаж үзүүлбэл доголон морийг нь таньж, бас л - Энэ гэв. Тэгэхэд шүүгч суудалдаа эргэж суугаад Бауакасад:

- Морь чинийх, аваад яв гээд доголонг басхүү тавин удаа саваадах тушаал өгөв.

Шүүхийн дараа шүүгч гэр лүүгээ явахад Бауакас түүний араас дагав.

- Чи надаар яах гээ вэ? Миний шийдвэр буруу гэж үү? хэмээн шүүгч асуухад:

- Үгүй ээ, үгүй. Таны зөв. Гагцхүү эхнэр эрдэмтнийх, мөнгө махны худалдагчийнх, морь минийх гэж та яаж мэдэв гэдгийг л мэдэх гэсэн юм. Шүүгч:

Эхнэрийн тухай бол, би түүнийг өглөө дуудаад:

- Янтайд бэх хийгээдэх гэлээ. Эхнэр янтайг хурдан угааж цэвэрлээд их л дадамгайгаар бэх хийлээ. Ингэж хийж сурсан нь нүдэнд илхэн байлаа. Хэрвээ хархүүгийн эхнэр байсан бол үүнийг хийж чадахгүй байсан юм. Ингэхлээр эрдэмтний үнэн ажээ.

- Мөнгөний тухайд бол, мөнгийг би аягатай усанд хийгээд хонолоо л доо. Өглөө босоод усан дээр тос хөвж байна уу, үгүй юу? гэдгийг харлаа. Мөнгө хэрвээ тосны худалдагчийнх байсан бол бөөн тостой байх ёстой сон. Усан дээр тос хөвж харагдсангүй. Ингэхлээр махны худалдагчийн үнэн ажээ. Морины талаар мэдэх нэлээд хэцүү байлаа. Доголон эр хорин морины дотроос чиний морийг яг л чам шиг шууд л олсон шүү дээ. Гэхдээ би зөвхөн та хоёрын морио таньж байна уу, үгүй юу гэдгийг мэдэх гэсэн юм биш, харин та хоёрын хэнийг чинь морь таньж байна гэдгийг харах гэсэн юм. Чамайг ойртоод очтол морь толгойгоо чам руу хандуулан, чиний зүг тэмүүлээд байсан. Доголон эрийг ойртоод очтол морь чихээ хулмайлан нэг хөлөө өргөсөн.

Ингэхлээр чамайг жинхэнэ эзэн нь мөн гэдгийг би мэдсэн дээ гэлээ. Тэгэхэд нь Бауакас:

Би худалдаачин биш, хаан Бауакас. Чиний тухай яриа үнэн үү, худлаа юу гэдгийг нүдээр үзэхээр ирсэн юм. Ингээд чамайг үнэхээр мэргэн шүүгч юм гэдгийг харлаа. Юу хүсэж буйгаа хэл, би чамайг шагнаа гэхэд шүүгч “Надад ямар ч шагнал хэрэггүй” гэж хариулжээ.

(Дэлхийн хүүхдийн хүүрнэл зохиолын дээж, II боть, Эмхэтгэгч, орчуулагч Ж.Дашдондог, УБ., 2009, 28-31 дүгээр тал)

Зохиолчийн үг сонголтын шалтгааныг тайлбарлаж, зохиолын утгыг мэдэрч ойлгох

1. Зохиолоос ямар үгийн утгыг мэдэхгүй байсан бэ?
2. Тэр үгийн утгыг өөрийнхөөрөө яаж таамагласан бэ? Таамаглахад чинь ойр орчмын үг, өгүүлбэрийн утга хэрэг болсон болов уу?
3. Тухайн үгийн утгыг мэдэхийн тулд юу хийх ёстой вэ?
4. Хэрэв чи зохиолчийн оронд байсан бол ямар үгийг сонгон хэрэглэх байсан бэ?

Тэмдэглэсэн үгс	Үгийн утгын хам орчны тэмдэглэл	Миний бодлоор ийм утгатай	Толь бичигт ийм утга илэрхийлсэн байна.	Миний үг сонголтоор
Хэтэвч	- Би үүнээс шар тос аваад мөнгөө төлөх гэж хэтэвчээ гаргатал энэ хүн гараас минь шүүрч мөнгийг минь булаах гэв... Би өөрийнхөө хэтэвчийг барьж байна.			
Домбо				
Саваа /саваадах/				
Янтай				
Хулмайлгах				

Зохиолын агуулгыг ойлгосноо ярилцах

Хэн хэн маргалдсан бэ?	Юунаас болж маргалдсан бэ?	Хэн нь заргаа авч чадсан бэ?	Шүүгч хэрхэн шийдвэрлэсэн бэ?

Зохиолын утгыг тодруулан асуулт зохиож ярилцана уу. Тухайлбал:

1. Хааны нэрийг хэн гэдэг вэ?
2. Зохиолын үйл явдал хаана өрнөсөн бэ?
3. Хаан шүүгчийн араас яах гэж дагаж явсан бэ?
4. Шүүгчийн гаргасан шийдвэр бүрийг хаан сонсоод юу гэж бодсон бол?
5. Хааны шагналаас шүүгч яагаад татгалзсан бэ?
6. Зохиолоос хамгийн их таалагдсан хэсгээ ярина уу.
7. Уншиж байхдаа хэнийг их өрөвдөж, шоолж, хайрлаж, буруутгаж, өмөөрч байсан бэ? Яагаад?
8. Уншиж байхдаа та нар доголлон эрд хэрхэн хандаж байсан бэ?

Дүрүүдийн зорилгыг тодорхойлох

61 дүгээр хуудасны бүдүүвчийг ашиглан дүрүүдийн зорилгыг тодорхойлоорой.



ОСКАР УАЙЛД (1854-1900)

Төрсөн нутаг: Англи улсын Дублин хотноо төржээ.

Гол уран бүтээл: Түүний “Аз жаргалтай ханхүү”, “Залуу хаан” болон бусад өгүүллэгүүд нь хайр энэрэл, хүмүүнлэг үзлийг илэрхийлсэн байдаг.

Зохиолчийн хэлсэн онцлох үг: Хүүхдийг сайн хүн болгох шилдэг арга бол тэднийг жаргалтай байлгах явдал юм.

ТОСГОНЫ ОВГОР

Түүнийг хэн нь ч Овгор гэж нэрлэсэн юм бэ, бүү мэд. Лав л маш сайхан цэцэрлэгтэй юм даг. Хүүхдүүд тэнд очиж тоглох дуртай. Номин ногоон зүлэгнээс цасан цагаан цэцэг од шиг гэрэлтээд ямар гоё гэнэ. Моддын мөчир хаврын цагт цэцгээр дүүрч, намар тэр нь жимс болон бөнжийнө. Дээгүүр нь шувуу жиргээд, дэргэдүүр нь хүүхэд гүйдээд сайхан даа тэнд сайхан!

Тэгтэл нэг өдөр байдал бишдэв. Өөр тосгонд найзындаа очиж долоон жил болсон Овгор эдлэндээ буцаж ирлээ. Бодвол найзтайгаа хөөрөлдөх хамаг яриа нь дууссан юм байгаа биз. Мань Овгор цэцэрлэгтээ наадаж байсан жаалуудыг хараад “Хөөе! Миний хувийн эдлэнд та нар чинь дураараа дургиж байх шив дээ?” гэв. Хүүхдүүд ч годхийн алга болов. Тэдний араас Овгор “Энэ цэцэрлэгт надаас өөр эзэн байхгүй. Та нар дахиад ирээд үзээрэй, дуулав уу?” хэмээн хашхирлаа. Тэгээд Овгор цэцэрлэгээ тойруулж хэрэм бариад “Хувийн өмчийг хуулиар хамгаална” гэсэн бичигтэй самбар босгов.

Яая гэх вэ дээ, ядуу хүүхдүүдэд тоглох газар ямар олдох биш. Зам дээр тоглохоос өөр газар олдсонгүй. Гэсэн ч тэнд шороо босоод нэг л тавгүй. Тэгээд бас чулуутай овгор товгор газар яаж ч сайхан тоглох билээ. Хичээл тараад хүүхдүүд Овгорын хэрмэн хашааны дэргэдүүр өнгөрөхдөө “Энэ цэцэрлэгт бид ямар хөгжөөнтэй сайхан тоглож байлаа даа” хэмээн ярилцахаас цаашгүй. Удалгүй хавар болж амьд байгаль сэргэж эхэллээ. Харин тосгоны Овгорын цэцэрлэгийг хавар хатагтай тойрч өнгөрсөн бололтой. Тэндхийн мод нь ч цэцэглэсэнгүй, шувууд нь ч



жиргэлдсэнгүй. Өвсөн дундаас нэгэн цэцэг хасын царайгаа цухуйлган, нөгөө хориг тавьсан самбарыг харснаа, хөмсөг зангидаж тэгээд ч хүүхдийн хөгжөөнт дуу алга болохоор эргэн шургав. Тэгж байтал тэнгэр бүүдийж цас шуурч эхэллээ. Цасан дундах арвагар сарвагар модод цаасанд барласан сийлбэр зураг мэт. Түүнийг цонхоороо ширтсэн Овгор санаа алдаж “Тосгоны бусад цэцэрлэг нь нов ногоон байхад манайх яагаад цав цагаан байна вэ? Үүнийг юу гэж ойлгох вэ?” хэмээн өөрөө өөртэйгөө ярина. Гэсэн ч Овгор манай цэцэрлэгт урин цаг ирнэ гэж хүлээсээр байлаа. Харамсалтай нь хавар алга. Овгор нэг өглөө орондоо хэвтэж байтал хөгжим уянгалах шиг болов. “Юу вэ, хааны хөгжимчид гадуур явж өнгөрөв үү?” гээд өндийн хартал юу ч алга. Дахиад л хөгжим. Тэгтэл нэг бяцхан дууч шувуу цонхны нь цаана жиргэж байлаа. Овгор шувуудын уянгат жиргээг сонсолгүй уджээ. Анхилуун

сайхан үнэр цонхоор сэнгэнэн орж ирэхэд Овгор “Одоо л нэг хавар ирлээ” гээд орноосоо яаран бослоо. Тэгтэл нүдэнд нь юу харагдсан гэнэ? Моддын мөчир дээр хүүхдүүд суугаад дууч шувууд шиг шаагин шуугин байв гэнэ. Хэрэмний доогуур тэд шурган орсон бололтой. Хүүхэд суусан мөчир бүхнээс цэцэг гарчээ. Тэд баярлахдаа цэцэглэсэн бололтой. Зүлэг сугсран ургаж, цэцэг дэлбээгээ дэлгэж, шувууд хөгжилдөн жиргэнэ. Цэцэрлэгийн нэгээхэн буланд цас үзэгдэв. Тэнд нэг жаахан хүүхэд модны мөчирт авирч чадаагүй тул өвлийн тасархай үлдсэн мэт. Дэргэд нь буй мод мөчрөө бөхийлгөн “Хүү минь надад амьдрал өг” гэх шиг шивнэн байв. Хүү ч мөчир дээр авиран гарч, модны нахиа ч дэлбээгээ нээх нь үзэгдлээ. Цэцэрлэг хүүхдүүдээ санасан байжээ. Тэгээд аз жаргалтай байсан сайхан цагаа мартжээ. Тэр бүхнийг тосгоны Овгор ойлгоод “Аа, хавар хожимдсоны учрыг сая л мэдлээ. Тэд чинь хүүхдийн цовоо сэргэлэн дууг сонсохгүй бол цэцэглэдэггүй юм байна. Би яасан муухай хувиа бодсон эр вэ? Ядуусын хүүхдүүдийг чөлөөтэй тоглуулъя. Хэрмэн хашаагаа ч нураая. Цэцэрлэг минь үеийн үед хүүхдийн хөгжилдөн тоглох газар байг!” хэмээн амандаа үглэв.

Чингээд Овгор цэцэрлэгтээ сэмээрхэн ороход хүүхдүүд түүнийг харуутаа зугтав. Цэцэрлэгт дахиад л өвөл болж эхлэх нь тэр. Нөгөө буланд байсан жаал хүү зугтаж амжилгүй айсандаа уйлж зогсов. Овгор тэр жаал хүүг өргөн авч мөчирт нь буцаан суулгав. Тэгсэн чинь л нөгөө модны цэцэг дэлгэрч, шувууд мөчрийг нь дамжин жиргэж гарлаа. Нэг харах нь ээ, жаал хүү Овгорын хүзүүг тэвэрч авлаа. Хүүхдүүд “Ямар ч гэсэн Овгор уургүй байгаа юм байна” хэмээн бодож дөхөн дөхсөөр буцан ирэв. Хавар дахиад л хүүхдүүдийг даган айсуй.

“Овгорын цэцэрлэг одоо та нарынх!” гэж хэлүүтээ лантуу авч том хэрмийг нурааж эхлэв. Бага үдийн үеэр тосгоныхон зах явах замдаа хүүхдүүдтэй хамт хөгжилдөн тоглож буй Овгорыг олж харжээ. Түүнээс хойш олон ч жил өнгөрч. Насны эрхээр Овгор маань хүүхдүүдтэй наадаж чадахаа ч байж. Харин гаднаа исэр сандалд сууж, дураараа наадан тоглож буй хүүхдүүдийг харж хайрлан өхөөрдөөд “Би ч олон сайхан цэцэгтэй хүн дээ” хэмээн бахархах болжээ. Энэ дэлхийн хамгийн сайхан цэцэг нь хүүхэд гэдэгтэй маргах хүн нэгээхэн ч үгүй биз.

*(Дэлхийн хүүхдийн хүүрнэл зохиолын дээж, II боть, Эмхэтгэгч, орчуулагч
Ж.Дашдондог, УБ., 2009, 40 дүгээр тал)*

Зохиолын агуулгыг ойлгосноо ярилцах

1. Зохиолын утгыг тодруулж бие биедээ асуулт тавиарай.
2. Зохиолыг эхлээд уншихад юу бодогдсон бэ?
3. Зохиолыг уншихад ямар үг, ямар дүрслэл, ямар санаа, ямар дүр сэтгэлийг чинь их татсан бэ?
4. Яагаад сэтгэлийг чинь их татав? Ямар мэдрэмж төрсөн бэ?
5. Зохиол ямар санагдав? Аль дүрд хэрхэн хандав? Сайнаар уу, муугаар уу? Яагаад ингэж хандаж байгаагаа илэрхийлээрэй. Зохиолоос жишээ баримт татаж болно.
6. Зохиолд гүн гүнзгий юм уу эсвэл өвөрмөц содон ямар санаа байсан бэ?

Дүрийн зорилго, зан төрхийг тодорхойлох.

	Дүрүүдийн хийсэн үйлдлийг тоочин бичнэ үү.	Ямар зорилгоор ийм үйлдэл хийсэн бэ?	Зохиолч ямар дүр бүтээхийн тулд ийм үйлдэл хийлгэсэн бол?
Овгор			
Хүүхдүүд			

ЦААСАН ОНГОЦНЫ ҮЛГЭР

Өглөө болж наран мандсан ч Сакүн нойрондоо дийлдэн унтсаар л байлаа. Тэгтэл базаж бөөрөнхийлсөн нэгэн цаас ширээн дээрээс нь өнхрөн унаж орны нь өмнө очоод “Босоорой хөөе! Миний төрсөн Африк руу хамт явцгаая!” гэх нь тэр. Сакүн унтсаар л. “Хөөш, явахгүй юм уу?” гэхэд Сакүн нойрмоглон нүдээ нээв. Нөгөө цаас цонхоор цэцэрлэг рүү харж бас л “Бидэнтэй хамт аялах уу?” гэж хашхирлаа. Эхлээд л “Ммсс ммсс” гэсээр цох, араас нь аалз, чийгийн улаан хорхой, царцаа, шоргоолж, нуруундаа жижигхэн шавж суулгасан зөгий, фүв фүв дэвсээр эрвээхэй яаран ирлээ. Тэгж байтал Сакүний хайртай нохой, муур, тэр ч байтугай бяцхан цөөрмийн загас хүртэл айсуу. Нийлээд арван нэгүүлээ болов. За, за одоо боллоо. Ийм олуул яаж явах болж байна вэ? Бүгд л бодолд оров. Тэгтэл цаас ам нээж “Санаа зовох хэрэггүй. Үрчийсэн намайг тэнийлгэн дэлгэвэл онгоц болж мэднэ” гэв. Нээрэн, хумхиад хаячихсан тэр цаасыг тэнийлгэн толийлговол ямар болсон гэнэ? Маш том! Тэгээд яахав, онгоц хийгээд л аян замдаа гарах нь тэр. Сууцны байшин, гудамжинд чихцэлдсэн машин, цэцэрлэгийн дээгүүр нислээ. Тэгтэл цэцэрлэг дундаас нэгэн аварга мод далбайсан том навчаараа даллан “Амьсгалах цэвэр агаар өгөөч? Хотын утаанд хордож, ногоон бие минь хар боллоо” хэмээн халаглах нь өрөвдөлтэй. Сакүн, түүний бяцхан нөхөд хэчнээн санаа зововч “Хичээгээрэй, тэсээрэй!” гэхээс цаашгүй байлаа.

Салхи үлээх тусам цаасан онгоц улам л өндрөө авсаар байв. Мод, байшин, хот харагдахаа болив. Тэгтэл тээр доор нэг тэмээ баян бүрднээс ус ууж харагдана. Сакүн болон түүний бяцхан найзууд цөм баярлалдан доош буулаа. Ам нь цангасан болоод ч тэр үү, усны амт бараг зуу дахин нэмэгдсэн бололтой. Тэгтэл элсэн дундаас нэгэн цэцэг “Жилд ганцхан удаа бороо ороход л болох нь тэр. Бид ямар ч ганг тэсэж чадна” гэхэд бяцхан аялагчид бүгд л шагшин биширч байв.

Өндөр уулсыг даван өргөн далай дээгүүр ниссээр зорьсон газраа ирлээ тэд. Тэр бол ноён цаасны төрсөн нутаг. Хэчнээн баяртай очсон ч оройтжээ. Юу гээч болчих нь энэ вэ? Эргэн тойрон хожуул. Өргөн уудам их талыг бүрхэж байсан өтгөн ногоон мөчирт төрөл садан нь хаачив? Төрсөн нутаг нь энэхэн бага хугацаанд элсэн цөл болж хувирсанд цаас үнэхээр харамсан гашуудаж байв. Цорын ганц зулзаган хар цөргөс мод л үлджээ.

Түүний өгүүлсэн нь “Би гурван настай. Насанд хүрч талийгаач төрөл садныхаа зиндаанд хүрэхэд дор хаяж зуун жил хэрэгтэй. Тэднийг маань толгой дараалан хядаж агшин зуурт



цаас болгосон. Цаасаар та нар амьсгалах уу?” гэв. Тэд их багагүй л санаа алдаж “Ай хөөрхий, ой модгүй бол бид юугаар амьсгалах билээ. Тэгсгээд л дуусна биз?” гэлцэнэ. Чийгийн улаан, бяцхан шавж хоёр цөргөс модыг тайвшруулж “Унасан навчийг тань бид идэж шим тэжээлээр таныг тэтгэнэ ээ, гайгүй. Нэг л мэдэхэд өтгөн ой найгаж байх болно” гэлээ. Үдэш болж одод түгэв. Аялагчид бүгд түүнийг ширтэж “Хорвоод хамгийн ухаантай нь хүн атал амиа хорлож байгаагаа яагаад ухаардаггүй юм бол доо” гэлцэж байлаа.

Хөөрхий цаас уруу царайлан үрчийж “Мод хоромхон зуур цаас болно. Харин цаас хэзээ ч мод болохгүй. Ай, юутай харамсалтай” хэмээн гасалж суув. Тэгснээ гэнэт омог нь бадран шаржигнаж “Аа ер нь яадаг юм бэ, ерөөсөө би дахин амилахаар шийдлээ. Хэдийгээр би хумигдсан ч өөр шинэ цаас болон хувиръя. Нэг мод ч гэсэн амьд үлдэг. Цаасны халуун тогоо руу, урагшаа!” гэхэд нөхөд нь дэмжив.

Цаасан онгоц дахиад л дээш хөөрлөө. Дэлхийн хаа нэгтээ цаас хийдэг том тогоо амаа ангайх мэт харагдлаа. “Харав уу, тэр бол модон төрлөөс цаасан биеийг олсон газар!” гэв. Цаас хийдэг газраас цаасны хоолойгоор дуулах нь сонсогдоно. Ийм дуу,

Зузаан нимгэн номын цаас
Зурагтай сонин сэтгүүлийн цаас
Гагцхүү эндээс гардаг цаас
Гараг дэлхийг бүрхдэг цаас...
Хаясан цаас голсон цаас
Халуун тогоо руу харайн орж
Эрэлхэг зоригт хуучин цаас
Энэ дэлхийд дахин төрнө...

“Байзаарай, байзаарай!” гэж Сакүн хашхираад орон дээрээсээ пидхийн уналаа. Цонхоор харвал өмнөөс нь нэгэн цох “Ммсс ммсс!” гэлээ. “Сайн байна уу?” гэж мэндчилж байгаа нь тэр байх. Бас нэгэн шавж Сакүнийг ширтэн зогсоно. Таньж байгаа бололтой.


Сакүн ширээн дээр базаад хаячихсан цаасаа харав. Тэгээд “Уучлаарай, цаас минь!” гэж амандаа хэлээд, түүнийг тэнийлгэн толийлгож онгоц хийлээ. Улмаар түүнийг алган дээрээ тавьж “Наддаа л алт!” хэмээн шивнэн хэлсэн ч өчүүхэн шавжнаас эхлээд амьтан бүхэн сонссон гэдэг.

*(Дэлхийн хүүхдийн хүүрнэл зохиолын дээж, II боть, Эмхэтгэгч, орчуулагч
Ж.Дашдондог, УБ., 2009, 351 дүгээр тал)*

Зохиолын утгыг ойлгосноо ярилцах

1. Гол дүр Сакүн зүүдэлсэн үү? Эсвэл түүнд бодитоор тохиолдсон уу?
2. Базаж бөөрөнхийлсөн цаас хаашаа явахаар найзуудаа уриалсан бэ?
3. Зохиолын үйл явдал хаана хаана өрнөж байна вэ?
4. Цэцэрлэг дундаас аварга модны хашхирахыг та нар сонссон бол юу гэж хэлэх вэ?
5. Чийгийн улаан, бяцхан шавж хоёр цөргөс модыг хэрхэн тайвшруулсан бэ?
6. Цөргөс модны “Цаасаар та нар амьсгалах уу?” гэж хэлснийг шүүн тунгаагаарай.
7. Хүүгийн “Наддаа л алт” гэж хэлсэнтэй санал нэгдэж байна уу? Яагаад?

Дүрийн зорилгыг тодорхойлох



Өгүүлэгдэхүүний дарааллаар тайлбарлах

Эхлэл	Зангилаа	Өрнөл	Туйл	Тайлал
Зохиолч хэнийг яаж танилцуулсан бэ?	Үйл явдал юунаас болж өрнөв?	Өрнөл хэсгийг дахин сонгож уншаарай. <ul style="list-style-type: none"> • Гол баатарт юу юу тохиолдов? • Цаасанд юу тохиолдов? • Тэдэнд бэрхшээл гарав уу? • Ямар боломж тэдэнд байсан бэ? 	Зохиолын аль хэсгийг цааш үргэлжлэх аргагүй болсон гэж үзэж байна?	Төгсгөл хэсгийг зохиолч хэрхэн зохиов? Хүү “Наддаа л алт!” гэж шивнэн хэлсний учир юу байв?
			Цаас халуун тогоо руу орох агшинд хүү “Байзаарай, байзаарай” гэж хашхирч байгаа нь зохиол цаашид өрнөх боломжгүй болж байгааг харуулж байна.	

Үзэл бодлоо илэрхийлэх

1. Цаасыг хэрхэн хийдэг бол?
2. Чи цаасыг дэмий, гамгүй хэрэглэдэг үү?
3. Цаасыг гамтай хэрэглэдэггүй хүүхдийн дутагдлыг яаж засах вэ? Бодлоо илэрхийлж бичээрэй.
4. Цаасыг заавал модноос гаргах нь зөв үү?
5. Модыг устгавал цэвэр агааргүй болж, гол мөрөн тэжээгддэггүй гэдэг. Гэтэл цаасыг модноос гаргадаг. Асуудал юунд байгааг багаараа хэлэлцээрэй.
6. Багаараа ярилцсанаа үнэлээрэй.

Өөрийн үнэлгээний шалгуур	Тийм	Үгүй	Заримдаа	Сайжруулах шаардлагатай
Ангийн хүүхдүүдийн ярьсныг анхааралтай, хүлээцтэй сонсдог.				
Багшийнхаа ярьж тайлбарлаж байгааг анхааралтай сонсдог.				
Багаараа ажиллахдаа өөрийнхөө хэр ярьж байгааг мэдэрч сонсдог.				
Зөв сонссон гэдгээ илэрхийлж сурсан.				
Өөрийнхөө саналыг нэмэрлэдэг.				



Ярих сонсох чадвараа хөгжүүлэе

Зохиолын гол санаа, дүрийн зан төрхийг ойлгож мэдэрснээр дүр бүтээж харуулах

Дүр бүтээхээсээ өмнө:

1. Зохиолыг дахин уншиж, тоглох зохиол болон дүрээ сонгох
2. Сонгосон дүрийнхээ үг хэл, бодол санаа, үйлдлийг төсөөлөх, тунгаан унших
3. Зохиолч энэ дүрээр уншигчдад юуг хэлэхийг хүсэж байгааг бодож унших
4. Ямар зан төрхтэй дүр билээ гэж бодож дүгнэх
5. Дүрийнхээ зан төрхөд тохируулан дуу хоолойныхоо өнгө, харц, дохио зангаа, биеийн хөдөлгөөн ямар байхыг төлөвлөж хэлэлцэх
6. Дүрийн зан төрхийг илэрхийлэхийн тулд үгээ цээжлэх, өөрийн болгох

Дүрд тоглохдоо:

1. Бусад дүрд өөрийгөө танилцуулж, өөрийн /дүрийн/ санаа бодлыг илэрхийлээрэй.
2. Өөртөө итгэлтэй байгаарай.
3. Үгээ тод хэлж, бусдын анхаарлыг таттал жүжиглэн дүрд тоглоорой.
4. Баатрын зан чанарт тохируулан дууны өнгийг өндөр, нам болгохыг анхаарна уу.
5. Нүүрний хувирал, нүдний харц хөдөлгөөнийг тохируулаарай.



Бичих чадвараа хөгжүүлэе

Мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичих

1. Энэ хичээлийн жилд уншсан зохиолуудаас хамгийн их таалагдсан зохиолоо сонгоно уу.
2. Юу бичихээ бодож төлөвлөөрэй. Сонгон ажиллана уу.

Мэдрэмжээ илэрхийлэхдээ хэрэглэх үг, найруулга	Сэтгэгдлээ илэрхийлэхдээ хэрэглэх үг, найруулга
Энэ зохиолоос мэдэрлээ. Зохиолыг уншихад ... дуу чимээ сонсогдох мэт санагдсан. Зохиолын ... тэр хэсгээс зүйл харагдсан. Яагаад гэвэл ингэж бичсэн учраас би гэж бодож байна. Зохиолд дүрслэгдсэн зүйлд гар хүрлээ гэж бодоход мэдрэмж төрөх байх гэж бодож байна.	Энэ зохиолыг сонгосны учир юу гэхээр тэр хэсгийг уншаад сэтгэл маш хөдөлсөн. Учир нь Зохиолыг уншаад догдолсон, хөөрч баярласан, эргэлзэж тээнэгэлзсэн, гунисан, талархсан, жигшсэн, өрөвдсөн гэх мэт сэтгэлийн олон өнгө аясаа илэрхийлэхдээ зохиолын үг хэллэгийг жишээ баримт болгон татаж болно.

3. Бичих зүйлээ ярьж хэлэлцээрэй.
4. Хэлэлцсэнээ бүдүүвчлэх, зураглах гэх мэтээр төлөвлөж болно.
5. Хэдэн цогцолборт багтааж бичихээ төлөвлөөд, байршуулаарай.
Эхлэл хэсэгт: Уншсан зохиолоо яагаад сонгосноо тайлбарлаж бичих
Гол хэсэгт: Зохиолыг уншаад ямар мэдрэмж, эсвэл ямар сэтгэгдэл төрснөө бичих
Төгсгөл хэсэгт: Бусдад энэ зохиолыг уншихыг санал болгосноо илэрхийлэх
6. Ноороглон бичиж эхлээрэй.
7. Бичсэний дараа бусдын бичсэнийг уншиж санаа авах, өөрийн бичсэнийг бусадтай хамтран хэлэлцээрэй.
8. Алдаагаа хянаж, засаарай.

ХЭРХЭН СУРСНАА ҮНЭЛЬЕ

Изобел Финн

МАШ ЗАЛХУУ ЦОХ

Энэ бол маш залхуу нэгэн цохны тухай үлгэр юм. Тэр өдөржин унтах дуртай. Бас шөнөжин унтана. Тиймээс яаж нисдэгийг залхуу тэр цох мэддэггүй байв. Залхуу цох нэгэн өдөр нөгөө л унтдагаараа унтахыг хүсчээ. Нэгэнт нисэж чадахгүй хойно өөр яах ч билээ дээ.

Гэнэт нэг сонин санаа төрөв гэнэ. Дэргэдүүрээ өнгөрч явсан имжний уутанд үсрээд орчих нь тэр. Имж дэгдэж явдаг юм болохоор цох яаж ч унтах билээ. Тэгтэл хажууд нь нэг бар явж байв. Цох агшин зуур нуруун дээр нь дүүлэн гарлаа. Бар байнга л “P-p-p!” гэж архирна. “Чих дөжрөм их чимээнд яаж унтах юм бэ?” гэж цох хашхирлаа. Ойролцоо нь тэгтэл нэгэн матар сэлж үзэгдэв. Сүүлэн дээр нь цовхорч гарлаа. Матар ямагт л сүүлээ шарвах тул унтах арга байсангүй. Тэгтэл нэг сармагчин мөчрөөс дүүжигнэн үзэгдэв. Толгой дээр нь тэпхийн буутал, нөгөөх нь үргэлж савлах тул унтах боломж байсангүй. Тэгтэл нэг баавгай цүл цүл шогшиж явлаа. Цох тэр дорхноо л чихэн дээр нь суув. Баавгай дандаа л чихээ маажих тул унтана гэдэг санасны гарз. Хартал нэг яст мэлхий аажуухан мөлхөж явна. Нуруун дээр нь буутал, нөгөөх нь тэр дороо л зүүрмэглээд өгөв. Хөөрхий минь тэр хөдлөхгүй нь сайхан ч дээрээс шарах нарыг яалтай билээ. Унтах ч арга алга. Тэгтэл уул шиг заан сүүдэрлэн өнгөрч явна. Мань цох хошууны нь үзүүрт амжаад буулгүй яахав. Эцэст нь цох “Өө, би дэгддэггүй, архирдаггүй, мааждаггүй, шарвадаггүй, дүүжигнэдэггүй, зүүрмэглэдэггүй нэгнийг оллоо” хэмээн олзуурхав. Тэгтэл заан “А-а-н-чу-у-у!” гээд маш хүчтэй найтааж орхив. Цох яасан гэнэ? Нисэж сурдаг байгаа! Одоо тэр залхуу биш, хаа хүссэн зүгтээ нисэн явах болов оо.

*(Дэлхийн хүүхдийн хүүрнэл зохиолын дээж, II боть, Эмхэтгэгч, орчуулагч
Ж.Дашдондог, УБ., 2009, 21 дүгээр тал)*

Унших чадварыг үнэлэх даалгавар

Багаараа хийж гүйцэтгэх дасгал

1. Баг бүр зохиолын утгыг тодруулан асуулт зохиогоорой. Жишээ нь,
Цох юу хийх дуртай вэ?
Түүний мэддэггүй зүйл юу байв? гээд үргэлжлүүлээрэй.
2. Зохиосон асуултаа бусад багт тавиад, дараах үнэлгээний хуудсыг хэрэглэн, бие биеэ үнэлээрэй.

Шалгуурууд	Тийм	Үгүй	Зассан хувилбар
Бусад багт тавьж байгаа та нарын зохиосон асуулт ойлгомжтой байсан уу?			
Багууд асуултад оновчтой хариулсан уу?			
Багийн гишүүд бүгд анхааралтай сонссон уу?			Шаардлагагүй
Багийн гишүүдэд хариулт өгөх хугацааг өгсөн үү?			Шаардлагагүй
Сэдэв, гол санааг тодруулсан асуулт тавьсан уу?			
Дүрийн зан төрхийг тодорхойлоход чиглэсэн асуулт зохиосон уу?			

ҮГИЙН ТАЙЛБАР

А

Адбиш - Үнэхээр, чухамхүү, ер бус, хосгүй, ижилгүй

Ажин түжин – Нам гүм, чимээ аниргүй

Ам ч хөдөлгөх юмгүй – Хоол хүнсгүй хоосон

Анаа – Бяцхан гэсэн утгатай, нутгийн аялгууны үг

Ангал - Хад, газар зэрэг хагаран ангайж гүнзгий ан цав гарсан хэсэг

Б

Баглуур - Уулын хормой бэлд болон говь цөлийн бор саарал хөрстэй нутагт ургадаг мал иддэггүй ургамал

Багсайх - Сагсайх, багсар болох

Бажууна - Говь нутагт ургадаг, урт үндэстэй, шар ногоон өнгийн дугариг хэлбэртэй өргөн навчтай олон наст ургамал.

Баянбүрд - Говь, цөлийн бүсэд орших үржил шимтэй хэсэг газар

Боргох - Нохой хүн, амьтныг явуулахгүй хоргоож хуцах

Будаан сум – Будаа адил олон ширхэгтэй сум

Бударгана - Шигүү бутлан ургадаг, бөөрөнхийвтөр, цулцгар, навчныхаа өвөрт үсэрхэг нахиатай, сөөглөг өвс ургамал

Г

Гоёо - Говь газар ургадаг, шүүслэг чихэрлэг амттай олон наст ургамал

Гол тасрах – Амь алдах, үхэх

Гунан үхэр - Гурван настай эр үхэр

Гэлмэх - Балмагдах; дэндүү сандрах

Д

Дөнөн үхэр - Дөрвөн настай эр үхэр

Е

Ес – Өвлийн ид хүйтэн байх хугацааг нэрлэх уламжлалт ойлголт. Ес нь есөн ес, нийт наян нэгэн хоногийг хамарна.

Ж

Жилдэм – Өвс ургамалгүй нүцгэн газар

Жинчид - Ердийн хөсгөөр алсад ачаа бараа тээж яваа хүмүүс

Жишэвчлэн харах - Нүднийхээ дээр гараа тулган барьж, гэрлийг халхлан сайн анзаарч, саравчлан харах

З

Заг - Говьд ургадаг, найлзуур нь шилмүүсний хэлбэртэй, буурцгийн дотоодод цагариг ногоон үртэй, яслэг хатуу нэг зүйл мод.

Загсгал - Говьд, ихэвчлэн уул, хадтай газар ургадаг бутлаг ургамал

Залтас - Хагадас мод

Золбин - Эзэнгүй нохой

Зүтгүү - Шамдангуй, махруу

И

Илүүр – Оёдол хийхдээ даавууг наах зэрэгт галд халааж хэрэглэдэг багаж

Ичээ - Ан амьтны орогнодог газар

М

Манивил - Машин асаахад хэрэглэдэг хүнд төмрөн зүйл

Н

Нухуур эвэр – Үзүүр нь нухуур мэт хэлбэртэй, богинохон, мөлгөр эвэр

О

Олойртох – Эмээлийн олмыг хэт чангалснаас болж оломны ороор морины хэвэл хэсгийг гэмтээж, улмаар тэр хэсэгт нь цагаан үс ургахыг олойртох гэнэ.

Оорцог хад - Зайдуу, сондгой, тусгаар орших хад асга

Орвонгоороо эргэх - Юу ч үлдэхгүй, үндсээрээ өөрчлөгдөх

Ө

Өег - Шим тэжээл сайтай, нүнжигтэй, чанарлаг, өег хоол (шим тэжээлтэй хоол)

Өл даах - Өлсөхийг тэсвэрлэх

С

Сааглах - Сарлаг хэлээ гаргаж, сүүлээ өргөн сүр үзүүлэх

Савга үс - Сарлагийн хэжлүүрийг дагаж ургасан урт үс

Сайр – Гол дагуух жижиг хайр чулуутай нам дор газар

Сар – Шувууны нэр

Сухай - Говь, зарим цөл газрын элс, марзлаг хөрстэй газар бут бутгаар ургадаг, ягаан цэцэгтэй, улаавтар мод

Сэрвэн хад - Сэрвэгэр сэртгэр хад, эрвийж сэрвийсэн хэлбэртэй тогтсон хад

Т

Таана - Хээр, говийн бүсэд ургадаг сонгины төрлийн олон наст ургамал

Толгод - Олон жижиг намхан гүвээ

Толих - Арьс, нэхийг толигор болгон тэлж тэнийлгэх

Тоорой - Говь газар ургадаг нэг зүйлийн мод

Төхөм - Хотгор, хонхор газар

Тургих- Хүн малын уруулаа доргиулан, хамраа турд хийн дуугаргах

Туужуу - Хог арилгах шүүр

Тэр гэхийн тэмдэггүй – Тийм гэж хэлэхийн аргагүй

У

Угалз - Говь цөлд тохиолддог, хүчтэй элсэн хуй, шороон шуурга

Угсуурга - Эмээлийн олом, жирэм, дөрөөний сур зэргийг эмээлийн модтой холбож уях нарийн сур

Улаан цөл - Бараг усгүй, ургамалгүй, хуурай уур амьсгалтай, зэлүүд нутаг

Ус цавчиж гаргадаг хулан – Говьд амьдардаг хулан хэмээх амьтан хөрсний ус ойрхон байгаа сайр газрыг туурайгаараа цавчин, малтаж ус гаргадаг. Цавчаал усаар нь зэрлэг ан амьтад, мал ундаалдаг.

Х

Хармаг – Сондуул гэдэг сөөг ургамлын үр, мойл мэт хэлбэртэй, хүн иддэг, нэгэн зүйл жимс ургах бут

Хатирах - Хатир явдлаар явах

Хахирган - Хахир хавар, хатуу ширүүн хавар цаг

Хивдэс - Хивэгч амьтны хивээд амнаасаа унагасан сэвс

Хорз - Нэрмэл архийг дахин нэрж гаргасан архи

Хойлог - Ургамал шавж зэргийг идэж амьдардаг гургуулын овгийн шувуу

Хотир тэсэг - Ургамал, бөөрөлзгөний өөр төрлийн нэр

Хохь хоосрох - Биеэс өөр юу ч үгүй, ядуу болох

Хөхөмдөг манан - Бага зэрэг хөх туяа татсан манан

Ц

Цаазлах - Дархан цаазтай амьтан буюу улаан номд орсон гэсэн утгаар хэрэглэгджээ.

Цав – Эмх замбараагүй тархсан толгод

Цайдам - Хөндий, уудам тал

Цонж хад - Эгц өндөр ханан хад

Цөнхрөг - Тэмээний хэвдсээ хадгалах эрхтэн

Цулхир - Навч нь хавтгай болоод шөвгөр, тэмээ идэх дуртай, хүнсэнд хэрэглэхэд тохиромжтой элстэй газар ургадаг нэг наст өвс

Цүнхээл - Гүнзгий хонхор газар тасарч тогтсон гүн устай нүх

Ч

Чивчаант цаг – Ээдрээтэй цаг хугацаа

Чигч - Шударга, үнэн

Ш

Ширэнгэ - Чигжүү ургасан мод сөөг, ой дотор нягт шигүү ургасан мод

Шоролзох - Шоргор, шовх үзүүртэй юмны байн байн хөдлөх хөдөлгөөн

Шуурган хөшиг - Хүчтэй салхи гарах

Э

Элсэн бороо - Элсээр шуурах

Эсэргэн цаг - Ирэх цаг, дараагийн гарах цаг

Я

Явуу - Хав загасны яс, чимэг зүүлт болгон хэрэглэнэ.